



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ОЮУНЫ
ӨМЧИЙН ГАЗАР



ШИНЖЛЭГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН
ДЭЭД СЭРГЭЭЛЭ

ОЮУНЫ ӨМЧ - ХӨГЖЛИЙН УНДАРГА, ХҮНИЙ ҮЛ ЗУВЧИГДАХ ЭРХ

(ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
БАГА ХУРЛЫН МАТЕРИАЛ)

2013 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 15

Редактор: Ч.Даваадам, Г.Амаржаргалан
Эмхэтгэсэн: Ё.Болормаа

Улаанбаатар хот
2013 он

DDC
015
O-634

**ОЮУНЫ ӨМЧ - ХӨГЖЛИЙН
УНДАРГА, ХҮНИЙ ҮЛ ЗУВЧИГДАХ ЭРХ**

Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал

Редактор: Ч.Даваадан, Г.Амарсаргалан
Эмхэтгэгч: Ё.Болормаа
Цаасны хэмжээ: 60х90/16
Хэвлэлийн хуудас: 12.125
Хэвлэсэн он: 2013 УБ
ISBN: 978-99962-2-891-9



"Соёмбо принтинг" ХХК-д
хэвлэв.

ГАРЧИГ

БАГА ХУРАЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ6
Ч.Давааданг Шинжлэлт ХЭДС-ийн дэд захирал, доктор (Ph.D), профессор

**ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН
БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДАГА**9
*Н.ЧИНБАТ Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч Агентлэг-Оюуны
өмчийн газрын дарга, гавьяат хуульч*

**ОЮУНЫ ӨМЧӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ХИЙХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ**21
*Г.АМАРЖАРГАЛАН Шинжлэлт ХЭДС-ийн салбар эрх зүйн тэнхимийн
эрхлэгч, ахлах багш*

**ДНХ-ЫН ПАТЕНТЖУУЛАЛТ: АНУ-ЫН ДЭЭД
ШҮҮХИЙН ӨНӨӨГИЙН ЖИШИГ БА БОДЛОГО** 37
*ЭРИК ЭНЛОУ БНСУ-ын Хангайн Олон Улсын хууль зүйн сургуулийн
декан, профессор*

**ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ОНОЛ,
ПРАКТИКИЙН АСУУДАЛ** 65
*Э.МЯГМАРДОРЖ Оюуны өмчийн газрын Аж үйлдвэрийн өмч, зохиогчийн
эрхийн хэлтсийн дарга*

**ОЮУНЫ ҮЙЛ АЖИЛАГААНЫ ҮР ДҮНД ХААДСАН
ХААДАГАД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДАГА,
ОЮУНЫ ҮЙЛ АЖИЛАГААНЫ ҮР ДҮНГ ХАМГААЛАХ
ТАЛААРХ ХАРИЦААГ ЗОХИЦУУЛЖ БҮЙ ОЛОН
УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ ҮНДЭСНИЙ
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖТОЙ УЯАДУУЛЖ
ӨГӨХ АСУУДАЛУУД** 72
*МИХАИЛ АЛЕКСАНДРОВИЧ СУТУРИН Эрхүүгийн Улсын Их
сургуулийн Хууль зүйн сургуулийн эрхүүгийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
хууль зүйн ухааны доктор /Ph.D/*

ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗАРИМ ТУЛГАМДСАН АСУУДАЛ	82
<i>Н.ТЭМҮҮЛЭН Оюуны өмчийн газрын аж гүйцэтгэлийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийн мэргэжилтэн</i>	
ЗОХИОГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН БУС ЭРХ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ	93
<i>Б.БАТБАЯР МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрх зүй, төрийн онол, түүхийн тэнхимийн судлаач, докторант</i>	
ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛЭМЖ БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО	104
<i>Д.ОТГОНТУЯА Шилххүтүг ХЭДС-ийн ахлах багш</i>	
АНУ ОЮУНЫ ӨМЧИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХЭРХЭН ТЭМЦЭЖ БҮЙ ТУХАЙ	117
<i>ДЭВИД КОЛЛЕР БНСУ-ын Хандуу Олон Улсын хууль зүйн сургуулийн Профессор</i>	
“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР ДАХЬ ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ”	130
<i>Ц.ЭНХГЭРЭЛ Цагаарийн Ерөнхий газрын хэв.тэл, мэдээллийн төвийн судлаач</i>	
ЦАХИМ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ	144
<i>П.ТҮВШИНГӨГС Шилххүтүг ХЭДС-ийн багш, докторант</i>	
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ	152
<i>О.ОЮУНГЭРЭЛ Оюуны өмчийн газрын аж гүйцэтгэлийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийн шинжээч</i>	
ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТ	154
<i>Т.МӨНХЖАРГАЛ Хууль зүйн ухааны доктор /Ph.D/, Профессор</i>	

**ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТЫГ
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ..... 161**

С.БАТБУЯН СЭЗДС-ийн ХУТ-ийн багш, докторант

Б.ДЭЛГЭРМАА СЭЗДС-ийн ХУТ-ийн багш, Дэд проф, докторант

БАРААНЫ ТЭМДГИЙН

ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦОО170

Б.ОЮУНЦЭЦЭН Оюуны Өмчийн Газрын аж гүйцэтгэлийн өмч, зохиогчийн эрхийн хэлтсийн олон улсын барааны тэмдгийн анхжээч

ОЮУНЫ ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ

ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДАЛУУД.....172

Д.ДЭЛГЭРЦОО Оюуны Өмчийн Газрын хяналтын хэлтсийн дарга

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ЗӨРЧСӨНӨӨС УЧИРСАН ГЭМ

ХОРЫГ АРИЛГАХ ЗАРИМ АСУУДАЛ..... 181

Ж.БЯМБАА Шихлэлтүг ХЭДС-ийн төр, эрх зүйн онол, түүхийн тэнхлэгийн эрхлэгч, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/, Профессор

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ОЮУНЫ ӨМЧИЙН
ГАЗАР БОЛОН ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН
ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛАЖ БУЙ “ОЮУНЫ
ӨМЧ-ХӨГЖЛИЙН УНДАРГА, ХҮНИЙ ҮЛ
ЗУВЧИГДАХ ЭРХ” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ НЭЭЖ
ШИХИХУТУГ ХЗДС-ИЙН ДЭД ЗАХИРАЛ,
ДОКТОР(РЬ.Д), ПРОФЕССОР Ч.ДАВААДАШИЙН
ХЭЛСЭН ҮГ**

Эрхэм хүндэт эрдэмтэн профессор, багш нар, эрдэмд шамдсан оюутан залуус аа!

Энд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, төлөөлөгчид өө!

Та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Өнөөдөр Шихихутуг Хууль зүйн дээд сургууль жил бүр уламжлал болгон хийдэг олон улсын эрдэм шинжилгээний бага хурлаа Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч Агентлаг-Оюуны өмчийн газартай хамтран зохион байгуулж байна.

“Оюуны өмч-хөгжлийн ундарга, хүний үл зувчигдах эрх” гэсэн сэдвээр хийж буй өнөөдрийн эрдэм шинжилгээний бага хурал маань улс орны хөгжлийн өнөөгийн амин чухал шаардлага, хүн төрөлхтний эрин зууны дуудлагад яв цав нийцсэн, цаг үеэ олсон арга хэмжээ болж байна.

Одоогоос бараг 600 жилийн тэртээ Английн их сэтгэгч Фрэнсис Бэконы “Мэдлэг бол хүч” хэмээн тунхаглаж, шинжлэх ухааны өөрчлөгч агуу хүчийг хүн төрөлхтөнд зарлан өртөөлсөн гайхамшигтай тэр суут санаа өнөөдөр манай гариг дээр жинхэнэ амьд биеллээ олж буйг бид бүхэн бэлхнээ харж, мэдэрч байна.

Мэдээллийн эрин зууны гайхамшиг, мэдлэгт тулгуурласан нийгмийн үсрэнгүй хөгжил эдүгээ хүний оюун ухаан, мэдлэгийн оргил нь болж байна.

Энэ цаг үе дор хүн бүр чөлөөтэй сэтгэж, чөлөөтэй туурвих эрх нь нээлттэй болсон манай орны хувьд оюуны хөдөлмөрийн үнэлэмжийг эрс дээшлүүлж, оюуны бүтээлд хандах нийгмийн хандлагыг үндсээр нь өөрчилж, оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг улам дархлаатай болгох нь оюунилаг удмын их сангтай, авъяаслаг сэргэлэн ард олныхоо бүтээл туурвил, нэг үгээр, соёл иргэншлийнх нь агуу их хүчийг өдөөн бадрааж, өөгшүүлэн дэмжиж, хайрлан хамгаалах нэн чухал нөхцөл, Монгол орноо дэлхийн дайд хүргэн хөгжүүлэх гол эх сурвалж билээ.

Чухамхүү Монголын нийгмийн өөрт нь байгаа энэ "дотоод шаталтын хөдөлгүүр"-ийг, өөрөөр хэлбэл, дотоод их эрч хүчийг жинхэнэ ёсоор оргилуулж, буцалгаж өгөх явдал өнөөгийн бид бүхний гол зорилт мөн. Хүн ард маань ч өөрийн энэ дуусанггүй, дундаршгүй бүтээлч үйлмийнхээ үр шимийг зохих ёсоор хүртэж, үнэ цэнийг жинхэнэ утгаар нь мэдэрч, тууштай хамгаалж чаддаг, төр засаг нь иргэдийнхээ энэ бололцоог, энэ эрхийг нь бүх талаар хангаж өгөх явдал нэн чухал юм. Энэ утгаараа оюуны өмч гэдэг бол улс орны болоод тухайн хүний өөрийн нь хөгжлийн ундарга болоод зогсохгүй, хүний үл зувчигдах чухамхүү тэр дархан эрх яах аргагүй мөн билээ. Энэ эрхэм үйлст оюуны өмчийн бодлогыг гардан хариуцдаг Монгол Улсын Оюуны өмчийн газар, эрх зүйн сургалт, судалгааг дагнан явуулдаг Шинихутуг ХЗДС хоёр хамтран цаг үеэ олсон нийм чухал сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж байгаа нь нэг талаас оюуны өмчийн онол, практикийн асуудлыг тал бүрээс нь шинжлэх ухааны үндэстэй авч үзэж, оновчтой шийдвэрлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх арга замыг боловсруулах, нөгөө талаас оюуны өмчид хандах хандлагыг эрс өөрчлөх, түүний хамгаалалтын дархлааг хууль зүйн бат бааз суурьтай болгоход жингтэй хувь нэмэр оруулма гэдэгт итгэлтэй байна.

Энэ хүрээнд бидэнд олон улсын туршлага, сургамж ч чухал билээ.

Өнөөдрийн бага хурлын ажиллагаанд манай хөрш сургуулиуд болох БНСУ-ын Хандуны Их сургууль, ОХУ-ын Эрхүүгийн

Улсын Их сургуулийн төлөөлөгчид оролцож байгааг баяртайгаар уламжлалай.

Манай хуралд хурлыг зохион байгуулагчдаас гадна МУИС, СЭЗДС, ЦЕГ-ийн төлөөлөгчид, эрдэмтэн профессор багш нар оролцон илтгэл тавьж байна.

Ингээд Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг-Оюуны өмчийн газар, Шихихутуг ХЗДС-ийн хамтран зохион байгуулж буй "Оюуны өмч-хөгжлийн ундарга, хүний үл зувчигдах эрх" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье.

Хурлын ажиллагаанд амжилт хүсье.

Н.ЧИНБАТ

Монгол Улсын Засгийн Газрын хэрэгжүүлэгч Агентлэл-Оюуны
өмчийн газрын дарга, гавьяат зүүдч

ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ИРЭЭДҮЙН ЧИГ ХАНДЛАГА

Дэлхий дахинаараа глобалчлагдаж байгаа өнөө үед оюуны өмчийн хамгаалалт, тогтолцооны ач холбогдол улам бүр өсөн нэмэгдсээр байна. Оюуны өмчийн үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцооны үр шим хүн бүрт үр ашгаа өгдөг. Техник технологийн өнөөгийн хөгжлийн түвшин нь оюуны өмчийн хамгаалалтын үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцооны гол үр дүн болсныг харуу... байна. Оюуны өмчийн ойлголт анх манай эриний арван зургаа дугаар зуунд бий болсноос хойш хүн төрөлхтөний хөгжлийн өнөө хүртэлх хугацаанд оюуны өмчийн хамгаалалтын түвшин улам бүр боловсронгуй болж, хөгжсөөр ирсэн.

Монгол улс 1990-ээд оноос ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэнээс эхлэн оюуны өмчийн хамгаалалт жинхэнэ утгаар хөгжих болсон. Энэ үеэс өмнө оюуны өмч төрлийн өмч байж, зохиогч эд хөрөнгийн бус эрх болон шагнал авах эрх эдэлдэг байсан юм.

Манай оронд оюуны өмч гэсэн нэр томъёо зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн үеэс эхлэн хууль зүйн шинжлэх ухаанд орж ирж хууль тогтоомжид тусгагдах болсон билээ. 1990-ээд оноос өмнө шинэ бүтээл, оновчтой санал, зохиогчийн эрх, барааны тэмдэг, гарлын газрын заалт гэсэн нэр томъёо, ойлголт байсан боловч энэ нь оюуны өмчийн жинхэнэ утгыг агуулдаггүй, зөвхөн шинэ санаачлагыг дэмжин урамшуулах зорилгоор шинэ зүйл санаачлагч, бүтээгчдэд шагнал олгох төдийгөөр хязгаарлагддаг байсан.

Орчин үеийн иргэний эрх зүйн шинжлэх ухаанд өмчийг хөдлөх, үл хөдлөх, оюуны өмч гэсэн 3 төрөлд ангилж авч үзэх

болсон. Цаад утгаараа оюуны өмч гэдэгт шинэ зүйл бүтээгчийн тухайн бүтээж бий болсон зүйл дэх өмчлөх эрхийг ойлгодог.

Оюуны өмч гэсэн ойлголтод багтах объектын талаар Монгол улс 1979 онд гишүүнээр нь элссэн Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагыг байгуулах тухай конвенцид заасан нь олон улсын түвшинд хамгийн анхны удаа оюуны өмчийн агуулгыг тодорхойлсон чухал заалт болсон юм. Уг конвенцийн 2 (VIII) зүйлд "Оюуны өмч нь,

[1] шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээл

[2] уран бүтээлчдийн тоглолт, дуу авианы бичлэг, шугамаар нэвтрүүлэх

[3] хүний хэрэгцээний бүх салбар дахь шинэ бүтээл

[4] шинжлэх ухааны нээлт

[5] бүтээгдэхүүний загвар

[6] барааны тэмдэг, үйлчилгээний тэмдэг, худалдааны нэр, нлэрхийлэл

[7] шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах болон үйлдвэрлэл, шинжлэх ухаан, уран зохиол, уран сайхны салбарт оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон бусад зүйлд хамаарах эрхийн агуулга." гэж заажээ. [1]-д заасан нь оюуны өмчийн зохиогчийн эрхийн салбарт, [2]-т заасан нь хамаарах эрхэд, [3], [5], [6]-д заасан зүйлүүд нь оюуны өмчийн аж үйлдвэрийн өмчийн салбарыг бүрдүүлж байгаа бөгөөд [7]-д заасныг аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцид тодорхойлсноор мөн аж үйлдвэрийн өмчийн объектод хамааруулжээ. Оюуны өмчийн ойлголт шинжлэх ухаан, техник улам хөгжихийн хирээр улам өргөжиж түүнд хамаарах объект улам олон болсоор байна. Тухайлбал: бичил бүдүүвчийн байршил загвар, компьютерийн программ, бизнесийн нууц гэх мэт. Сүүлийн үед ДООБ-аас уламжлалт мэдлэг, хүний генетик хүчин зүйл, ардын урлагийг хамгаалах талаар нэлээд оролдлого хийж эхлээд байна.

Орчин үеийн "оюуны өмч" гэсэн нэр томъёо нь XVIII зууны сүүлч, XX зууны эхэн үеэс бий болсон оюуны өмчийн онолтой нягт холбоотой бөгөөд тэдгээр эрхийн хууль зүйн шинж байдал нь

ямар нэг эргэлзээ төрүүлдэггүй тул ямар нэг бодит хор уршиггүй юм. Ийм учраас "оюуны өмч" гэсэн нэр томъёог хууль тогтоомж болоод хууль зүйн шинжлэх ухаанд хэрэглэх нь сөрөг үр дагавар байхгүй гэж үзэж болно. Оюуны өмч нь үнэлэгдэх боломжтой зүйл бөгөөд, өмчлөлийн шинжгүй бол үнэлэгдэх байдлаа алддаг. Оюуны өмч нь хүний оюун бодол, ухаан санааны өмчлөлийг илэрхийлдэг. Аж ахуйн томъёоллоор энэ нь өмчлөгдөх мэдлэг юм. Оюуны өмч гэдгийг өргөн утгаар нь авч үзвэл үйлдвэрлэл, шинжлэх ухаан технологи, уран зохиол, хөгжмийн жүжгийн салбарт шинэ зүйл бүтээгчийн эрх мөн.

Энэ нь цогцолбор зүйл байх ба хэрвээ оюуны авьяас чадвар мэдлэгээ хөгжүүлэхээс өмнө оюуны өмчөө нийтэд дэлгэвэл, оюуны өмчийн эрхээ алдах ба оюуны бүтээлч хөдөлмөрийн ач холбогдол байхгүй болох юм. Шинэ зүйл сэдэх тухайгаа өөр хэн нэгэнт хэлэх, патентлагдаагүй бүтээгдэхүүнээ худалдчихвал өрсөлдөгчид тэдгээрийг чөлөөтэй ашиглах боломжтой болно. Энэ нь тухайн бүтээгдэхүүн нийтэд дэлгэрсэн учир шинэ байж чадахгүй тул патентаар хамгаалагдах боломжгүй болно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, уг шинэ зүйлийг хуулбарлахаас хамгаалж чадахгүй гэсэн үг юм.

Хүн өөрийн оюун ухаанд бодож сэтгэж байгаа, биеллээ олоогүй зүйл бол оюуны өмч болж чадахгүй. Ой ухаандаа бодож сэтгэснийг гаргаж ямар нэг бодит зүйл хийсэн тохиолдолд оюуны өмчийн объект болдог. Оюуны өмч нь үргэлж хөдөлгөөнтэй байж, хөгжиж, улам боловсронгуй болж байдаг онцлог объект юм. Технологийн зах зээл нь оюуны өмчийн эрхийн хөгжлийн гол хөдөлгүүр болдог ба эдгээр эрх нь өргөжиж өөрчлөгдөж байна (кино үйлдвэрлэгчдийн эдийн бус баялгийн эрх, дуу авиаг барааны тэмдгээр бүртгэх, бичил бүдүүвчийн хамгаалалт, ургамлын төрөл зүйл).

Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйл:

"Иргэний туурвисан оюуны үнэт зүйл зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн" гэж заасан ажээ. Мөн Монгол улсын иргэн шинжлэх ухаан урлаг бүтээл туурвих үр

шимийг нь хүртэх эрхтэй гэж заасан. Энэ нь Монгол улс дахь оюуны өмчийн эрх зүйн үндсэн эх сурвалж болж өгсөн юм. Иргэний эрх зүйн нэг гол салбар болох оюуны өмчийн эрх зүйгээр шинжлэх ухаан, техник, технологи, урлаг, уран сайхны бүтээлтэй холбогдон үүсэх нийгмийн харилцааг зохицуулдаг.

Оюуны өмчийн хамгаалалт тогтоох зорилго нь зохиогч, шинийг санаачлагчдыг дэмжих, ингэснээр шинэ зүйл бүтээх сонирхлыг нэмэгдүүлэх, нийгмийн хөгжлийн хурдцыг түргэсгэн шинжлэх ухаан техникийн хөгжилтийг хангах явдал байдаг. Ийм учраас оюуны өмчийг хамгаалах системийг тогтоож, боловсронгуй болгох явдал тухайн улс орны хөгжилтөд бодитой хувь нэмэр оруулах хүчин зүйл болдог. Энэ утгаараа эрхийн хамгаалалт хийлгэхийн ач холбогдол, зах зээлийн эдийн засгийн үед шударгаар өрсөлдөх, оюуны өмчийн эрх эзэмшигчид хууль тогтоомжоор онцгой эрх олгох, эрх эзэмшигчид эрхээ хамгаалуулах ба хуулиар олгосон боломжийг ашиглах, оюуны өмчийн эрх эзэмшигчид хуулиар олгосон эрхийг гурав дахь этгээд зөрчихөөс сэргийлэх зэрэг болон бусад олон асуудлыг ард иргэд, их дээд сургуулийн оюутнууд, багш нар, шинийг санаачлагч, зохион бүтээгчид, зохиогчид ойлгож мэдэх шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа юм.

Орчин үеийн оюуны өмчийн хөгжлийг үндсэн гурван чиглэлээр авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

1. Аж үйлдвэрийн өмчийн хөгжил: үүнд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт, уламжлалт мэдлэг, генетикийн нөөц
 2. Зохиогчийн эрхийн хамгаалтын хөгжил
 3. Оюуны өмчийн хөгжлийн стратеги, бодлогын түвшинд хамаарах хөгжил
1. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын хувьд мэдүүлэг бүрдүүлэх, хайлт шүүлт хийх, шийдвэр гаргах үйл явцыг бүрэн автоматжуулах, патентын байгууллагууд мэдээллээ аль болох түргэн солилцох, мэдүүлгийг онлайн гаргах боломжийг нэмэгдүүлэх, улс орнууд патентын хайлт шүүлтний тайланг шууд хүлээн авах тогтолцоонд нэгдэн

орох, үндсэндээ патентын хамгаалалт улам бүр олон орныг хамгаалах нэгдсэн системд шилжиж байна.

Патентын хамтын ажиллагааны дагуу патентын эрхийн хамгаалалтыг улам бүр боловсронгуй болгох, олон талын болон хоёр талын гэрээгээр патентын хайлт шүүлтний тайланг харилцан хүлээн зөвшөөрснөөр эрхийн хамгаалалт хийх хугацааг аль болох богиносгох үйл ажиллагаанд улс орнууд улам бүр нэгдэж байна.

Patent Prosecution Highway Pilot (PCT-PPH) буюу патентын хайлтын хурдавчилсан замд улс орнууд хоёр талт гэрээ байгуулан орох үйл явц хурдацтай хөгжиж байна. АНУ гэхэд Австри, Австрали, Канад, Хятад, Европын Патентын газар, Испани, Финлянд, Израэль, Япон, БНСУ, ОХУ, Швед, Норвеги зэрэг улс орнуудтай PPH гэрээ байгуулан ажиллаж байна. Патентын эрхийн хамгаалалтын орчин үеийн хөгжил, хэтийн хандлагын дагуу "world patent" дэлхий дахины патент бий болох цаг хугацаа улам бүр ойр болжээ.

Бүтээгдэхүүний загварын онцлог бол богино хугацаанд олон янзаар өөрчлөгддөг учраас хамгаалалтын хугацааг богиносгох, шүүлтний системд шилжих чиг хандлага руу явж байгаа бөгөөд Бүтээгдэхүүний загварын хадгалалт, хамгаалалтын тухай олон улсын Гаагийн хэлэлцээрийг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

Барааны тэмдэг бол зах зээлд хэрэглэгчээ татах, нэр хүндтэй болох, шударгаар өрсөлдөх, брэнд болоход чухал нөлөө үзүүлдэг үндсэн хэрэгсэл тул ялгагдах шинжээ хадгалсан, уншиж, дуудах, тогтооход хялбар, эргэлзээ төрүүлэхүйц шинжгүй байх ёстой байдаг. Олон улсын худалдаа улам бүр глобальчлагдаж байгаа өнөө үед барааны тэмдгийн бүртгэл өдрөөс өдөрт нэмэгдэж, олон улсыг хамрах шинжтэй болж байна. Тийм учраас барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тогтолцоог автоматжуулах, боловсронгуй болгох шаардлагын үүднээс Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын хэлэлцээр, Протокол болон Барааны тэмдгийн олон улсын ангиллын Ниццийн хэлэлцээр, Барааны тэмдгийн дүрсийн олон улсын ангиллын

Венийн хэлэлцээрийг дахин авч үзэх асуудлаар Дэлхийн Оюуны өмчийн Байгууллагын гишүүн орнууд хэлэлцэж байна. Түүнчлэн дуу авиа, мультмедиа, гурван хэмжээст, голограм тэмдэг гэх мэт онцлог барааны тэмдгийн цахим удирдлагын асуудлыг авч үзэхийн зэрэгцээ барааны тэмдгийн шүүлтнийг боловсронгуй болгох, цахимжуулах, шүүлтний тайлангийн үр дүнг улам илүү үр дүнтэй болгоход улс орнууд анхаарч ажиллаж байна.

Газар зүйн заалтын хувьд олон улсын хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох үүднээс Дэлхийн Худалдааны Байгууллагын Худалдаан дахь оюуны өмчийн эрхийн асуудлаарх хэлэлцээр болон Гарлын газрын нэр, түүний олон улсын бүртгэлийн тухай Лисбоны гэрээг хянан үзэж байна. Улс орнууд газар зүйн заалтыг буруу тодорхойлохоос хэрэглэгчдийг хамгаалахын тулд өөрийн орны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоос гадна олон улсын шинж чанартай үр дүнтэй хамгаалалтыг бий болгохын төлөө хамтран ажиллаж байгаа юм.

Уламжлалт мэдлэг, генетикийн нөөц нь зарим тохиолдолд газар зүйн заалттай ч холбоотой юм. Нэн буурай болон, хөгжиж байгаа улс орнуудын хувьд уламжлалт мэдлэг, генетикийн нөөц шавхагдашгүй баялаг тул үүнийг ашиглах тохиолдолд зөвшөөрөл авдаг, төлбөр төлдөг журмыг бий болгох шаардлага урган гарч байгаа болно. ДООБ-аас уламжлалт мэдлэг, генетикийн нөөцийн хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын гэрээгээр хамгаалах эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Олон улсын ажлын хэсгийг байгуулсан бөгөөд хэд хэдэн чухал баримт бичгийг гаргасан юм. Үүндээ уламжлалт мэдлэг гэж юуг ойлгох, хэрхэн хамгаалах талаарх мэдээллийг агуулсан байна.

2. Зохиогчийн эрхийн салбарын өнөөгийн хөгжлийг техник технологийн өнөөдрийн түвшинтэй холбож авч үзэхээс өөр аргагүй.

Зохиогчийн эрхийн хамгаалалт нь үйлдвэржилт хөгжсөн, хэвлэх машины үйлдвэрлэл үүсч бий болсон цаг хугацаатай хамааралтай үүссэн гэдэг утгаараа ямагт техник технологийн хөгжилтэй холбоотой байдаг.

Техник технологийн үсрэнгүй хөгжсөн орчин үед зохиогчийн эрхийн бүтээлийг хуулбарлах, хууль бусаар ашиглах явдал улам бүр хяналтгүй болж байна.

Цахим орчинд зохиогчийн эрхийг үр дүнтэй хамгаалах явдал аль ч улс орны хувьд тулгамдсан асуудал юм.

Ийм учраас дэлхий дахинаа олон улсын гэрээгээр зохиогчийн эрхийг цахим орчинд хамгаалах, хууль бус ашиглалттай улс орон бүр үр дүнтэй аргаар тэмцэх, хамтын удирдлагын байгууллагын тогтолцоог улам бүр хөгжүүлэх, цахим орчинд эрхийн мэдээллийн удирдлагыг бий болгох асуудалд анхаарлаа илүү хандуулж байна.

Зохиогчийн эрхийн хамгаалалтыг улам бүр хүчтэй болгохын зэрэгцээ олон нийтийн эрх ашгийг нэг талаас хамгаалах зорилгын үүднээс зохиогчийн эрхийн хамгаалалтаас хасах зохицуулалтыг ч мөн авч үзэж байна.

Харааны бэрхшээлтэй, хэвлэмэл материалыг унших чадвар сул хүмүүст зориулж зохиогчийн эрхийн хамгаалалтаас чөлөөлөх тухай Марракешийн гэрээг 2013, Тоглогчийн эрхийг хамгаалах тухай Бээжингийн гэрээг 2012 онд тус тус байгуулсан нь зохиогчийн эрхийг өнөөгийн хөгжлийн түвшинг тодорхойлж байгаа юм.

Зохиогчийн эрхээ хэрэгжүүлэх дэлхий дахинаа шалгарсан хамгийн үр дүнтэй систем болох хамтын удирдлагын тогтолцоог улам бүр хөгжүүлэх шаардлага улам бүр бий болсоор байна. Зохиогчийн эрхийн бүтээл ашиглах зөвшөөрөл олгодог, зөвшөөрлийн үндсэн дээр бүтээл ашигласны төлөө төлбөр авдаг, хураасан төлбөрийг гишүүддээ хуваарилах үндсэн үүрэг бүхий ашгийн төлөө бус хамтын удирдлагын байгууллага нь нэг талаас зохиогчид өөрсдийн эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэлбэр болж байгаа төдийгүй, бүтээл ашиглагч нарт олон зохиолч, уран бүтээлчтэй нэг бүрчлэн гэрээ хийх шаардлагагүй хамтын удирдлагын байгууллагаар дамжуулан гэрээ байгуулж байгаагаараа хөрөнгө мөнгө, цаг хугацаа, хүний нөөцийн зардал хэмнэдэг олон давуу талтай байдаг.

Улс орнуудын хамтын удирдлагын байгууллагууд өөр хоорондоо хамтран ажиллах гэрээ байгуулснаар зохиогчийн эрхийг харилцан хамгаалах өргөн боломжийг бий болгож байгаа юм.

3. Оюуны өмчийг хамгаалах нь улс орны хөгжил дэвшилд чухал нөлөө үзүүлдэг тул нэн буурай хөгжилтэй болон хөгжиж байгаа улс орнууд оюуны өмчийн үр дүнтэй, хүртээмжтэй тогтолцоог бий болгоход анхаарч байна. Оюуны өмчийг хөгжүүлэхийн тулд улс орнууд оюуны өмчийн үндэсний стратегийг бий болгох шаардлагатай юм. Оюуны өмчийн хөгжлийн үндэсний стратеги нь тэргүүлэх чиглэлийн салбарыг тодорхойлж, оюуны өмчийн дэд бүтцийг бий болгох, патентын мэдээллийг оновчтой ашиглах, патентыг үр дүнтэй ашиглах, зах зээлд нэвтрүүлэх, патентын эрхийн хамгаалаалтын үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй болгох, оюуны өмчийн үнэлгээг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, улмаар улс орны эдийн засгийн хөгжилд тухац болгоход чиглэгдсэн бодлогын баримт бичиг байх ёстой. Оюуны өмчийн үндэсний стратегийг батлан хэрэгжүүлснээр улс орон богино хугацаанд түргэн хөгжсөн улс орнуудын жишээнд Сингапур, Япон, БНСУ, БНХАУ-уудыг нэрлэж болно. Сүүлийн жилүүдэд Хятад улсын оюуны өмчийн хөгжил дэлхий дахинаа үлгэр жишээ болж байна.

Оюуны өмчийн үндэсний стратегид заавал авч үзэх ёстой асуудлын нэг бол оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах явдал мөн. Оюуны өмчийг хамгаалахад төрийн гүйцэтгэх гол хоёр үүрэг бол оюуны өмчийн эрхийн хамгаалаалтын бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчинг бий болгох, оюуны өмчийн эрх нь зөрчигдсөн үед хүлээлгэх хууль зүйн албадлагын арга хэмжээний тогтолцоог бий болгох явдал юм.

Монгол Улсын хувьд аж үйлдвэрийн өмчийн эрхийн хамгаалаалтыг бүрэн автоматжуулж хайлт шүүлтгийг хийх, тайлан гаргах, батлах, патент, гэрчилгээ гаргах үйл ажиллагааг бүрэн цахимжуулсан бөгөөд патентын эрхийн хамгаалаалтын дэлхий дахины чиг хандлагын дагуу хөгжүүлэхээр ажиллаж байна. Үүний

хамт дэлхий дахины чиг хандлагад нийцүүлэн Патентын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгохоор ажиллаж байгаа юм.

Үүнд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашинтай загвараар хамгаалагдах зүйлийн талаарх ойлголтыг нарийвчлах, эрхийн хамгаалалтын үйл явцыг боловсронгуй болгох, хяналтын тогтолцоог хөгжүүлэх, хариуцлагын шинэ, хэрэгцээ хангасан хэлбэрийг бий болгох, патентын нэвтрэлт, үнэмлээний асуудлыг тодорхойлох шаардлага урган гарч байна.

Зохиогчийн эрхийн салбарт эрхийн удирдлагын мэдээллийг бий болгох, нэвтрүүлэх, хамтын удирдлагын тогтолцоог улам бүр хөгжүүлэх, зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэйгээр бүтээл ашиглах ухамсар, ёс зүйг төлөвшүүлэх, үнэлэмжийг нэмэгдүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зохиогчийн эрхийн зөвшөөрөлгүйгээр хувийн зорилгоор ашиглах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, тоглогч, уран бүтээлчийн эрхийг илүү тодорхой болгох, дижитал орчин дахь зохиогчийн эрхийн хамгаалалтыг тогтолцоог хөгжүүлэх, интернетийн орчинд зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрхийн зөрчилтэй тэмцэх чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Уламжлалт мэдлэгийг хамгаалах зорилгоор Уламжлалт мэдлэгийн тухай хуулийн төслийг боловсруулан санал авах шатанд явж байгаа төдийгүй энэ талаарх олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр олон ажлуудыг зохион байгуулж байгаа юм.

Оюуны өмчийн үндэсний стратегийг батлах шаардлагын үүднээс ДООБ-ын дэмжлэгтэйгээр стратегийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлсэн.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалт өнөөгийн байдал нь хөгжлийн ирээдүйн чиг хандлагыг тодорхойлж байдаг учраас оюуны өмчийн хамгаалалтын үр дүнтэй хүртээмжтэй тогтолцоог бий болгоход Монгол Улсын Оюуны өмчийн газар улам бүр анхаарах болно.

N.Chinbat

Honorary lawyer of Mongolia

Head, Intellectual property Agency

CURRENT SITUATION OF INTELLECTUAL PROPERTY PROTECTION AND FUTURE TRENDS

Current era of globalization, the importance of intellectual property protection and the whole system is increasing more. The efficiency of positive system of intellectual property system will probably distribute to everyone. Current level of technology development proves the result of efficient and profitable system of intellectual property protection.

Since the time of transferring into market economy and democracy in 1990s, the protection of intellectual property has been developing in Mongolia in its' real meaning.

For the objects included in intellectual property, the list by the international convention for founding World Intellectual Property Organization in 1979 in which Mongolia joined as a member became as a first important statement that determining the content of intellectual property.

Intellectual property is the specific object that is always moving, developing and getting sophisticated. Technology market plays the key role for the development of intellectual property and rights related to it are changing and expanding their frames.

The aim of the intellectual property protection is in supporting authors and creators and so in increasing the interest of making new creations, fastening the social development speed and in providing the development of science and technology. Therefore, the issue related to forming and sophisticating the system for intellectual property protection plays as a real factor that distributes for a country's development.

Modern intellectual property development is suggested to be divided into three main directions as:

1. Development of industrial properties: it includes new creations, design of a product, profitable designs, trademark, geographical signs, traditional knowledge, genetics resource
2. Development of copyright protection
3. Development of intellectual property referred to strategy and policy level

In accordance with the modern development and future trends of patent right protection, the time of being created "world patent" is coming soon.

During the modern time of rapid development of the technology, the duplication and illegal use of copyright is over-controlled and unlimited.

It requires more to develop the co-management system that is most-selected way of protecting copyright in the world.

By concluding cooperation agreement between co-management organizations in country, it gives wide opportunity for protecting copyright mutually.

In order to developing intellectual property, countries in the world are required to create a national strategy for protecting intellectual property.

One of the mandatory issues in a national strategy of intellectual property is related to providing the implementation of copyright of intellectual property.

For Mongolia, the copyright protection of industrial properties as searching, making reports, approving, issuing patent and certificates have been protected completely and is aimed to develop the patent right protection in conformity with global trend. As well as, we aim to sophisticate the laws and regulations on patent in accordance with world trend.

Our goal is on creating and introducing copyright management information, to develop co-management system more, to form behavior and ethics of using copyright according to permissions, increasing ratings, sophisticating the legal regulations for allowing the disabled to use the copyrights without permission for their private use,

making the rights of performers and artists more clearly, developing the copyright protection system in a digital area, protecting the copyrights in internet area, sophisticating the legal regulations in the frame of fighting against the violations of copyright and focusing to implement these issues.

For the purpose of protecting traditional knowledge, the bill of law on traditional knowledge is on the stage of developing and voting and as well as some events is organized for expanding the public knowledge on this purpose.

Because off the current situation of intellectual property protection determines the future development, the Intellectual Property Agency, Mongolia will put more attention on creating the efficient system of intellectual property protection.

Г.АМАРЖАРГАЛАН

*Шинжлэхтүг ХЗДС-ийн салбар эрх зүйн
тэнхимийн эрхлэгч, ахлах багш*

ОЮУНЫ ӨМЧӨӨР ХӨРӨНГӨ ОРУУЛААТ ХИЙХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛААЛТЫН ОНЦЛОГ

*Томдсон малтай тээр болж
Багадсан малтай толгой дааруулна*

“Оюуны өмч”, “Хөрөнгө оруулалт” гэсэн нэр томъёо нь эрх зүйн хувьд холбогдохдоо тэдгээрийн эдийн засгийн мөн чанарт тулгуурлан зүй зохистойгоор нэгдэн орших нь зүйн хэрэг. Асуудлын чухалыг “Оюуны өмчийн эрхэд тулгуурласан хөрөнгө оруулалтын аргын асуудал уу?”, аль эсвэл “Хөрөнгө оруулалтын мөн чанарт суурилсан оюуны өмчийн эрхийн асуудал уу?” гэдгийг ялган зааглахад чиглүүлсэнгүйг дурдан хэлье.

Оюуны өмчийн эрхэд тухайн эрхээр хөрөнгө оруулалт хийх эрх хамаардаг эсэх.

Оюуны бүтээлийг хүний оюун ухаанаараа бүтээсэн аливаа үр дүн гэж үзвэл түүнтэй холбоотойгоор үүсэн бий болох бүхий л боломжийг оюуны өмч гэж үзэж болох юм. Өмч, хөрөнгөд хандах эдийн засгийн хандлага нь түүнийг капитал болох талаас нь үнэлж, түүнийг тодорхойлогч нь эдийн засгийн өгөөж өгөх боломж гэж үздэг. Угтаа ямар ч өмчлөлийн зүйл энэ шинжийг хадгалж байж өмч болох юм. Оюуны өмч ч нэгэн адил.

Өмчлөх эрхийн агуулгад хамаарах “эзэмших”, “ашиглах”, “захиран зарцуулах”, “хамгаалах” эрхүүдийг эрх зүйн хэм хэмжээнээс олж харах боловч А.Смитээс Эриандо дэ Сотог хүртэлх эдийн засагчдын хамгаалдаг “капиталын” мөн чанар нь энэхүү өмчлөх эрхийн тухайд бус өмчлөх эрхийг эдлэх эрхэд анхаарал хандуулсаныг орхиндуулж болохгүй юм.

Толгой байдаг учраас малгай өмсдөгийн нэгэн адилаар хуулиар зохицуулах харилцаа нь өмчийн эдийн засгийн хязгааргүй эрх учир энэ эрхийг эдлэх боломжийг хаалгүйгээр малгайг өмсгөх хэрэгтэй болж байна. Угтаа энэ нь өмчийн харилцааг зохицуулж буй хуулийн тухай биш зохицуулах хуулийн тухай асуудал юм. Синдикат төслийн захирал Андрей Рапазанскийн хэлсэн үгийг цохон тэмдэглэснийг дурдвал, "Зөвхөн зохих хууль зүйн дэглэм байгуулснаар орчин үеийн эдийн засгийн системд тохирох өмчлөх эрхийн сүлжээг байгуулж болно гэдэг ойлголт байж болшгүй юм. Учир нь ихэнх өмчлөх эрхийн зөвхөн өчүүхэн хэсгийг хууль эрх зүйн системийн шахалтаар хийж болно..."¹ гэсэн байна.

Оюуны өмчийн эрхийн системчлэлд хамаарах хуулуудад "эрхийн хүрээг" дараах байдлаар томъёолсон байна.

1. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд, "Зохиогч бүтээлийн хувьд л эрх эдэлнэ, бүтээл туурвисан хүнийг зохиогч гэнэ, бүтээлийг...тоглодог хүнийг уран бүтээлч гэнэ, ...бүтээлийг...бүтээл гэнэ, бүтээлд.....бүтээлийг тооцно" гэсэн боловч "бүтээл" гэдгээ тайлбарласангүй.
2. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд, зохиогчийн оюун ухаанаас гарч болох бүтээлийг 20 хэсэгт л ангилалд эндээс 12-г нь хуулиар хамгаална, 8-г нь хамгаалахгүй гэсэн байна. Хэдийгээр хуулийн 3.1.1-д, "зохиогчийг" өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүн гэж тодорхойлсоноос үзэхэд зохиогчийн оюуны үйл ажиллагааг ямар нэгэн байдлаар хязгаарлаагүй мэт боловч «бүтээл туурвисан» байх гол шинжийг хуулийн 7 болон 8-р зүйлээр хайрцагласан нь энэ эрхийг эдлэх боломжийг явцууруулж байна. Хэрвээ хүн эл хуулийн 7 болон 8-р зүйлд зааснаар өөр бүтээл туурвисан бол яах вэ? Энэ тохиолдолд хамгаалахаас бусад нь хамгаалагдахгүй юу, Хамгаалагдахгүйгээс бусад нь хамгаалагдах уу гэдэг нь тодорхой бус байна. Мэдээж хэрэг туйлын эрх чөлөө гэж үгүй. Тодорхой эрхийг хэрэгжүүлэхэд зохих хязгаарлалт байх

¹ Эрнандо Де Сото, *Капитальон нууц*, УБ, 2004, 159 дэх талд

нь зүйн хэрэг. Гэхдээ энэ тохиолдолд, «Туйлын эрх чөлөө гэж үгүй. Бид харилцан биенээсээ хамаарсан нийгэмд амьдарч байна. Иймээс бүр долоон дор хязгаарлалтанд хүрэхгүйн тулд зарим эрх чөлөөг хязгаарладаг. Харин бид өдгөө аль хэдийнээ зайлшгүй хязгаарлалтынхаа хилийг давчихжээ. Ингэхээр тулгарч байгаа асуудал маань энэ хязгаарлалтыг цуцлах болохоос биш цааш нь олшруулах явдал биш юм².” гэснийг бодох нь зүйтэй санагдана.

3. Хуульд “эрхтэй” гэж заах, эрхийг тоочих зохицуулалтын хувьд ихээхэн ялгаа бий. Тухайлбал, Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 20-р зүйлд, “уран бүтээлчийн эрх”, 21-р зүйлд, “фонограмм бүтээгчийн эрх”, 22-р зүйлд, “радио, телевизийн байгууллагын эрх”-ийг тоочин тодорхойлсон нь оюуны өмчийн эрхийг хязгаартайгаар эдлүүлж байгаа жишээ юм.
4. Хуулийн 1.1-д, “Энэ хуулийн зорилт нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж томъёолсон байна. Гэхдээ хуулийн 10-р зүйлийн 10.1-д, “**Зохиогч бүтээлийнхээ хувьд эдийн бус баялагийн эрх болон бүтээл ашиглах онцгой эрх эдэлнэ**” гэж тодорхойлон зохицуулсан нь хуулийн зорилтын хүрээг хумигдуулсан шинжтэй байна. Ингэхдээ эдийн бус баялагийн эрхэд хуулийн 11.1-д зааснаар 4 төрлийн эрх хамаарахаар заасан байх бөгөөд хуулийн 12-р зүйлийн 1-д, “Зохиогч нь өөрийн бүтээлийг бүхий л арга, хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ.” гэдгийн эрхийг тоочоогүй байх учир “бүхий л арга хэлбэр гэдгийн дотор” тухайн эрхээр хөрөнгө оруулалт хийх эрхийг багтаасан гэж итгэж байна.
5. Патентын тухай хуулийн 16-р зүйлийн 16.1.1-д, “шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашинтай загварын зохиогч нь шинэ

² *Хувь заяагаа сонгох нь, Мильтон Фридман, Рөцз Фридман, УБ., 2007, 56 дөрөв тал*

бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвараа өмчлөх эрхтэй” гээд тухайн эрхийг тоочоогүйн дотор уг эрхээр хөрөнгө оруулалт хийх эрхийг багтсан гэж үзэх боломжтой байна. Гэхдээ эрх хэрэгжих боломжийг хайрцаглан хязгаарладаг хуулийн нийтлэг алдаа бас байсаар байна.

Бид оюуны өмчтэй байх эрхтэй, оюуны өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хамгаалах эрхтэй гэж хуулиаа заадаг боловч энэ эрхийг хэрэгжүүлэх эрхийг нь хуулиараа хязгаарлаад байгаа юм биш биз. Энэ бол том толгойд багадсан малгай өмсгөөд байгаагийн илрэл юм.

Хөрөнгө оруулалтын эрхэд оюуны өмчийн эрх хамаарах эсэх.

Хөрөнгө оруулалтыг эдийн засгийн болон эрх зүйн үүднээс тодорхойлж болно. Эдийн засгийн агуулгаараа ирээдүйн тодорхой хугацаанд үргэлжлэх нэг болон нэгэн хэсэг хөрөнгөд чиглэх хөрөнгийн үүрэг³, өгөөжтэй хөдөлмөрийг тэтгэхэд чиглэгдэх⁴ байдлаар авч үзсэн нь бий.

Хөрөнгө нь Ф.Бастиагийн бичсэнчлэн “үнэт чанар”-тай⁵ бөгөөд энэ чанар нь “хөрөнгийг өгсөн бол авдаг” эдийн засгийн олон талт харилцааны үндэслэл болж байна. Хүн үнэхээр сайхан сэтгэлтэйдээ хоолны газар ажилуулж бусдад “тусалдаг”, бас ур чадвартай учраас барилга барьж, банк санхүүгийн үйл ажиллагаа явуулдаг уу гэвэл мэдээж тийм биш. Хөрөнгийн “үнэт чанар” л тэднийг тийм ажил хийлгэхэд хүргэдэг. Чухамдаа юу өгөөд юу авах вэ гэдэг бол хөрөнгө оруулж буй үнэт чанартай холбоотой бөгөөд хөрөнгө оруулагч түүнээсээ давсан үнэт чанарыг авах эрмэлзэл дээр энэ ойлголтын эдийн засгийн үндэслэл тогтож

³ Charles P. Jones. *Investment analysis and management*. IV ed. 1993. 5 дахь тал

⁴ Алан Смит: “Аливаа хөрөнгө өгөөжтэй хөдөлмөрийг л тэтгэхэд зориулагддаг үүцртэй авч, хэмжээгээрээ ижил хөрөнгийг хөдөлгөөнд оруулдаг хөдөлмөрийн хэмжээ нь хэрэглэж байгаа аргаасаа замааран илээхэн хэлбэлгэх бөгөөд, црний хамтаар тэдгээрийг хэрэглэснээр улсын жилийн нийт бүтээгдэхүүнд орох өртөг нь бас өөрчлөгдөж байдаг.” Үндэстөвдийн баялаг. УБ., 2009, 370 дахь тал

⁵ Ф.Бастиа. Эдийн засгийн софизм, эдийн засаг дахь эв зохиол. УБ., 2004, 41 дэх тал

байна. Гэхдээ хөрөнгө оруулалтын харилцаа ямагт хоёр талын ашиг сонирхол байдаг утгаараа эсрэг талд хөрөнгө авагчийн эдийн засгийн ашиг сонирхол туйлын чухал. Авсанаасаа илүү ихийг өгөх нь түүний сонирхол биш.

Эдийн засгийн хувьд ашигтай байхаар сонгосон хөрөнгө оруулалт бүр өөрт тохирохуйц хөрөнгийн хэлбэрийг санал болгож байдаг. Энэ нь өмчийн эрх эдлэх боломж нь хөрөнгө оруулагч төдийгүй хөрөнгө авагчийн ашиг хүртэх сонирхолоор хязгаарлагдаж байдаг гэсэн үг юм. Гагцхүү нйм хязгаарлалтаар л хөрөнгө оруулагч этгээдийн өмчийн эдийн засгийн эрх чөлөө хязгаарлагдаж болох юм.

Хэдийгээр оюуны өмчийн эрхийн хувьд хөрөнгө оруулалт хийх эрх хамаарч байгаа ч хөрөнгө оруулалтын эрх түүнийг хүлээн зөвшөөрөх эсэх нь бас чухал.

Хөрөнгө оруулалтын талаар А.Смит: "Хөрөнгийг, нэгд, жил бүр нийгмийн хэрэглээнд шаардагдах түүхий бүтээгдэхүүнийг олборлох, хоёрт, мөнөөх түүхий бүтээгдэхүүнийг шууд хэрэглээнд тохирохуйцаар боловсруулах, гуравт, түүхий ба боловсруулсан, бэлэн бүтээгдэхүүнийг илүүдэлтэй газраас дутагдалтай газар луу гэвэрлэх, дөрөвт, мөнөөх бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн хэрэглээнд тохирсон хэмжээгээр жижиглэн хуваах гэх зэрэг дөрвөн аргаар хэрэглэж болно."⁶ гэж үзжээ. Хөрөнгийг юунд хандуулах нь чухалын зэрэгцээгээр яаж хандуулах нь бас чухал.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах гэсний дотор, хөрөнгө оруулалтын хувьд⁷ шинэ технологи нэвтрүүлэх боломжтой

⁶ А.Смит, Үндэстэндийн баялаг, УБ., 2009, 370 дэл талд

⁷ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, 3.2.2.1.Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дэл хувь, орлувоот нэмэгдлцлэх, замгаалах бодлого хэрэгжлцлэх, бизнесээ өргөжлцлэх, олон улсын тавуунал өрсөлдөх чадвараа дэмжлцлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх цэрээ гүйцэтгэх боломжийн бодлцрэнэ.

3.2.2.2.Гадаадын аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс хэтрээгүй байлгах бодлого баримтлалд.Гадаадын төрийн өмчийн компанийн хөрөнгө оруулалтыг

байхаар хууль, эрх зүйн зохицуулалтыг хангана гэснээс үзэхэд, оюуны өмчөөр хийх хөрөнгө оруулалтын гарцыг шинжлэх ухаан, технологийн салбарт тухлуу чиглүүлж байгаа нь харагдаж байна.

Хөрөнгө оруулалтын харилцааг зохицуулж буй хууль тогтоомж нь /Хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 он, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль 2013 он, Инновацийн тухай хууль 2012, Җижиг, дунд үйлдвэрийн тухай хууль 2007 он, Компанийн тухай хууль 2011 он, Нөхөрлөлийн тухай хууль 1995 он/ сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын арга, хэлбэрийг өргөжүүлсэн, ялангуяа оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийх эрхийг хангахыг ихэд эрмэлзэж байгаа билээ.

Хөрөнгө оруулалт нь улс орны эдийн засагт ач холбогдолтой гэдэг нь маргаангүй үнэн. Гэхдээ хэзээ, ямар хөрөнгө оруулалтыг яаж татах асуудал бол хөрөнгө оруулж байгаа талд бус түүнийг авч байгаа талын гол асуудал юм. Хууль, эрх зүй оновчтой байна гэдэг нь хуультай байх ёстой учраас хуулийг батлах бус хууль үнэхээр хэрэгтэй учраас түүнийг батлан гаргадаг байх хуулийн "амин сүнсний" ойлголт юм. Хөрөнгө оруулалтын бодлого, хуулийн шинэчлэл цаг үеэ олсон эсэх нь чухал.

хязгаарлаж, стратегийн ач холбогдолтой салбарт хөрш орон, өндөр хөгжилтэй бусад орноос оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг тэнцүүэртэй байлгах бодлого баримтала.

3.2.2.3. Монгол Улсын үрэг үзэгтэй аж ахуйн нэгжүүдийн хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд борлуулалдан гэдэгдмн хөрөнгө оруулалтын чиглэлээр баримтлах бодлогын зарчим алдагдалгүй байх эрх эрхэн орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.2.4. Гэдэгдмн хөрөнгө оруулалтыг өрсөлдөх чөлөөт, санхүү, менежментийн цо өгөөжийг дээшлүүлэх, шинэ технологи нэвтрүүлэх, урт хугацааны хөгжлийн үрэгсийг тавих чухал хөшигцрэг, арга хэрэгсэл болгоно.

3.2.2.5. Гэдэгдмн худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт зараагт байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Эскпортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, Монгол Улсын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. <http://www.legalinfo.mn/>

Цаг үеэ олсон, мэдрэмжтэй хөрөнгө оруулалтын жишээг Хятад улсаас харж болно. Хятад улсын хөрөнгө оруулалтын бодлого нь гадаад, дотоод зах зээл, гадаад, дотоод баялагийг хавсран хөгжүүлэх бодлогод суурилсан “Хятад, гадаадын хамтарсан үйлдвэрийн тухай хууль”, “Гадаадын дагнасан хөрөнгө оруулалттай үйлдвэрийн тухай хууль”, “Хоршсон үйлдвэрийн тухай хууль”-ууд нь шат дараалсан, уян хатан, зөвшилцөлд суурилсан, хамгийн гол нь “үлдэцтэй” хөрөнгө оруулалтыг бий болгож чадаж байна. Шат дараалсан энэхүү арга хэмжээний дүнд хамгийн үлдэцтэй, “өгөөжтэй” хөрөнгө оруулалт болох оюуны өмчийн “мэдлэг”ийг авч үлдэн хөрөнгө оруулалтын дараагийн шатлалын бодлогоор хөгжсөн орнуудтай өрсөлдөхүйц үйлдвэрлэл явуулах боломжийг бүрдүүлээд байна. “Монгол улс барууны орнуудын санал болгосон “цочмог” загвараар явсан бол Хятад улс аажмаар ахин дэвших өөрчлөлтийн аргыг сонгож, арван хэдэн жилийн өөрчлөлт, нээлттэй бодлогын туршлагынхаа үндсэн дээр сүүлийн 15 жил эдийн засгаа тогтвортой, өндөр хурдацтай хөгжүүлсэн”⁸ гэдгийг бодож үзэх нь зүйтэй.

Оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийх эдийн засгийн эрх зүйн зохицуулалт нь бидэнд олон талаас бодож тунгаах, хөрөнгө оруулагчийг татахаас илүүтэйгээр хөрөнгө авагчийн хүсэл зориг, шаардлагыг хангасан зохистой байдлыг зайлшгүй шаардаж байна. Хэд хэдэн асуудалд анхаарал хандуулъя.

1. Оюуны өмчийн хөрөнгө оруулалт ба даяаршил.

Хүн төрөлхтөн хоёр дахь том үсрэлтийнхээ үед явж байгаа өнөө үед дэлхий дээрх 3 биллион хүн ядуурлаас дээш түвшинд амьдарч байгаа болон өөр олон олон хөгжил, дэвшлийн эхлэлийг даяаршилтай холбон тайлбарлах хандлага улам бүр хүчтэй яригдаж байна. Энэ нь ч зүйн хэрэг. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд, гадаад нөөц боломжийг ашиглан үндэсний ашиг сонирхолоо хамгаалж бататгах боломж

⁸ Ли Сяньжи. Монгол-Хятад хоёр улсын “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийн хөрвүүлэлтийн зарим асуудал. Монголын төв, эрх зүй сэтгүүл, 2010 №2 |60|

олгож байна хэмээн даяаршлыг зөвтгөсөн байна. Даяаршлыг тууштай дэмжигч Жохан Норберг, "Энэхүү хөгжлийг өөрийн орны иргэдэд гадаад оронд буй шинэ санаа, технологийг ашиглах, бусад орнуудтай худалдаа наймаа хийж, хөрөнгө оруулах боломж олгосон улс орнууд тэргүүлж байна. Өөрөөр хэлбэл, даяаршил гэж нэрлэгддэг тэр үйл явц л уг боломжийг олгож байгаа юм."⁹ хэмээн өмнөтгөлдөө бичсэн байна.

Бид даяаршихгүйгээр оюуны өмчийн хөрөнгө оруулалтыг татах, оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжгүй юм. Эдийн засгийн эрх чөлөө хамгийн их улс орнуудын хувьд нэг хүнд оногдох ДНБ-ийн хэмжээ их байдаг, эдийн засгийн өсөлт их байдаг, хүний хөгжлийн индекс хамгийн өндөр байдаг, тухайн орны хүн хамгийн урт насалдаг гээд ач холбогдол их бий. Мэдээж ашигтай боловч бас хэмжээтэй. Хөгжиж буй орнуудын хувьд оюуны өмчийн хөрөнгө оруулалтыг бусад салбарын шинэчлэлийн бодлогоор "цочир" шинэчлэх, хязгааргүйгээр хөрөнгө оруулалт хийх эрхийг олгох нь эдийн засгийн шинэ империализм болох "Кока колонизаци" (Coca-colonization)¹⁰-д нэрвэгдэх хөгжиж буй орнуудын "зовлон" манайд ч бас хамаатай.

Зохистой даяаршлыг хүлээн зөвшөөрөх нь "уламжлалт мэдлэг"-ийг хамгаалж үлдэхэд нөлөөлөх нь дамжиггүй. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 4.2-т, "Хөрөнгө оруулагч нь Монгол улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад салбар, үйлдвэрлэл, үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийж болно." хэмээн заажээ. "Шилмэл өмгийн адуу авчирснаас болж азарга нь манлайлдаг адуун сүргийн бүтэц алдагдсан" тухай мэдээ, баримт дахин сонсогдохгүй гэхэд эргэлзэж байна.

2. Хөрөнгө оруулагч, хөрөнгө авагчийн ашиг сонирхол. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 3.1.1-д, "хөрөнгө оруулалт"

⁹ *Даяаршиж буй капитализмыг хамгаалахуй. Жохан Норберг. УБ., 2007, 7 дэх тал.*

¹⁰ *The impact of Foreign Investment on Indigenous Culture: An Intellectual property Perspective. Doris Estelle Long. 2006. Globalization and Intellectual property. /http://ssrn.com/abstract 2223312/*

гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг хэлнэ, гэснээс үзэхэд оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийх боломжийг тодорхойлсон байна. Хуулийн дээрх заалтад ашгийн төлөө хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь эрх зүйн байдлын хувьд компани, нөхөрлөлийн хувьд л хамаарахаар тусгагдсан байна. Компани, нөхөрлөлд хөрөнгө оруулалт хийх боломж нь оюуны өмчийн хэлбэртэй байх боломжтой боловч энэ нь гагцхүү тодорхой хэмжээгээр үнэлэгдсэн үед л тооцогдоно. Харин оюуны өмчийн үнэлгээ нь гагцхүү хөрөнгө оруулагч нэг талын ашиг сонирхол бус хөрөнгийг хүлээн авагч нөгөө талын ашиг сонирхолоор хязгаарлагдана. Бизнесийн байгууллагуудын хувьд давуу эрхийн хувьцаа гаргах болон зарим хариуцлага хүлээдэг гишүүнийг элсүүлэх зэрэг хэлбэрээр илрэх боловч энэ нь ашиг сонирхолуудын нэгдэлд хүрч байж хөрөнгө оруулалтад тооцогдох юм. Оюуны өмчийн эрх нь эдийн засгийн эргэлтэд чөлөөтэй оролцдог, хөрөнгө оруулагч болон хөрөнгө хүлээн авагч талуудын ашиг сонирхолыг бүрэн хангадаг байхын тулд үнэлэх жишиг, боломжийг эрх зүйн хувьд хангах нь зүйтэй.

Хөрөнгө авагчийн ашиг сонирхолд суурилсан оюуны өмчийн хөрөнгө оруулалтыг татах, дэмжих нь хамгийн үлдэгдтэй, өгөөжтэй бөгөөд ийм хөрөнгө оруулалтын эрх зүйн зохицуулалт үнэхээр чухал байна.

Оюуны өмчөөр хөрөнгө оруулалт хийх хэлбэрүүдэд хуулиар тодорхойлсон тодорхой төрлийн гэрээний хэлбэрүүд мөн хамаарна. Ялангуяа эдийн бус баялагийн эрхийг шилжүүлдэг тодорхой төрлийн гэрээ нь франчайзын гэрээ юм.

Эдийн засгийн өсөлт, хөгжилтөд нөлөөлөхүйц оюуны өмчийн хөрөнгө оруулалт нь цаг үеэ олсон оновчтой зохицуулалтыг шаардах боловч "үйлдвэрлэлийн, үйлчилгээний, бараа бүтээгдэхүүний" франчайзын хэлбэрийн хөрөнгө оруулалтаас гагцхүү үйлдвэрлэлийн франчайзийн¹¹ хуульчилсаныг тайлбарлахад

¹¹ Монгол улсын Иргэний хуулийн 333.1-т, "Франчайзийн гэрээгээр эрх

хэцүү. Нөгөө талаас зөвшилцдөг ашиг сонирхолуудыг зохицуулсан гэрээний үүргийн зохицуулалтыг "иргэний эрх зүйн гэрээ" гэсэн ойлголтоос тусгаарлан авч үзэх эрх зүйн шаардлагыг хүлээн зөвшөөрөх цаг болжээ.

Сүүлийн жилүүдэд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Инновацийн хуулийг батлан гаргасан нь ихээхэн чухал юм. Гэхдээ нийм хэлбэрийн хөрөнгө оруулалтыг хүлээн авах, эдийн засгийн эргэлтэд оруулан хэрэгжүүлэхэд ихээхэн цаг хугацаа, шат дараалсан бодлого дутагдаж байна. Хамгийн энгийн жишээ бол инновацийг дэмжих төрийн бодлогын хүрээнд Монгол улсын Засгийн газрын 193-р тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан 100-р тогтоолд нано, биотехнологийн үйлдвэрлэлийг дэмжих зориулалтаар нийтдээ 34 нэр төрлийн БТКУС-ын код бүхий тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөхөөр заасан байна. Энэ дагуу 2012-2013 онд ХБНГУ, ОХУ, БНХАУ, АНУ, БНСУ, Бельги, Франц, Их Британи, Гонконг, Турк, Япон, Австрали, Сингапур, Энэтхэг зэрэг орноос 250 орчим бүрдүүлэлт бүхий тоног төхөөрөмжийг оруулж ирэн татвараас чөлөөлөөд байна¹². Эдгээр нь зөвхөн мэдүүлгийн үндсэн дээр тогтоогдож байгаагаас жинхэнэ оюуны өмчийн эрхийн хөрөнгө оруулалт байж чадах нь эргэлзээтэй. Угтаа хөрөнгө оруулалтыг авагч тал нийм төрлийн хөрөнгө оруулалтыг хүлээн авахад бэлтгэгдсэн байх ёстой. Жинхэнэ утгаараа хийгдээгүй хөрөнгө оруулалт эдийн засгийг хөгжүүлэхээсээ илүүтэйгээр хохироож ч мэдэх юм.

шилжигдэгч нь өөрийн фирмын нэр, бараа буюу ажил, үйлчилгээний тэмдэг, бүтээгдэхүүний загвар, бэлгээ, боодол, түрчлэн ажил хэргийн удирдлагын тогтолцоо, төлөвлөлт, харилцаа холбоо, бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ олж авах үндсэн чиглэл зэрэг эдийн бүс хөрөнгийг ашиглуулахаар тогтоосон журмаар бүртгүүлсэн лицензийг эрх хүлээн авагчид олгох, эрх хүлээн авагч нь эрх шилжигдэгчийн боловсруулсан тогтолцоо, хамтын ажиллагааны хөтөлбөрийн дагуу үйл ажиллагаа явуулж, түцмд зохих ивэглэл, хураамж, эсгэл орлогын тодорхой хувийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.

¹² Галлийн Ерөнхий газрын 2012-2013 оны статистик мэдээллээс хэсэглэн авав.

3. Оюуны өмчийн хөрөнгө оруулалт ба хамгаалалт.

Оюуны өмчийн хөрөнгө оруулалт нь эрх зүйн зохих хэмжээний хамгаалалтыг шаарддаг. Угтаа оюуны өмчийн эрх болон хөрөнгө оруулалтыг эрх зүйн хувьд холбож өгдөг нэгэн чухал асуудал бол хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин дахь оюуны өмчийн хамгаалалт юм. Жохан Норберг: "Эдийн засгийн хөгжлийн төвшнийг хангаж өгдөг зүйл бол худалдаа бөгөөд хөгжиж буй орнууд худалдаагаар дамжуулан эд баялаг, технологи олж авдаг. Эндээс л оюуны өмчийн эрхийг хамгаалах нь эдийн засагт нь амни чухал болж хувирна."¹³ гэснийг тэмдэглэн хэлье.

Оюуны өмчийн хөрөнгө оруулалтад оюуны өмчийн эрхийг хамгаалах асуудлыг сүүлийн жилүүдэд хэд хэдэн байдлаар асуудал дэвшүүлэн авч үзэж байна.

а. Олон улсын гэрээний хамгаалалтад орсоноор шууд хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх¹⁴.

б. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг Олон улсын хөрөнгө оруулалтын гэрээгээр хамгаалах асуудал. Энэ асуудлын хүрээнд ДХБ, TRIPS-д элсэх, Бернийн болон Парижийн конвенцуудаар хязгаарлаж болохгүй бөгөөд үндэсний хууль тогтоомжийн уялдаа холбоо чухал ач холбогдолтой талаар Австралийн Засгийн газрын эсрэг гомдол гаргасан Филип Мориссийн хэрэгт тулгуурлан илэрхийлсэн үзэл хандлага¹⁵ олон бий.

в. Соёлоо хамгаалахад чиглэсэн оюуны өмчийн хатуу хамгаалалтыг эдийн засгаа хөгжүүлэх бодлоготой хослон барих хандлага¹⁶.

¹³ Даваршиж буй капитализмыг хамгаалалтгүй, Жохан Норберг, УБ., 2007, 191 дэх талд

Зохиогчийн эрхийн тухай анхны бие даасан хууль 1993 онд батлагдан гарсан байдаг. 1993 оноос өмнөх зохиогчийн эрхийн бүтээл нь төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөөр болон төрийн албан хаагч өөрийн ажил үүргийн дагуу хийж гүйцэтгэн, төрөөс цалин хангамж, урамшуулал аван бүтээж бий болгосон бүтээлүүд гэж үздэг.

Төрийн өмчийн хороо, Оюуны өмчийн газрын дарга хамтран 2009 оны 07 сарын 02-ны өдөр “Төрийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийг үнэлэх, бүртгэх, ашиглах, хадгалах журам” боловсруулан баталсан. Энэхүү журмаар төрийн хөрөнгөөр бий болсон, холбогдох хууль тогтоомжийн дагуу оюуны өмч гэж тооцож, үнэлсэн оюуны өмчийг эзэмших, ашиглах, бүртгэх, хадгалахтай холбогдсон харилцааг зохицуулсан. Төрийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийг төрийн өмчийн бүртгэл, мэдээллийн санд оруулсаны дараа хуулийн этгээд, иргэдэд зохих журмын дагуу ашиглуулж болно. Ингэж ашиглуулахдаа оюуны өмчийг төрийн өмчит төсөвт байгууллагад үнэ төлбөргүй зиниглууна, харин хуулийн этгээд иргэдэд ашиглуулахдаа тодорхой төлбөр авч байхаар зохицуулсан. Төрийн хөрөнгөөр бий болсон оюуны өмчийг хариуцан хадгалах этгээд нь төрийн өмчит хуулийн этгээд юм.

Энэхүү журмын дагуу төрийн өмчийн хороо, оюуны өмчийн газартай хамтран төрийн өмчит хуулийн этгээдийн байгууллагуудаар явж хадгалагдаж буй бүтээлүүдэд тоолого

хийсэн ба одоогоор тухайн бүтээлүүд дээр үнэмлэгээ хийх, нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулах зэрэг ажлууд хийгдээгүйн улмаас төр эдгээр бүтээлүүдийг бусдад ашиглуулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлууд одоо болтол хийгдээгүй байна. Мөн тухайн бүтээлүүдийг эдийн засгийн эргэлтэнд оруулсан тохиолдолд бүтээл ашиглуулснаас олсон орлогоос тухайн зохиогчид нь тодорхой хэмжээний урамшуулал олгодог байх талаар заалтыг тус журамд нэмж оруулах нь зүйтэй юм. Хэрвээ зохиогч нь 1993 оноос өмнө бүтээсэн бүтээлээ төрийн оролцоо байхгүй болохыг нотолж байгаа тохиолдолд зохиогчийн эрхийг зохиогч нарт эзэмшүүлэх талаарх зохицуулалт үгүйлэгдэж, маргаан дагуулсаар байна.

Зохиогч болон хэрэглэгчийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх

Зохиогчийн эрхийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээг шударгаар биелүүлэх төдийгүй эх орондоо байгаа оюуны өмч, түүний дотор зохиогчийн эрхийг хамгаалахад зохиогчийн эрхийн олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх явдал нэн чухал асуудлуудын нэг юм. Өнөөдөр бид амьдралынхаа алхам тутамд зохиогч, оюуны бүтээл туурвигчдын урлагийн бүтээлүүдийг ашиглаж оюуны болон сэтгэлийн таашаал авч байдаг билээ. Бүтээл туурвина гэдэг нь зохиогч болон бүтээл туурвигчаас оюуны маш их хүч хөдөлмөр шаардсан ажил юм. Хэдийгээр бүтээл ашиглагч байгууллагуудын зохиогчийн эрх болон бүтээлд хандах хандлагад ахиц дэвшил гарч бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй, төлбөр төлөхгүйгээр ашиглах явдал эрс багассан хэдий ч бүтээл ашиглагч ерөнхий олон нийтийн зохиогчийн эрхийн мэдлэг, боловсрол хангалттай бус байгаагаас зохиогчийн эрхийг зөрчих, бүтээлийг хууль бусаар хуулбарлан ашиг олох явдал байсаар л байна. Уран бүтээлч, зохиол бүтээл туурвигчид өөрсдөө ч зохиогчийн эрхийн хууль болон эрхээ хэрхэн хамгаалах талаар хангалттай мэдлэг

байдаггүй нь эргээд зохиогчийн эрхийн зөрчил гарах, бүтээлээ бусдад алдах нөхцөлийг бүрдүүлдэг.

Оюуны өмчийн эрхийн мэдлэг, ойлголтыг түгээн дэлгэрүүлэх ажиглагаа бүх шатны сургуулиудын хөтөлбөрт хэрхэн тусгагдсаныг судлаад үзэхэд ерөнхий боловсролын бага, дунд ангийн сургалтын хөтөлбөрт оюуны өмчийн мэдлэг олгох хичээлийг судалдаггүй, харин ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд эрх зүйн мэдлэг олгох хичээлийг судалдаг боловч энэ хичээлийн хүрээнд оюуны өмч, зохиогчийн эрхийн салбарын мэдээллийг авч үздэггүй, дурьддаг ч үгүй нь харамсалтай. Зарим их дээд сургуулиуд оюуны өмчийн эрх зүйн хичээлийг заавал судлах хичээлийн тоонд оруулдаг ч аж үйлдвэрийн өмчийн эрх зүйн асуудлыг голчлон судлахад хичээлийн ихэнх цаг нь зарцуулагддаг бөгөөд зохиогчийн эрхийн сэдвийг цөөхөн цаг судалдаг нь ажиглагдсан. Түүнээс гадна оюуны өмч, зохиогчийн эрхийн хичээл заадаг мэргэшсэн багш нарыг бэлтгэдэг газар байхгүйгээс болоод хичээл заадаг багш нар зөвхөн өөрсдийн судалсан хүрээнд л хичээлээ заадаг нь уг асуудлын нарийн зохицуулалтуудыг бүрэн ойлгож мэдэхэд тодорхой хэмжээгээр бэрхшээл учруулдаг. Тиймээс бүх шатны сургуулиуд, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зохиогчийн эрхийн асуудлыг сурталчлах, таниулах нэгдсэн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байна. Оюуны баялагийг дээдэлдэг, үнэлж хүндэлдэг, хуулиа чандлан биелүүлдэг зарим улс орнуудын туршлагаас харахад зохиогчийн эрхийн талаарх ойлголтыг сургуулийн өмнөх нас буюу цэцэрлэгийн наснаас эхлэн системтэйгээр зааж сургадаг нь хүн бүрийг багаас нь бүтээлч болгох, зохиогчийн эрхийн талаар ойлголт мэдлэг боловсролыг багаас нь таниулах, оюуны өмчийг дээдэлж, хуулийг зөрчихгүй байлгах зэрэг олон чухал ач холбогдолтой юм.

Оюуны өмчийн хамгаалалтын механизмыг боловсронгуй болгоход төрийн бодлого, төрийн оролцоо зайлшгүй чухал юм. Оюуны баялагийг үнэлдэг, хүндэлдэг улс орнуудын хувьд оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнгийн илэрхийлэл болсон

бүтээлийг хамгаалдаг оюуны өмчийн салбараа төрийн зүгээс маш их дэмжиж, анхаарал хандуулан сайтар боловсруулсан бодлогыг авч хэрэгжүүлдэг. Аливаа нийгмийг хөдөлгөгч, хөгжүүлэгч гол хүч бол яахын аргагүй хүний оюун ухаанаас ундран гарсан шинэ бүтээл, материаллаг бус оюуны баялаг байдаг билээ. Уг баялгийг бүтээгч туурвигчдын эрхийг хамгаалах, тэдний нийгмийн баталгаат байдлыг бий болгох, урамшуулах, хөхүүлэн дэмжихийн тулд оюуны өмчийн салбартаа зайлшгүй анхаарлаа хандуулах нь чухал юм. Монгол улсын хувьд оюуны өмчийн салбарт тэр дундаа зохиогчийн эрхийн салбарт хэрэгжүүлэх оюуны өмчийн эрхийн төрийн нэгдсэн бодлого, төлөвлөгөө хараахан байхгүй.

Харин ДОӨБ-ын төслөөр "Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх үндэсний стратеги"-ийг оюуны өмчийн газраас боловсруулан засгийн газарт хүргүүлээд байна. Оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх шаардлага нь мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох, оюуны бүтээлийг зах зээлийг эргэлтэнд оруулах нөхцлийг хөгжүүлэх, ингэснээр эдийн засгийн чадавхийн хувьд дэлхийн эдийн засагт эзлэх байр суурь бүхний улс болох хөгжлийн зорилт дэвшүүлж байгаа өнөөгийн нөхцөлд бүтээл туурвих, шинийг санаачлах үйл ажиллагааны үр өгөөжийг эрс нэмэгдүүлэх бодит шаардлага тулгарч байгаа юм. Олон улсын хэмжээнд өрсөлдөхийн тулд Монгол улс чанартай патент, хүчтэй брэнд, соёл урлагийн хосгүй бүтээл бүхний оюуны өмчийн цогц орчинтой байх нь чухал юм.

Манай улсад оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг улс орон даяар хүртээмжтэй хүргэх, орон нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дутагдалтай байна. Оюуны өмчийн асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд эрхлэн хариуцдаг байх үед аймгуудын засаг даргын тамгийн газрын хууль зүйн хэлтэс оюуны өмчийн асуудлыг хариуцаж байсан ба одоо ихэнх аймгийн хувьд энэ зохион байгуулалт хадгалагдсаар байна. Тамгын газрын нэг ажилтан энэ асуудлыг нийхүү хариуцдаг боловч яг ямар үйл ажиллагаа явууладаг нь тодорхойгүй. Үүнээс болоод орон нутгийн

хэмжээнд зохиогчийн эрхийн хуулийн хэрэгжилтийг хангах асуудал маш сул байдаг. Оюуны өмчийн газрын өдөр тутмын үйл ажиллагаа зөвхөн нийслэлд л явагдаж байна. Орон нутагт оюуны өмчийн зөрчилтэй холбоотой асуудал, хэрэг маргаан гарах тохиолдолд шууд ханддаг зөвлөгөө авах, шүүхээс өмнөх шатанд асуудлыг шийдвэрлүүлэх боломж байдаггүй. Түүнчлэн зохиогч, бүтээл туурвигчид бүтээлдээ хуулийн дагуу эрхийн хамгаалалт хийлгэх тохиолдолд заавал өөрийн биеэр хол замыг туулан ирэх шаардлагатай болдог нь бүтээл туурвигчдад ихээхэн хүндрэл учруулж байгаа юм. Тиймээс орон нутагт аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн асуудлыг тус тус хариуцсан дор хаяж нэг мэргэжилтэн ажиллуулах зайлшгүй шаардлагатай байна.

Хамтын удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг боловсронгуй болгох

Оюуны бүтээлч үйл ажиллагааны бүхий л ололт амжилтыг хүн төрөлхтний өмнө өргөн нээлттэй, хүртээмжтэй болгох, түүнчлэн эдгээр ололт амжилтыг бий болгох ба түгээн дэлгэрүүлэхэд тус дөхөм үзүүлсэн хүмүүсийг хөхүүлэн дэмжих, урамшуулах, бүтээл ашиглуулсныхаа төлбөрийг цуглуулах хамгийн оновчтой бөгөөд ач холбогдолтой арга бол зохиол бүтээл туурвигч нар нэгдэж Хамтын удирдлагын байгууллага байгуулах явдал билээ. Эрхээ хамгаалах болон хэрэгжүүлэхэд ганцаараа ажиллах нь хүндрэл бэрхшээлтэй байдаг учраас хамтын удирдлагын байгууллага байгуулах эсвэл байгуулахгүйгээр гишүүнээр элсэх замаар хэрэгжүүлэх нь зохиогч бүтээл туурвигчдад ашигтай байдаг. Хамтын удирдлагын байгууллага нь зохиогч болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчдийн нэрийн өмнөөс, тэднээс олгосон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага юм. Бүтээл туурвигчид, бүтээл ашиглагч нар Хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагаа, ач холбогдлыг үгүйсгэх хандлага байсаар байна. Тэд өөрсдийнх нь бүтээлийг бусдад ашиглуулж их хэмжээний ашиг олдог гэсэн

буруу хандлагынхаа улмаас хамтын удирдлагын байгууллагад гишүүнээр элсэх сонирхолгүй харин бие дааж өөрөө өөрийнхөө менежер, продюссер болж явахыг илүүд үздэг. Бүтээл хэрэглэгч байгууллагууд хувь уран бүтээлчтэй гэрээ хийхээс илүү хамтын удирдлагын байгууллагаар дамжуулж бүтээл ашиглах гэрээ байгуулан, хамтран ажиллахыг илүүд үздэг. Мөн хамтын удирдлагын байгууллагад гишүүнээр элсэх нь бүтээлээ дан ганц монгол улсын нутаг дэвсгэрт ашиглуулж төлбөр аваад зогсохгүй хэрэв олон улсын хамтын удирдлагын байгууллагад дотоодын хамтын удирдлагын байгууллага гишүүнээр элссэн тохиолдолд гадаадын улс орнуудад бүтээлээ ашиглуулж, зохиогчийн шагнал авах боломж бүрддэг гэх мэтчилэн уран бүтээлчдэд хүртэх үр ашиг нь илүү байдаг.

Сүүлийн жилүүдэд хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, тэднийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь зөв голдиролд оруулах тал дээр Оюуны өмчийн газраас маш олон ажлуудыг хийж байгаа боловч хамтын удирдлагын байгууллагуудын дотоод менежмент сул, хоорондын хамтын ажиллагаа муу, гишүүдээ булаацалдах, эсвэл гишүүнээр элсүүлэхээс татгалзах, бие биенийхээ үйл ажиллагааг үгүйсгэх хандлага байсаар байгаа нь эргээд бүтээл ашиглуулсныхаа төлбөрийг хэрэглэгч байгууллагуудаас хангалттай цуглуулж чадахгүй байх нэг үндэс болдог. Гэтэл радио телевизийн байгууллагууд, fm радионууд, үүрэн телефоны оператор компаниуд, нийтийн тээврийн хэрэгсэл (автобус, такси г.м), томоохон их дэлгүүрүүд, караоке, баар, ресторанууд гэх мэт бүтээл ашиглагч олон газрууд байдаг боловч цөөхөн хэдэн газруудаас л бүтээл ашигласныхаа төлбөрийг үнэн зөвөөр авч байна.

Хамтын удирдлагын байгууллагыг байгуулахдаа зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийн төрөл ангиллаар дагнасан хэлбэрээр буюу нэг төрөл дээр нэг л хамтын удирдлагын байгууллага байгуулахаар хуулиндаа тусгаж өгөх шаардлагатай юм. Нэг төрөл дээр хэд хэдэн хамтын удирдлагын байгууллага байгуулах

нь тэдгээрийн үүсгэн байгуулагч болон гишүүдийн хооронд үл ойлголцох байдал үүсэх нэг үндэслал болдог. Хамтын удирдлагын байгууллагууд үр дүнтэй үйл ажиллагаа явуулах, бүтээл хэрэглэгчидтэй амжилттай гэрээ, халцал байгуулахын тулд юуны түрүүнд гишүүдийнхээ мэдлэг боловсролыг дээшлүүлэх, цаашлаад хэрэглэгчдийн мэдлэгийн дээшлүүлэх талаар анхаарч ажиллах, энэ үйл ажиллагаанд уран бүтээлчдийг татан оролцуулах ажил чухал ач холбогдолтой юм.

Зохиогчийн эрхийн асуудал нь мөнхийн сэдэв бөгөөд жилээс жил ирэх тутам шинжлэх ухаан, технологийн хөгжилтэй уялдан эрх зүйн шинэ зохицуулалт, шинэ ухагдахуун төсөөллийг бий болгож байгаа бөгөөд технологи үсрэнгүй хөгжиж, зохиогчийн эрхийг зөрчих явдал газар авсантай уялдан энэ асуудал нь олон улсын бодлогод эн тэргүүнд тавигдах болоод байгаа билээ. Бид ч дэлхий нийтийн энэхүү чиг хандлага, хөгжлөөс хоцрохгүйн тулд хөгжилтэй улс орнуудын туршлагаас сайн судлах, олон улсын гэрээгээр хүлээн зөвшөөрсөн зарчим хэм хэмжээг биелүүлж орчин үеийн эрэлт, шаардлагад нийцсэн хууль боловсруулах, зохиогчийн эрхийн салбарыг хөгжүүлэх цогц бодлого боловсруулж ажиллах нь чухал юм.

Б.БАТБАЯР

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрх зүй, төрийн онол,
түүхийн тэнхмийн судлаач, докторант

ЗОХИОГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН БУС ЭРХ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Үндсэн хуульд, “Соёл, урлаг, шинжлэх ухааны цйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, цр шимийг нь хүртэх, шинэ бүтээл, нээлтийн эрхээ хуулиар хамгаалуулах”³⁴, тэрчлэн “Монголын ард түмний түүх соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалаалтад байх, Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн”³⁵ хэмээн бататгасан нь Үндсэн хуулиар засаг төрд үүрэг болгосон Үндсэн хуулийн нэг гол зарчим болно.

Монгол Улс нь 1993 онд энэ салбарын анхны гол хууль болох *Зохиогчийн эрхийн тухай хууль*, Патентын тухай хуулийг баталсан бөгөөд өдгөө оюуны өмчийн эрхийн зохицуулалт, хамгаалаалтын механизмьг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль³⁶, Патентын тухай хуулиар³⁷ голлон зохицуулж байна. Бусад эх сурвалжид Иргэний хууль, Эрүүгийн хууль болон Технологи дамжуулах тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Өрсөлдөөний тухай, Барааны тэмдэг болон аж ахуйн нэгжийн нэрийн тухай гэх мэт хэд хэдэн хууль хамаарч байна.

Аливаа хувь хүн шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвисныхаа үр дүнд зохиогч хэмээн нэрлэгдэж, улмаар эд хөрөнгийн бус хувийн ба эд хөрөнгийн шинжтэй хэд хэдэн эрх олж авдаг. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн

³⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 8 дахь хэсэг

³⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйл

³⁶ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль /2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн шинэчилсэн найруулга/

³⁷ Патентын тухай хууль /2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн шинэчилсэн найруулга/

тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд дээр дурдсан эд хөрөнгийн бус хувийн эрх ба эд хөрөнгийн эрх³⁸-ийг жагсаан тоочиж бичсэн байна. Үүнд, зохиогчийн эдийн бус баялгийн эрх гэдэгт "бүтээлээ өөрийн болон зохиомол, нууц нэрээр, эсхүл нэргүйгээр нийтлэх, зохиомол нууц нэрийг түүний зөвшөөрөлгүйгээр өөрчлөх задруулахыг хориглох, бүтээлээ нийтлэх эсхүл бүтээлийг ашиглах тухай бүр нэрээ дурдуулах, бүтээл болон түүний нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглох", бүтээл ашиглах онцгой эрхэд "зохиогч нь бүтээлийг хуулбарлах, бүтээлийг нийтлэх, бүтээлийг нийтэд түгээх, цэсмэл бүтээл болгон өөрчлөх, түрээсээр ашиглуулах"³⁹ эрх зэргийг дурджээ.

Академиц С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг"⁴⁰-тээ Зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрх гэдгийг "...Зохиогчийн эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан утга зохиол, шинжлэх ухаан ба урлагийн бүтээлийн зохиогчид хамаарах эд хөрөнгийн бус амины эрх" хэмээн тодорхойлж, энэ нь "...үнэмлэхүй шинжтэй бөгөөд зохиогчийг тодорхой бус хүрээний этгээдийн хууль бус цйлдлээс хамгаална..." энэ эрхийг "...хуулиар ч, гэрээгээр ч хасаж болохгүй" хэмээн тайлбарласан байна.

Эд хөрөнгийн бус хувийн эрх нь бүтээлийг шууд туурвигчид хамаарна. Эдгээр нь зохиогчийн хувийн байдлаас огт салгашгүй бөгөөд бусад этгээдэд шилжүүлж болдоггүй⁴¹ онцлогтой. Эх газрын эрх зүйн тогтолцоотой зарим улс орнуудад (тухайлбал, Франц, Герман, Испани) зохиогчийн аливаа бүтээл нь тухайн зохиогчийн оюун ухааны салшгүй хэсэг гэж үзэн, зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрхийг дээдэлж, чухалчлан авч үздэг. Харин эд хөрөнгийн эрх нь амины эрхээс үүдэн гардаг тул

³⁸ "Эд хөрөнгийн бус хувийн эрх" гэдгийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд "Эдийн бус баялийн эрх", харин "Эд хөрөнгийн эрх"-ийг "Бүтээл ашиглах онцгой эрх" хэмээн нэрлэжээ. 2002 оны Иргэний хуулийн 84, 122 дугаар зүйлүүдэд "Эдийн бус хөрөнгө" нэр тэмдэг хэрэглэсэн.

³⁹ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 11, 12 дугаар зүйл.

⁴⁰ Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. Нэмж засварласан гурав дахь хэвлэлт. Ув., 2011. 218 дахь тал

⁴¹ Нарангэрэл С., Тэмүүлэн Н. Зохиогчийн эрхийн туслуур асуудал. Ув., 2008. 115 дахь тал

зохиогчийн оюун санааг үнэлж урамшуулж буй хэлбэрт тооцдог бөгөөд манай улсын хувьд энэ жишгээр зарим зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжуудад тусгаж өгсөн.

Зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрх болох дээр дурдсан бүтээлээ нийтлэх, нэрээ дурдуулах, бүтээл болон түүний нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглох зэрэг эрхийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зааж өгсөн хэдий ч зохиогч мөн болох, бүтээл халдангүй байх, бүтээлээ нийтийн хүртээл болгох ба татан авах зэрэг эрхийг эд хөрөнгийн бус хувийн эрхэд зайлшгүй байх, мөн хууль тогтоомжид заавал тусгах шаардлагатайг судлаачид бүтээлдээ цохон тэмдэглэсэн⁴² бөгөөд миний хувьд дээрх судлаачдын үзэл бодолтой санал бүрэн нийлж буйгаа энэ дашрамд зориуд тэмдэглэе.

Дээр дурдсантай холбогдуулан зохиогчийн эрхийн зөрчлийн асуудал хөндөгдөх бөгөөд Зохиогчийн эрхийн зөрчилд зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг зөрчсөнтэй холбоотой үүсэх харилцааг хамааруулан авч үздэг. Практиктаас үзвэл ихэнхи тохиолдолд зохиогчийн эд хөрөнгийн эрхийг хөндсөн зөрчил илүүтэй гардаг байна.

Судлаачдын ихэнхи нь зохиогчийн эрхийн салбарт гарч байгаа зөрчлийг хөндөгдөж байгаа эрхийнх нь хувьд авч үзэн зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрхийг зөрчсөн үйлдэл, эд хөрөнгийн эрхийг зөрчсөн үйлдэл гэж ангилан үзжээ.

Иймээс зөрчлийн асуудлыг **зохиогчийн эдлэх эд хөрөнгийн бус хувийн зарим эрхийн хүрээнд** авч үзье. Зохиогчийн эд хөрөнгийн бус хувийн эрхэд “зохиогч мөн болох эрх” зайлшгүй байх ёстойг судлаачид⁴³ хүлээн зөвшөөрдөг. Харамсалтай нь хуульд энэ талаар зохицуулсан заалт байхгүй бөгөөд энэ төрлийн

⁴² Нарангэрэл С., Тэмүүлэн Н. Зохиогчийн эрхийн тулгуур асуудал. Ув., 2008. 115-127 дахь талд дэлгэрүүлэн үзнэ үү.

⁴³ Нарангэрэл С., Тэмүүлэн Н. Зохиогчийн эрхийн тулгуур асуудал. Ув., 2008. 115-116 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

зөрчил болох **Зохиогчийн бүтээлийг завших**⁴⁴ явдал амьдралд түгээмэл тохиолддог.

2010 онд Улсын бүртгэлийн ерөнхий газар 70 жилийнхээ ойн баяраар байгууллаагынхаа түүхэн замналын тухай хамтын бэсрэгхэн ном⁴⁵ хэвлүүлсэн. Тус бүтээл нь үүсмэл бүтээл⁴⁶ бөгөөд тухайн бүтээлд оюуны бүтээлч хөдөлмөр болон оюуны бүтээлч шинж чанартай хувь нэмэр оруулаагүй этгээд тус бүтээлд нэрээ дурдуулсан төдийгүй хамгийн хачирхалтай нь хамтран зохиогчоор оролцсон этгээдийн нэр дурдагдаагүй, зохиогч мөн болох эрх нь зөрчигдсөн явдал болно. Энэ бол ганц жишээ. Үүний цаана төрийн болон хувийн хэвшлийн зарим байгууллага, нэн ялангуяа судлаач эрдэмтдийн дунд ч ийм зөрчил их бий. Багш шавийн хийгээд найз нөхөд, танил тал, ажил олгогч болон ажилтны хоорондын "найзан дундаа" гэх харилцаанаас үүсдэг энэ зөрчлийг тэр бүр дэлгээд байх нь төдий л олон биш.

Мөн зохиогч бүтээлээрээ нэр төр, алдар хүнд олж авч нийтэд хүлээн зөвшөөрөгдөх сонирхолтой байдаг. Энэ нь эд хөрөнгөөр үнэлэгдэж, эдийн засгийн эргэлтэд оруулж үл болох ашиг сонирхол⁴⁷. Хувь хүн, байгууллага аливаа бүтээлийг ивээн тэтгэх явдал элбэг бөгөөд энэ нь янз бүрийн шалтгаантай байдаг. Хэдий тийм ч практикт зарим тохиолдолд ивээн тэтгэгчийн нэрийг бүтээлд дурдах нь бий. Гэрээний үндсэн дээр энэ нь байж болох асуудал боловч бусад хамтарсан зохиогчийн зөвшөөрлийг

⁴⁴ *Зохиогчийн бүтээлийг завших* - Зохиогчийн эрхэд халдсан гэмт халдлага бөгөөд бусдын бүтээлийг бүрэн хэмжээгээр буюу хэсэгчлэн өөрийн нэр дээр гаргасан үйлдэл; бусад хүмүүстэй хамтран бүтээсэн бүтээлийг төдий нэрийг танилгүйгээр өөрийн нэр дээр гаргах. Нарангэрэл С. Эрх зүйн эх тавь бичлэг. Нэмж засварласан гурав дахь хэсгит. Уб, 2011. 217 дахь тал

⁴⁵ *Давааням А., Монхбаатар Л. Монгол Улсын Бүртгэлийн байгууллагын түүхэн замнал*. Уб, 2010. (Монгол Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 70-н жилийн ойд приурган энэ номын нэгдүгээр бүлгийг мөнөө бие А.Даваанямтай хамтран зохиож, боловсруулсан. Харамсалтай нь зохиогчийн нэрсээ нэрийг мийм засаж, оронд нь Л.Монхбаатарын нэрийг тавьсан байдаг)

⁴⁶ *Огноо бүтээгдсэн бүтээлд түлгүүрлэж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, найруулах, оруулах, хөрвүүлэх, зурмаагүйлэх, эмгэгжх болон бусад хэлбэрээр өөрчлөж, шатээр бий болгосон бүтээлийг үүсмэл бүтээл гэнэ.*

⁴⁷ *Уянга Д. Монгол Улсын зохиогчийн эрхийн тухай хуулийн шатгэчлэлд*. Монголын төр эрх зүй, 2005. №3. 36 дахь тал

аваагүй бол, мөн хамтарсан зохиогч үүсэх нөхцлүүдийн аль нэг нь биелээгүй бол хамтарсан зохиогч хэмээн нэрээ дурдуулах нь зүйд үл нийцнэ.

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3-т "Бүтээлээ нийтлэх эсхүл бүтээлийг ашиглах тухай бичр нэрээ дурдуулах", 11.1.4-т "Бүтээл болон тццний нэрийг зохиогчийн зөвшөөрөлцйгээр аливаа арга хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглоно" гэж зохиогч бүтээлийнхээ хувьд эдлэх эд хөрөнгийн бус хувийн эрхийг хуульчилж өгчээ.

Практикт зохиогчийн нэрийг заахгүй байх, эсвэл гуйвуулах явдал түгээмэл бөгөөд ялангуяа хамтарсан зохиогч бүхий бүтээлийн хувьд хамтарсан зохиогчдоос нэг буюу хэд хэдэн этгээдийн нэрийг орхигдуулсан буюу зохиогчийн нэрээ дурдуулах эрхийг зөрчих явдал элбэг. Мөн бидний өдөр тутмын эрдэм шинжилгээний ажилтай холбоотой зөрчил, тухайлбал хуулиар зөвшөөрөгдсөний дагуу бусдын бүтээлээс эшлэл авахад эх сурвалжийг заахгүй байх нь зохиогчийн нэрээ дурдуулах эрхийн зөрчил болно. Тухайлбал, хамтарсан зохиогч бүхий бүтээлийн тухайд зохиогчийн нэрсийг бүрэн бичилгүй орхигдуулах явдал нэн түгээмэл (гурван хүртэлх зохиогчтой байвал зохиогч бүрийг заавал дурдах, харин түүнээс олон бол эхний зохиогчийн нэрийг төлөөлүүлэн бичиж хэмшсэн байдал практикт их байдаг боловч хоёр болон гурван зохиогчтой бүтээлийн эхний зохиогчийн нэрийг бичээд бусдынхыг нь орхигдуулах явдал цөөнгүй бий).

Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 11.1.4-т заасан "Бүтээл болон тццний нэрийг зохиогчийн зөвшөөрөлцйгээр аливаа хэлбэрээр хувиргах, гажуудуулах, өөрчлөхийг хориглох эрх" нь бүтээл халдашгүй байх эрх мөн. Энэ төрлийн зөрчилд хянан тохиолдуулагч, редакторын зүгээс бүтээлд тодорхой хэмжээний засвар өөрчлөлт оруулахдаа зохиогчоос зөвшөөрөл авалгүй засварлах, өөрчлөх явдал байж болно. Хамтарсан зохиогч бүхий бүтээлийн хувьд авч үзвэл зөвхөн нэг этгээдээс

зөвшөөрөл авах нь учир дутагдалтай. Энэ нь бие даасан хэсэгт хуваагдахгүй бүтээлийн хувьд яригдах бөгөөд редактор, хянан тохиолдуулагчийн зүгээс тухайн бүтээлд засвар өөрчлөлт оруулахаар бол заавал хамтарсан зохиогч тус бүртэй тохиролцож, хамтарсан зохиогч тус бүрийн зөвшөөрлийг авсны эцэст зохих засвар өөрчлөлтөө оруулж болно.

Үүнтэй холбогдуулан зохиогч, хамтарсан зохиогчийн эрх зүйн байдлын талаар холбогдох хууль тогтоомжид хэрхэн зохицуулсныг авч үзье. Зохиогч гэж өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүнийг хэлэх бөгөөд зохиогч бүтээлээ аливаа арга, хэлбэрээр ашиглах онцгой эрх эдэлнэ.

1993 оны Зохиогчийн эрхийн тухай хуульд "1. Бүтээл туурвисан этгээдийг зохиогч гэнэ. 2. Бие даасан хэсэгт хуваагдахгүй хамтын бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг хамтарсан зохиогчид гэнэ. Хамтарсан зохиогчид тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг хамтран эдэлнэ. 3. Бие даасан хэсэгт хуваагдах хамтын бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг нэгдсэн зохиогчид гэнэ. Нэгдсэн зохиогчид тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг хамтран эдлэхээс гадна өөрт хамаарах хэсэгт зохиогчийн эрхийг бусад зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр дангаар эдэлж болно"⁴⁸ хэмээн тус тус ангилан тодорхойлсон байна.

Харин Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 2006 оны шинэчилсэн найруулгад "нэг зорилготойгоор хамтын бүтээлч хөдөлмөрийн цр дүнд нэгдмэл бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг хамтарсан зохиогчид гэнэ, хамтарсан зохиогч бүхий бүтээлийн хувьд зохиогчийн эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол зохиогчид хамтран эдэлнэ"⁴⁹ гэж тодорхойлжээ.

⁴⁸ 1993 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Зохиогчийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Монголын хууль тогтоомжийн түүхэн змтгэл. Наймдугаар боть (1993-1994 он). УБ, 2010. 126 дахь тал

⁴⁹ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 5.1, 5.2 дахь тал

Эл зохицуулалтаас хамтарсан зохиогч үүсэх хэд хэдэн нөхцөл буйг академич С.Нарангэрэл, судлаач Н.Тэмүүлэн нар бүтээлдээ дурдсан байна. Энэ нь

1. Хэд хэдэн этгээдийн хамтын хүчин чармайлтын үр дүндхамтын нэгдмэл бүтээл туурвигдсан байх

2. Бүтээл нь хэд хэдэн этгээдийн хамтын оюуны бүтээлч хөдөлмөрөөр бүтээгдсэн байх

3. Хамтран зохиогчид гэгдэж буй этгээдийн оруулсан хувь нэмэр оюуны бүтээлч шинж чанартай байх

4. Аливаа этгээдийг бүтээлийн хамтарсан зохиогч гэж тооцох нөхцөл нь хамтарсан зохиогч үүсгэх тухай хэлэлцээр байх явдал мөн⁵⁰.

Практикт бүтээл туурвихад ямар ч байдлаар оролцоогүй, эсвэл оюуны бүтээлч хөдөлмөр болон оюуны бүтээлч шинж чанартай ямар нэгэн хувь нэмэр оруулаагүй этгээд хамтарсан зохиогч болох тохиолдол байдаг. Энэ нь нэг талаас ёс суртахууны, нөгөө талаас оюуны өмчийн талаархи “мэдлэг”-ийн түвшинтэй⁵¹ нь холбоотой. Гэхдээ мэдлэгийн түвшин гэхээсээ илүүтэй шууд утгаараа тухайн хувь хүний “ёс суртахуун”-ы байдлыг харуулж буй хэрэг юм.

Мөн хамтарсан зохиогч үүсэх нөхцлийн нэг болох “хэлцэл” нь хэрэг дээрээ мөн л хууль бус аргаар хийгдэх тохиолдол бий. Тухайлбал, “А”, “Б” хоёр этгээд албан үүргийн дагуу бүтээл туурвисан бөгөөд тухайн бүтээлийг хэвлүүлэхийн өмнө “В” ажил олгогчдоо бүтээлээ хэвлүүлэх тухайгаа хэлжээ. Гэтэл ажил олгогч тус бүтээлд өөрийнхөө нэрийг оруулах саналыг шууд илэрхийлээгүй боловч дэм байдлаар ойлгууцгаа байна. А, Б хоёр дургүй байсан боловч тодорхой шалтгааны улмаас оруулахаар болов. Энэ тохиолдолд А, Б, В гурав хэлцэл хийсэн

⁵⁰ Нарангэрэл С., Тэмүүлэн Н. *Зохиогчийн эрхийн тулгуур асуудал*. Ув., 2008. 108-102 дэлгэц талаас дэлгэрүүлэн үзвэ үү.

⁵¹ Дээр дурдсан хамтарсан зохиогч үүсэх нөхцлийн аль нэгийг нь биелүүлэхгүй мэтэдэвчлэн хувьд аргаарлаа. Өөрөөр хэлбэл дээрхи нөхцлүүд нь заримлан нэгэн хэлбэртэй, салхаж үзэ болон шинэгийн агуулжэ байна гэж үзэжэ бишмэч үзэжэ байлш бөгөөд оюуны ямар нэгэн хувь нэмэр оруулалгүй мэтэдэ өөрийнөө “зохиогч мөн” гэжээн үзэжэ буйг түрүүл мэдлэгийн түвшинтэй нь холбожэ үзэжэжэ өөр аргалгүй.

гэж үзэх боловч В-ийн үйлдэл хууль зөрчсөн байна. Өөрөөр хэлбэл энэ хэлцэл нь хүчин төгөлдөр бус хэлцэл болно. Үүнээс үзвэл хамтарсан зохиогч болох нь хамтын оюуны бүтээлч үйл ажиллагаагүйгээр үүсэхгүй ба мөн дан ганц хэлцлээр хамтарсан зохиогч үүсэхгүй гэдгийн хамгийн тод жишээ энэ.

1993 оны Зохиогчийн эрхийн тухай хуулийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор 1997 оны 1 дүгээр сарын 15-нд “Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай” Улсын дээд шүүхийн 15 дугаар тогтоол гарсан байна. Түүнд “Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг зохиох, туурвихад хоёр буюу хэд хэдэн этгээд оролцож тус бүр өөрийн оюуны бүтээлч хувь нэмрээ уг бүтээлд оруулсан бол хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар хамтарсан буюу нэгдсэн зохиогчийн эрх тус бүрт нь үүснэ. Харин материал цуглуулах, зураг, схем зурах зэргээр зохиогчид техник ажиллагааны тусламцаа үзүүлсэн этгээдийг хамтарсан буюу нэгдсэн зохиогч гэж үзэхгүй”⁵², мөн “Хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан *“албан цүргээ гүйцэтгэх журмаар бүтээл туурвисан зохиогч”* гэдэгт тухайн байгууллагад хөдөлмөрийн болон иргэний бусад гэрээ хэлцэл байгуулан ажиллаж байгаа бөгөөд гэрээнд заасан гүйцэтгэх ажлын хүрээнд нь тухайн бүтээлийг туурвих үүрэг тусгасан зохиогчийг хамааруулан ойлгоно. Харин албан үүргээ гүйцэтгэх журмаар бүтээл туурвисан зохиогч тухайн байгууллагатай гэрээ хэлцэл хийгээгүй бол зохиогч нь зохиогчийн амины эрхийг, гэрээнд өөрөөр заагаагүй бол албан үүрэг гүйцэтгүүлж санхүүжүүлсэн байгууллага гэрээ хэлцэлд заасан болзол, нөхцлийн дагуу / зохиогчийн зөвшөөрлөөр/ зохиогчийн эд хөрөнгийн эрхийг тус тус эдэлнэ” гэж тайлбарлажээ.

2006 оны Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд нийгэм, эдийн засаг, техник технологийн

⁵² “Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг тайлбарлах тухай” Улсын Дээд Шүүхийн 1997 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 15 дугаар тогтоол. Монгол Улсын Дээд шүүхийн тогтоолын эмтгэл. 1 дүгээр. 36., 1999. 292 даяг туг

хөгжлийг харгалзан зарим нэр томъёог хэрхэн ойлгох талаарх тодорхойлолтуудыг оруулсан хэдий ч хамтарсан зохиогч тус бүрийн эрх зүйн байдлыг нарийн зохицуулсангүй.

Хамтарсан зохиогч болон бүтээл туурвигчид тусалсан этгээд хоёрыг ялгаж ойлгох шаардлагатай. Практикт энэ хоёр ойлголтыг ялгаж ойлгоогүйгээс, зарим тохиолдолд мэдсээр байж нэр төр хөөцөлдөх зэрэг "эрх мэдлийн давуу байдал"-аа ашиглан зохиогчийн эрхийг зөрчих явдал бий. Ялангуяа хамтарсан зохиогчийг бүтээл туурвигчид туслагч этгээд гэж үзэх, эсрэгээр бүтээл туурвигчид туслагч этгээд нь өөрийгөө хамтарсан зохиогч гэж үзэх зэрэг маргаантай асуудал багагүй тохиолддог.

Үүсмэл бүтээлийн хувьд ч энэ төрлийн зөрчил нэн түгээмэл. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 3.1.9-д зааснаар *"үцсмэл бүтээл"* гэж өмнө бүтээгдсэн бүтээлд тулгуурлаж түүнийг оюуны бүтээлч хөдөлмөрөөр засварлах, найруулах, орчуулах, хөрвөцлөх, хураангуйлах, эмхтгэх болон бусад хэлбэрээр өөрчилж, шинээр бий болгосон бүтээлийг хэлнэ хэмээн тодорхойлсон. Гэтэл практикт эсрэгээр хэрэгжих нь олонтаа. Тухайлбал, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагын ажилтан албан үүргийн дагуу бүтээл туурвихад аль нэг хэлнээс орчуулах, хөрвүүлэх, эсвэл өмнөх бүтээлд тулгуурлан шинээр материал нэмж олж засварлах, найруулах зэргээр өөрийн оюуны бүтээлч хөдөлмөр, цаг заваа тодорхой хэмжээнд зарцуулж бүтээл туурвихад өөрийн оюуны бүтээлч хувь нэмрээ оруулдаг. Энэ үүднээсээ тэд хамтарсан зохиогч мөн бөгөөд бүтээлд нэрээ дурдуулах эрхтэй. Гэтэл хамтарсан зохиогч бус харин бүтээл туурвихад тусалсан этгээд гэгдэн зохиогч мөн болох, нэрээ дурдуулах гэх мэт зохиогчийн хувьд эдлэх эд хөрөнгийн бус хувийн эрх нь зөрчигддөг.

Өмнө дурдсан хамтарсан зохиогч үүсэх хэд хэдэн нөхцлийн агуулга болон **Дээд шүүхийн тайлбар**¹¹, хуулийн зохицуулалтаас

¹¹ Улсын дээд шүүхээс гаргасан эл тогтоол нь 1993 оны Зохиогчийн эрхийн тухай түүхийн зарим эрхл, эвдлт, хэсийг тайлбарласнаас бус Зохиогчийн эрх болон түүнд тэмдэгт эрхийн тухай түүхийн эрхл, эвдлтийг тайлбарлаагүй. 1993 оны Зохиогчийн эрхийн тухай түүхл эрхийн болсон түүд түүхий эрхл, эвдлтийг тайлбарласан Улсын дээд шүүхийн

аваад үзсэн ч хамтарсан зохиогч хийгээд зохиогчид туслагч этгээдийн ялгаатай байдал нэн тодорхой байна. Иймээс зохиогч, хамтран зохиогч, туслагч этгээдийн аль аль нь хуульд заасан өөрийн эрх, үүргийг мэдэж, бие биедээ хүндэтгэлтэй, хамгийн гол нь “ёс зүй”-тэй хандаж байх шаардлагатай байна.

Эцэст нь дээр дурдсан зөрчлийн улмаас ямар сөрөг үр дагавар үүсч болох вэ гэдэг асуудал урган гарна. Юуны түрүүнд тухайн зохиогчийн нэр хүнд, бусдад үнэлэгдэх байр суурь, ялангуяа хамтарсан зохиогч бүхий бүтээлийн хувьд зарим зохиогчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх талтай. Тэрчлэн оюуны өмчтэй харьцах ёс зүйн зөв төлөвшил тогтоогүйгээс, түүний улмаас шинэ санаачлага, бүтээлч эрэлхийлэл унтарч, ажиллах урам зориггүй болох зэрэг сөрөг үр дагавар гардаг. Оюуны өмчийн талаархи зөв мэдлэг, ёс зүйтэй байх явдал нь угтаа “мэдлэг бүтээх чадвар”-ыг хөхиүлэн дэмжих нэг гол нөхцөл мөн.

Иймд бид өөрсдийн оюуны өмчийн эрх зүйн мэдлэгээ эргэн харж, өөрөө өөрсдөдөө дүгнэлт хийх, эрдэм шинжилгээний ажлын ЁС ЗҮЙ-д илүүтэй анхаарал хандуулах шаардлагатай байна.

тус тогтоол нь мөн адил хүчинтэй болох ёстой. Гэвч өмөөг хүртэл тус тогтоолыг хүчинтэй болгосон албан ёсны шийдвэр гаргагч байна. Эл өгүүлэлд тус тайлбарыг зориулж энэ татан дурдсан нь түрний сүлжээ, төмөр мэдээний ач холбогчид нь харилзан цахимтай болно.

SOME ISSUE OF PERSONAL NON-PROPERTY RIGHTS OF AUTHOR'S

Anyone engaged in creative work in cultural and scientific fields that is called 'author', thus it obtains personal non-property rights and property characteristics. Personal non-property rights depend on first author who creates it. It is not transferred to anyone. It is belonging to conflict of copyright that is considered relations between personal non-property rights of author's and conflict of property right. Most of the researchers, who is considered conflict of right in the field of copyright and is divided into following two categories: conflict of personal non-property rights of author's, conflict of property right.

The present paper presents personal non-property rights of author's, its regulation and conflict on the based fact. Therefore, it is considered co-authorship and its legal status. In the fact, it doesn't have unified account. First of all, it is belonging to knowledge of intellectual property and academic moral because we have to pay attention our knowledge of intellectual property and academic moral. Finally, It is derived from conflicts above we seen. It affects negatively to author's reputation especially, for composition of co-authorship. Person who with the knowledge and moral about intellectual property are important factor ability to create knowledge.

Д.ОТГОНТУЯА

Шинжлэхтүг ХЗДС-ийн ахлах бичиг

ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛЭМЖ БА ҮНДЭСНИЙ ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦОО

Хөгжил маань түрхэн дотор байж байдаг

Ч.Эрдэнэ.

Илтгэлийн хүрээнд оюуны өмч гэдэг ойлголтыг хүний оюуны бүтээлч хөдөлмөрийн үр дүнд бий болсон бүтээл, соёлын хэсэг гэх ерөнхий утгаар авч үзэж байгаа болно.

Оюуны өмчийн үнэлэмж ба соёл

Үнэлэмжийн буюу аксиологийн¹ тухай онол нь үүсэл хөгжлийн хувьд залуухан салбар хэдий ч түүний үүрэг, үр нөлөө нь сэтгэлгээний хийгээд практик түвшинд тэргүүлэх чиглэлд тодорхойлогдож байна.

Үнэлэмжийн онол нь юмс үзэгдлийн зөвхөн үнэт зүйлсийг судалдаг гэх нь харьцангуй өрөөсгөл болохыг философичид тэмдэглэжээ.

Үнэлэмжийн онолыг философийн бие даасан салбар болгон хөгжүүлэх эхлэлийг Германы философич Р.Х.Лотцег тавьсан гэж үздэг.Тэрээр "Практик философийн үндэслэлүүд" бүтээлдээ "Бид бодит байдал зөвхөн онтологийн түвшинд хандах нь учир дутагдалтай. Ахуйд үнэлэмжийн олон хэлбэрүүд оршин байдаг. Үнэлэмж нь хүний танин мэдэхүй гадаад ертөнцийг тусгаж байгааг бус, харин ертөнцийн юмс үзэгдэл өөрийн өнгө төрхөөрөө бидний мэдрэмж рүү хандсаныг ойлгоно. Ингэснээр

¹ Аксиологи-/грек, axia-ценность, цэнэ цэнэ/-цэнэт чанарыг үзэх философиин судалгаа. Объектив идеалистууд цэнэт чанар бол орон цагаас ангил чанаруух мөн чанар, субъектив идеалистууд цэнэт чанар бол уламсарин үзэмэл, натуралистууд түрнийг зүрч бийгаль ёсны хэрэгцээний илрэл буюу байгалийн хуулиуд бичлэдээ илэрч буй нь мөн гэж үздэг. Философиин толь, УБ,1990. 15-р тал

хүнд янз бүрийн үнэлэмж бий болж, улмаар хүний хэрэгцээг хөтлөн тодорхойлодог.” хэмээжээ.

Оюуны баримтлагчдын тэмдэглэснээр үнэлэмжийн зорилго нь материаллаг ашиг тус, мэдрэхүйн таашаалд бус сэтгэхүйн үр дүнд буюу өөртөө хандсан байна. Тийм ч учраас үнэлэмж нь аливаа нийгмийн хэм хэмжээний эх сурвалж, үндэс нь болдог.

Оюуны өмчийн үнэлэмжийг хэрхэн тодорхойлох вэ? Оюуны өмчийн хамгаалалтын эрх зүйн зохицуулалат юунд тулгуурлан бүтээгдэх ёстой вэ?

Хүн оюуны бүтээлч хөдөлмөрөөрөө нэг талаас өмчлөлийн өвөрмөц зүйл болох оюуны өмчийг, нөгөө талаас баялагийн салшгүй хэсэг соёлын нэгээхэн хэсгийг бүтээдэг. Энэ зүй тогтоол нь оюуны өмчийн үнэлэмж нь /хүний жинхэнэ бодот хэрэгцээг хангах үнэ цэн нь/ өмчлөлийн зүйлээр бус харин соёлын мөн чанарт тулгуурлан тодорхойлогдоно гэдгийг илэрхийлж байна. Учир нь, өмчлөлийн зүйл ашигтай, соёл үнэ цэнтэй зүйл.

Оюуны аливаа бүтээлийн хувьд субъектын жинхэнэ бодот хэрэгцээг илэрхийлэгч үнэ цэн нь соёлыг илэрхийлэгч болдог өөрийнх нь чанарт агуулагдаж байгаа юм.

Өмчлөлийн зүйл нь өмчлөгчид эдийн засгийн үр өгөөжөө өгдөгт ашигт чанар нь агуулагдаж бол соёлын үнэ цэн нь тухайн үндэстний оршихуйн баталгаа, үндэсний аюулгүй байдлын дархлаа болдогт оршино. Өөрөөр хэлбэл, хүний оюун ухаан соёлыг бүтээдэг ч соёл эргээд хүнийг төлөвшүүлдэг, гэгээрүүлдэг. Соёл нь хүний “нийгэм дэх байгаль”-ийн үүргийг гүйцэтгэдэг. Соёлын энэхүү үүрэг нь хүний хүсэл зоригоос бус түүний өөрийнх нь дүр төрхөөр тодорхойлогдож байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол улсын Үндсэн хуулийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна/7.1/, Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн/7.2/ хэмээн заасан.

Үндсэн хуулийн үзэл баримтлал нь оюуны өмчийг зөвхөн зохиогчийн өмч болох талаас нь төдийгүй үндэсний баялагийг бүрдүүлэгч соёлын хэсэг мөн болохыг бататгасан агуулгатай гэж үзэж болно. Тодруулбал, оюуны өмчийн харицааг зохицуулсан эрх

зүйн зохицуулалтын үндэс нь өмчлөгчийн хувьд эдийн засгийн, нийт нийгмийн хүрээнд соёлын бодлогоор тодорхойлогдох учиртай гэж ойлгогдож байна.

Харин Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлал үндэсний хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан байдлыг Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Патентын хуулийн зорилтуудаас харвал оюуны бүтээлийг үндсэндээ өмчлөлийн зүйл болох талаас нь үнэлж, эрх зүйн зохицуулалтын зорилтыг өмчлөгчийн эрхийг хамгаалах чиглэлд тодорхойлсон байна.

Аливаа эрх зүйн зохицуулалтын зорилго нь хамгаалагдаж буй харилцааны үнэ цэнийг алдагдуулахгүй байлгахад чиглэх учиртай.

Энэ бүтдээс дүгнэвэл, оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтын үндэс нь соёлын мөн чанарт тулгуурлах ёстой. Гэхдээ энэ нь өмчийн халдашгүй байдлыг дордуулах ямар ч сөрөг нөлөө үзүүлэхгүй байх учиртай.

Одоо үед эдийн засагт ч үнэлэмжийн хандлага өөрчлөгдөж, "өмчид суурилсан эдийн засаг"-аас "мэдлэгт суурилсан эдийн засаг"-ийг хөгжүүлэхэд анхаарах болжээ.

Дүгнэлт: Оюуны өмчийн эрх зүйн салбарт үйлчилж буй үндэсний хууль тогтоомжийн нийтлэг үзэл баримтлал нь соёл/соёлын олонлог/-ыг хөгжүүцлэх, өмчлөгчийн эрхийг хамгаалах "юуг бодлого"-ын зохист шийдэлд чиглэсэн байхаар тодорхойлогдох ёстой.

Соёл, ижилсэл, ондоошлал

Соёл² гэх ойлголтыг судлаачид олон янзаар тодорхойлж

2. С.Нарангэрэл. Эрх зүйн эх төлө бичиг: Соёл-эрд түрэм зүйч үедээ хуримтлуулсан мэдлэгээ дамжуулан өвлүүцлэх, түгчдээ зүйч үеэ сургах, хэмийцүүлэх чадвартай холбогдсон хүний мэдлэг, итгэл үнэмшил, элм ажиллын төйлбөр юуг

Д.Бүян. Нийгмийн тухай мэдлэг: Соёл-хүний байнгын, илэрхий, чөлөөт үйл ажиллагааны эр эрд бий болж үлэмжлэгдэж байгаа элм хэмжээ, итгэл үнэмшил, бэлэг тэмдэг, црэт зүйлсийн юуг, хүний хөгжсөн түрэмх юм. Өөрөөр хэлбэл соёл нь хүний олон ажиллагаа юуг юм.

М.Мөнхсайхан. Соёл судлал: Соёл-хүн төрөлзтний түгчлэл бүтээгдэж буй болоод үгт хугацаа орон зайг туулан шалгарч үлдсэн црэт зүйлсийн тогтолцоо юм.

Royanmond Williams. Соёлын хэл хэлэн үгчлэг ач цэсэн. Үүрч, хувь хүний соёл, үрлэг соёлын бүтээлүүд, дэлхийн нийтээрээ нэг соёлтой байх буюу иргэмшил, үгт хугацаа, орон зай хугацаагаар ялгаатай соёлрууд байна.

тайлбарладаг хэдийч үндсэн агуулга нь хүн төрөлхтний бүтээсэн үнэт зүйлсийн цогц юм.

Уламжлалт соёл бол тухайн ард түмний хэл, зан заншил, өв уламжлал гэх мэт ард түмний бүтээн бий болгосон оюуны болон материаллаг үнэт зүйлсийн тогтолцоо, улс үндэстний дархлаа гэх утгыг илэрхийлж болох юм.

Өнөөдөр улс үндэстнүүдийн хувьд “Бид хэн бэ?” гэдэг энгийн асуулын хариулыг улс төр, эдийн засаг, үзэл суртал, цэрэг армийн хүчнээс хайхаасаа илүүтэй өөрсдийн уламжлалт зан заншил, оюун санааны хүч, амьдралын арга ухаан буюу товчхондоо бол өөрсдийн үнэт зүйлс болох соёлоос эрж хайх болов.

Төр улсуудын хувьд дэлхийн түүхэн дэх байр суурь нь тэдний соёлын язгуур мөн чанар, бодлогоор тодорхойлогдох нь зүй тогтол болж байна.

Дэлхий дээр оршин буй бие даасан тусгаар төр улсууд яагаад нэгдмэл нэг нийтлэгийг бүрдүүлж чадахгүй байна вэ? Тэднийг нэг нийтлэг болоход чухам юу саад болж байна вэ? Энд Австралийн жишээг анхааралтай харахад илүүдэхгүй мэт. 1990-ээд оны эхээр Австралийн элчүүд өрнийнхөөс холдож, улс орноо Азийн нийгэм хэмээн тодорхойлж, газар зүйн түншүүдтэйгээ ойр дөт харилцаа тогтоохоор шийдсэн боловч энэ үйл явц төдийлөн амжилтанд хүрээгүй. Энэ тухайд Австралийн ерөнхий сайд Пол Китин, Гадаад хэргийн сайд Гарет Эванс нар “... туурга тусгаар Австралийн онцлог төрхийг хадгалахын тулд ингэх шаардлагатай. Бид Британитай цаанид холбогдож байх нь бидний үндэсний соёл, эдийн засгийн ирээдүй болон Ази, номхон далай дах бидний хувь заяаг ганхуулах болно” хэмээн үзэж байсан бол Малайзын ерөнхий сайд Махатир “Соёлын хувьд Австрали нь Европынх хэвээр байна. Бид тэднийг Европ л гэж боддог. ... Энэ бол миний эсэргүүцэхийн шалтгаан. Гол учир нь арьсны өнгөндөө бус соёлдоо байгаа юм” хэмээсэн нь бий. Мөн Австралийн дипломатч Richard Woolcott “Тус бүс нутаг дах Австралийн жинхэнэ асуудал бол бидний туг далбаа бус,

Е.В.Тугарсоёл иргэншил нь нийтлэл ойлголт гээд мэдлэл, шургал, хувь ёс, ёс эрй, зан заншил, хүний дэглал чадвар зэргийг багтаасан

нийгмийн язгуур үнэт зүйлс маань юм. Энэ бүс нутагт нэгдэн орохын тулд тэдгээр үнэт зүйлээсээ татгалзах нэг ч австрали хүнийг олж харахгүй” гэж хэлсэн байх юм³. Эндээс харахад Азид нэгдэхэд нь Австралийн соёл, нийгмийн үнэт зүйлс нь асуудал үүсгэсэн бололтой.

Төр улсын оршихуйн үндэс нь юунд тулгуурладаг вэ? гэдэг асуултанд:

- нэг угсаа гарвал, соёл бүхий хүмүүсийн ижилсэл⁴/identity/ буюу үндэстэнд⁵ тулгуурласан төр улс
- соёл, зан үйлийн хувьд ялгаатай боловч эдийн засаг, улс төр болон өөр бусад ашиг сонирхолд тулгуурлан бүрэлддэг төр хэмээн ангилж үзэж болох юм.

Хэсэг бүлэг хүмүүс ямар нэг хэв шинжээрээ ижилслийг үүсгэдэг ба энэхүү ижилслээрээ бусдаас ялгардаг. Мөн чанартаа хүмүүсийн ижилсэл нь тэднийг ижилслээрээ бусдаас ялгарахыг илэрхийлсэн ойлголт. Тийм учраас, төр нь хүмүүсийн ондоошилд тулгуурлаж үүсдэг.

Төр улсын баримтладаг иргэний харъяалалын зарчим ч бас ялгаатай байгаа нь санамсаргүй зүйл биш ээ.

Дээрхээс үндэслэвэл Монголын төрийн оршихуйн үндэс нь Монгол хүн. Монголчуудын ижилслийн үндэс Монгол ахуй, соёлд агуулагдаж байна.

Өдгөө хүн төрөлхтөн нийгэм, эдийн засаг, улс төрийн, оюун санааны бүхий л салбарт хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлж, даяаршлагадаж, түүнийхээ үр шимийг хүртэж байгаа нь маргашгүй үнэн. Даяаршил, глобальчлал бидэнд бусдаас суралцах, бусдад өөрийгөө таниулах, тэр хэрээрээ мөн чанараа ухаарч сэхээрэх, сонголт хийх боломжийг олгож байна. Гэхдээ энэ үйл явц хэр

3 С.Хантингтон. *Иргэншил хоорондын мөргөлдөөн, Шинэчлэгдэн буй дэлхийн дэг журам*. УБ.2005

4 Чарлз Тейлор /Charles Taylor. *Multiculturalism and the "Politics of Recognition" 1992/ бүтээлдээ ижилслийг "хүний өөрийгөө хэн гэдэг тухай ойлголт, хүмүүн гэдэг үгднээсээ өөрийнхөө хэн байхыг тодорхойлох тухай ойлголт" гэсэн агуулаар тайлбарласан байна.*

5 Адам Харт Дэвис. *Дэлхийн түүх*. 328-р талд "Үндэстэн гэсэн цэгийг төр улс эсвэл улс орныг тодорхойлоход хэрэглэдэг ба кэдмэл нэн үндэстэн ястан, соёл, хэл ба шашинтай бүлэг ард түмнийг хэлнэ" хэмээн тодорхойлжээ.

удаан үргэлжлэх вэ? Хөгжил өөрөө үргэлжилсэн шулуун шугам уу? эсвэл тодорхой хугацааны мөчлөг үү? Даяаршлын процесс дуусах эсвэл зогсвол тэр үед бид хэн байх вэ? Эндээс бид монгол төрийн оршихуйн үндэс болсон Монгол хүнийг, тодруулбал, бидний ижилслийн агуулга, мөн чанар болсон үндэсний соёлоо хэрхэн хадгаж, хамгаалж үлдэх вэ? гэдэг асуултанд хүссэн хүсээгүй хариулах л хэрэгтэй болно.

Монголчууд бид өөрсдийн түүх, соёл, өв уламжлалаа эрт эдүгээгээс өдгөөг хүртэл нандигнан дээдлэж, баяжуулан уламжлуулж, өвлүүлэн амьдруулж, эрхэмлэн хамгаалж ирсэн баялаг түүхтэй ард түмэн. Өнөө ч энэ бодлого залгамжлагдан хойчид үргэлжлэнэ гэдэг нь лавтай. Гэхдээ энэ нөр их үйл итгэл, хүлээлтээр бус зүтгэл чармайлтаар биежих учиртай.

Үүний тулд “олон жилийн туршид хуримтлагдан, тэр дундаас хөгжиж буй болдог ард түмний дундах дэвшилтэт “үзэл сэтгэлгээ” буюу японоор “шисоо”, англиар “thought” гээч зүйлийг бид яаравчлан арвижуулах хэрэгтэй боллоо. Уламжлалт монгол сэтгэлгээгээ сэргээн амилуулж, сэлбэн баяжуулах замаар 21-р зууны “шинэ монгол хүний” дүр төрх, үнэлэмж, амьдрах хэв маягийг бүрдүүлэх хэрэгтэй болоод байна⁶.” гэдгийг эш үндэс болговол мартагдах, гээгдэхийн эхлэл тохиооод эхэлчихсэн уламжлал соёлоо хамгаалах асуудал чухал зорилт болоод байна.

Энэ чиглэлд хэрэгжүүлж буй олон талт арга хэмжээ үр дүнгээ өгч байгаа төдийгүй эрх зүйн зохицуулалтын орчин ч шинэчлэгдэн хөгжиж байна. Монгол улсын Үндсэн хууль, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал, Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Соёлын тухай, Эрдэнэсийн сангийн тухай, Төрийн албан ёсны хэлний тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулиуд, манай улсын нэгдэн орсон соёлын өвийн чиглэлийн олон улсын конвенциуд нь уламжлалт мэдлэг, ардын урлагийн бүтээлийн хамгаалалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байна. Өв соёлоо хадгаж хамгаалах чиглэлд онцгойлон анхаарч ажиллаж байгааг ч дурдаж болно.

6 Эрин М.Тулгат. Бусгаар тогтносон Монгол. УБ,2005, 55-р тал

Соёлын өвийн “хадгалаат хамгаалаат”, оюуны өмчийн “хамгаалаат” хоёрын хооронд нягт уялдаа төдийгүй зарчмын ялгаа байдгийг бид мэднэ.

Түүх, соёлын аливаа уламжлалын үнэ цэн нь тэрбээр тасралтгүй уламжлан хойчийн хойч олон үед дамжин ирсэн эсэхээс шууд шалтгаалдаг⁷ бөгөөд соёл, тэр дундаа урлагийн бүтээл нь “амьд байж” /хүмүүсийн амьдрал, арга ухаанд хэрэгжиж/ чадаж гэмээ нь хойч үедээ тасралтгүй уламжлагдан өвлөгдөнө гэдгийг ухаарах ёстой. Эс чадваас соёл, урлагийн бүтээлүүд нь “үзмэр”, уламжлалт мэдлэг, арга ухаан маань “мэдээлэл” болох эрсдэлтэйг санууштай.

Уламжлалт соёлыг хамгаална гэдэг нь түүнийг “тахин шүтэх”, “тулган хүлээлгэх”, “нандигнан хадгалах” замаар хэрэгжих боломжгүй бөгөөд үүнийг даяаршлын үйл явц бидэнд бэлхнээ харуулж байна. Харин түүнийг хөдөлгөөнд оруулж, бусдаас хоцролгүй хөгжих бололцоог нээж, хүмүүст сонгогдох боломжийг нь бүрэлдүүлэх замаар хөгжүүлж болох юм.

Нийгэмд олон соёлууд зэрэгцэн хөгжсөнөөр уламжлалт соёл уусах, устах бус харин ч бусдаас ялгарах давуу чанар нь товойн тодорч, хүнд “*уг цндэс*”-ээ мэдэх, мэдрэх, ухаарах боломж олгож, ингэснээрээ соёлд өөрт нь ч сонгогдох бололцоо бүрдэнэ. Үүнд даяаршил туслах бүрэн чадвартай хэдий ч уламжлалт соёлоо “дархлаажуулахгүйгээр” даяаршил гээчид даатгаад зөнд нь орхичихвол “үнэ цэн нь гээгдээд, өмсгөл хувцасаа солиод” өөр нутагт суурьшчих эрсдэл буйг анхаарахгүй орхиж болохгүй.

Дүгнэлт: Монгол төрийн онцлог нь Монгол хүний оршихуйд тулгуурлан бүрэлдсэн, харин Монгол хүний мөн чанар нь үндэсний соёл, ахуйд агуулагддаг хэмээн ухаарваас соёлын салбар /оюуны өмчийн салбар ч хамаарна/-ын хууль тогтоомжийн үзэл баримтлал нь соёлын олонлогийг төдийгүй үндэснийхээ соёлыг хамгаалан хөгжүүлэх, нөлөөллийг өргөжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлогдсон байвал зохилтой.

7 Ч.Эрдэнэ. Их гурвалжин. Угшил ба оргил /тойллуул/ УБ, 2002. 46-р тал

Үндэсний эрх зүйн тогтолцоо-“амьд хууль”-ийн үйлчлэл

“Хууль бол хүмүүсийн сохроор дагадаг яригдсан, бичигдсэн, албан ёсны болсон журмууд биш. Харин хууль хүмүүсийн биеэ авч явах зуршлуудыг тусгасан, түүнийг мөрдсөн хүмүүст үр шимээ өгөх боломжтой, хүмүүсийн ихэнх хувь нь зөвшөөрсөн зан авир, хийх үйлсийн журмуудыг албан ёсны болгосны илэрхийлэл юм⁸”.

Дээрх үгийн утгыг мөшгөвөл, “хууль байгаа учраас хүмүүс түүнийг мөрддөг юм биш, харин хүмүүс хуулийг байлгадаг учраас мөрддөг” гэж ойлгож болох юм.

Зохиогчийн эрхийн болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 8-р зүйлийн 8.1.7-д ардын урлагийн бүтээл, үндэсний зан заншлыг зохиогчийн эрхээр хамгаалахгүй байхаар хуульчилсан. Үүний үндэслэлийг судлаачид “ардын урлагийн бүтээлийн зохиогчид нь тодорхой бус, тэдгээрийн эд хөрөнгийн бус хувийн эрхийг хангах боломжгүй бөгөөд ардын урлагийн бүтээлийг мөнхийн хэмээн зөвшөөрдөг боловч тэдгээрийн хувьд онцгой эрх үйлчлэх хязгаарлалтын хутацаа өнгөрсөн байдаг⁹”, “Ардын урлагийн бүтээлийг хамгаалалтын хүрээнээс хассаны шалтгаан бол тэдгээрийн зохиогчид нь тогтоогддоггүй, зохиогчоор нь ард түмэн болдог явдал юм¹⁰” хэмээн үндсэндээ ижил агуулгаар тодорхойлсон байна.

Эдийн засгийн хөгжлийн онолын гол төлөөлөгч Эрнандо де Сото “Хөгжингүй орнуудын хөрөнгийн системд ажилладаг хүмүүс үндсэндээ өөр зүйлүүдэд анхаарлаа тавьдаг. Тэд ихэнхдээ өмчлөх эрхтэй холбоотой асуудлуудад дарагдсан байдаг. Миний голлон анхаарсан зүйл бол яг өмчлөх эрх биш харин мета-дээд эрх буюу өмчлөх эрхийг эдлэх эрх юм¹¹.” хэмээн өгүүлсэн байх юм.

Эргэцүүлэн бодвол, хуулиар өмчлөгч болохыг нь тогтоосон этгээдийн өмчлөх эрхээс гадна хуулийн гадна хоцорсон хууль ёсны бус “албан ёсны өмчлөгч”-ийн эрхийг хуулийн хүрээнд

8 Margaret Gruter. Law and Mind. London, 1991. P-62/дам шилээ/

9 С.Нарангэрэл, Н.Тэмцүүлэн. Зохиогчийн эрхийн тусламж асуудал. УБ.2008. 89-90-р тал

10 Э.Мягмардорж. Оюуны өмчийн эрх зүйн цэцээн асуудлуул.УБ. 38-р тал

11 Эрнандо де Сото. Капиталын нууц. УБ. 2004. 97-р тал

оруулж ирснээр өмчлөгчийг болоод өмчийг жинхэнэ утгаар нь албан ёсны болгох тухай асуудлыг хөнджээ гэж ойлгож байна. Тодруулбал, үйлчлэн буй хууль тогтоомж нь зохицуулах шаардлагатай харилцааг зохицуулах ёстой түвшинд нь зохицуулж чадсан байхыг ойлгоно.

Өмчийг албан ёсны болгосноор зөвхөн өмчлөгчийн эрхийг хамгаалаад зогсохгүй тэднийг өөрийнхөө болон бусдын өмнө хүлээх үүрэг, хариуцлагатай болгодог, арилжааны аюулгүй байдлыг хангадаг, өмчийг эргэлтэнд оруулж, хөдөлгөөнтэй болгодог, өмчлөгчдийг зах зээлтэй холбож, ингэснээр нэмэлт арилжаа, үйлчилгээнд хамруулах боломж олгодог, харилцагчдын итгэлцлийг үүсгэж, батаалгаажууладаг зэрэг ач холбогдолтой байдлыг бий болгодог.

Мэргэжлийн хуульчдын үндсэн үүрэг энэхүү зорилгод чиглэх ёстой бөгөөд хуульчид "байгаа хууль"-тай ажиллахын сацуу "*байх ёстой хууль*"-ийг байлгахын тулд ажиллах шаардлагатай. Тэдний үүргээ хэр сайн биелүүлснээс үйлчлэн буй албан ёсны хууль "амьд, зөв, үндэслэлтэй болж", хүмүүсийн харилцаанаас ангид бус, хүмүүсийн мөрдвөл зохих зарчим болсноор үйлчлэлийн үр нөлөө нь дээшлэх учиртай. Ийм хуулийг бид эрх зүйт хууль гэж ойлгодог.

Дээрх үндэслэлд тулгуурлан сэдвийн хүрээнд хөндөж буй асуудлын хувьд зохиогч нь тодорхойгүй, нийтийн эзэмшлийн ардын урлагийн бүтээл, уламжлалт мэдлэгийн боломжит хэлбэрүүдийг оюуны өмчийн эрх зүйн зохих түвшний хамгаалалтанд оруулах шаардлагатай төдийгүй боломжтой гэж үзэж байна. Гэхдээ уламжлалт мэдлэг, ардын урлагийн бүтээлүүд нь гарал үүсэл, илэрхийлэгдэх агуулга, хэлбэр хийц, үнэ цэнэ, өнгө төрхөөрөө дахин давтагдашгүй, баялаг агуулга бүхий оюуны илэрхийлэл болох хувьдаа өмчийн эрхийн хамгаалалтын өвөрмөц шийдлүүдийг шаардах нь дамжиггүй.

Улс орнуудын хувьд энэ асуудалд анхаарал хандуулж, тодорхой үр дүнд хүрч байгааг тэмдэглэе¹².

Оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд олон улсын,

¹² Дэлхийн оюуны өмчийн байгууллага. Оюуны өмч ба уламжлалт соёлын бүтээл. №1. Оюуны өмч ба уламжлалт мэдлэг. №2 товчхэмжээг дэлгэрэнгүй үзнэ үү.

Бүс нутгийн эрх зүйн зохицуулалтыг шууд хэрэгжүүлэх гэхээсээ соёл, иргэншлийн хувьд ойролцоо байх гэх шалгуурыг илүүтэй харгалзан үзэх нь зохистой мэт. Бүс нутаг гэх ойлголт нь соёл иргэншлийн нэг нэгдэл гэхээсээ илүүтэй газар зүйн утгыг илэрхийлдэг. Тиймд уламжлалт мэдлэг, ардын урлагийн бүтээлийг хамгаалах асуудлын хүрээнд эрх зүйн болоод эдийн засгийн хувьд хүчирхэгжсэн улс орнуудын сургамжийг харгалзахыг үгүйсгэхгүй боловч "ижил төсөөтэй соёлын үнэлэмж" гэх шалгуур тавих нь оновчтой гэж үзэж байна. Түүнчлэн өөрийн туршлагаа эргэн санах нь багадана уу гэхээс илүүдэхгүй.

Дүгнэлт: Хуулийг өөрчлөх хамгийн гол хүч-хуулийн хүрээнд хамаарагдах харилцаа үйлчлэн буй хуулийн хүрээний гадна бодитойгоор оршин буй явдал мөн.

Эцэст нь өгүүлэхэд:

Улс орнуудад оюуны өмчийн эрх зүйн салбар түүхэн нөхцөл байдал, цаг хугацаа болоод зорилго, чиглэлийн хувьд ялгаатайгаар үүсч бүрэлдсэн боловч эрх зүйн бүлийн шалгуураар хандвал хөгжлийн зүй тогтлын ижил төсөөтэй байдал ажиглагдаж байна.

Нийтлэг /common law/ эрх зүйн бүл бүхий улсуудад зохиогчийн эрхийг /copyright/ өмчлөлийн зүйлийн хэлбэр гэж үзэж, өмчлөлийн бусад зүйлсийн нэг адил өмчийн эдийн засгийн үр дагаварыг хамгаалахад чиглэж байсан бол хувийн /civil law/ эрх зүйн бүл бүхий орнуудад туурвигчийн эрх /author's right/-ийг өмчийн эдийн засгийн агуулгаар нь нийтлэг эрх зүйн бүлийн адил цар хүрээнд хамгаалах төдийгүй бүтээлээ өөрийн нэрээр нэрлүүлэх, бүтээлдээ нэр өгөх зэрэг эрхийг ч бас хамгаалж байжээ.

Оюуны өмчийн эрх зүйн салбарын хөгжлийн эхэн үед улс орнууд эрх зүйн зохицуулалтын бодлогоо оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон өмчлөлийн зүйлийн ашигтай чанарыг нь баталгаажуулах чиглэлд тодорхойлж ирсэн нийтлэг дүр төрх анзаарагдаж байна. Үүнд оюуны өмчийн эрх зүйн салбар үүсч хөгжих шаардлага бий болсон үеийн түүхэн нөхцөл байдал, оюуны өмчийн үнэлэмж нөлөөлсөн биз ээ.

Орчин үед оюуны өмчийн салбарт сэтгэлгээний хийгээд практик шинэчлэлүүд хийгдэж, тэр хэрээр эрх зүйн шинэлэг зохицуулалтууд үүсэн бий болж буйн нэг илрэл нь уламжлалт мэдлэг, уламжлалт соёлын бүтээлүүдийн оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтын асуудал хөндөгдөж, үр дүн нь гарч байгаа явдал мөн.

Уламжлалт мэдлэг, соёлын бүтээлийг эзэмшигчид асуудалд өөрсдийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, бусдын хууль бус ашиглалтаас хамгаалагдах, шударга өрсөлдөөнийг дэмжих зэргээр эдийн засгийн хэрэгцээ шаардлагын үүднээс хандахаас гадна хамгийн гол нь соёлын бодлогын үүднээс хандаж байгаа нь тэдний өөрсдийн хүсэл эрмэлзлэл, хамгаалалтын хэлбэрийн оновчтой шийдлүүдээс тод харагдаж байна. Үүний илэрхийлэл бол АНУ-ын Индиан үндэстний урлаг, гар урлалын тухай хууль, Тай анагаах ухааны уламжлалт мэдлэгийг хамгаалах, дэмжих хууль¹³ зэргийг дурдаж болно.

Уламжлалт соёлын бүтээлүүдийг оюуны өмчийн эрх зүйгээр хамгаалахын ач холбогдол нь соёлын болон эдийн засгийн хувьд үр өгөөжтэй төдийгүй тухайн бүтээлийн хувьд “эргэж ирэх баталгаа” нь болно.

Манай улсын хувьд уламжлалт мэдлэг, ардын урлагийн бүтээлүүдийг оюуны өмчийн хамгаалалтанд авах зайлшгүй шаардлагатай юу? гэдэгт анхаарал хандуулах цаг тулжээ.

Илтгэл бүхэлдээ энэ асуултанд “шаардлагатай” гэсэн хариулт өгөх үндэслэлүүдийг тодорхойлохыг зорьсон болно.

Эцэст нь тэмдэглэхэд уламжлалт мэдлэг болон ардын урлагийн бүтээлийг оюуны өмчийн эрхээр хамгаалах асуудал нь зөвхөн соёлын болон хууль, эрх зүйн бодлогоор хязгаарлагдах боломжгүй бөгөөд эрүүл мэнд, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, аялал жуулчлал, боловсролын зэрэг “цогц бодлого”-оор нөхцөлдсөн олон талт, өргөн хүрээтэй “ТОМ” асуудал, түүнийхээ хэрээр үр дагавар “ҮЛЭМЖ ТОМ” асуудал мөн.

**Соёлын олонлогийг хэдий чинээ хөгжүүлнэ
уламжлалт соёлын үнэ цэн төдий чинээ тодорно.**

¹³ Дэлхийн оюуны өмчийн байгууллага, Оюуны өмч ба уламжлалт соёлын бүтээл, №1, Оюуны өмч ба уламжлалт мэдлэг, №2 тогтоомлоос дэлгэрэнгүйг үзнэ үү.

INTELLECTUAL PROPERTY RATING AND NATIONAL LEGAL SYSTEM

With his creative intellectual work, man creates intellectual property — particular ownership item in one side and a part of culture — inseparable part of wealth in other side. In this case, the rating object (according to axiology) of intellectual property will be the culture, not be a ownership item. Because ownership item is profitable and the culture is valuable.

Profitability of the ownership item gives economic effectiveness to its' owners and value of culture becomes a verification of a nation's existence and an immunization of national security. In other words, however man's spirit creates culture but the culture forms and enlightens a man, in turn. Therefore, the culture performs the responsibility of "nature in human society".

Today, nations seek the answer of a simple question "Who we are?" from their traditional custom, spiritual power, living methods or briefly from their culture — the value of their living instead of seeking it from the power of politics, economy, ideology and military force.

For the answers of the question "What does the existing ground of a state base on?", we can classify as follows:

- Based on the identity of persons from same root and culture.
- A state based on economical, political and other interest however which are different in cultural behavior and etiquette.

As well as, different citizenship principles are administered by all states and countries is not an accidental thing.

If we think that the features of Mongolian state are formed and based on Mongolians existence and the nature of Mongolian man is contained in national culture and behavior, then we have to determine the legislation concept of a cultural sector (intellectual property is included, too) in such manner that aims to protect and develop national culture and to expand its' influence not only covering cultural sets.

The value of any historical and cultural traditions exist on directly whether its' continuous inheritance from generations to generations and we have to grasp that the culture especially art creations will be continuously handed down generations if they can survive "alive" (in human's living and spirit). Unless, we have to remember that the culture and art creations will become "showpiece" and our traditional knowledge and living methods will change into common "information".

Modern time, mentality and practical reforms are made in intellectual property sector, following this, newer legal regulations formed and one of examples for this is intellectual property legal protection issues for traditional knowledge and traditional cultural creations are raised and substantial results have been shown.

Based on above grounds, according to the topic in this article, we think folklore creations and other available types of traditional knowledge which authors are anonymous should be taken under the proper level of legal protection for intellectual property. But traditional knowledge and folklore creations which are considered as spiritual expressions of singularities according to their origin, expression, content, form and structure, value and image will probably require specific property right solutions for protection.

ДЭВИД КОЛЛЕР

БНСУ-ын Хандуны Олон Улсын хууль зүйн
сургуулийн Профессор

АНУ ОЮУНЫ ӨМЧИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ХЭРХЭН ТЭМЦЭЖ БУЙ ТУХАЙ

№1. Оршил

Оюуны өмчийн гэмт хэрэг нь ямарваа нэгэн хохирогч байдаггүй гэмт хэрэг бөгөөд энэ нь өөрөөр хэлбэл хулгай юм. Бусдын бүтээлч санаа болон хөдөлмөрийг хулгайлан зах зээл дээр гарган ашиг олохыг оюуны өмчийн гэмт хэрэг гэнэ. Энэ нь дан хувь хүн болон хувь хүмүүсийн оюуны өмчийг дээрэмдээд зогсохгүй хөдөлмөрийнх нь шан харамжийг хүртэл авдаг. Энэ нь цаашилбал АНУ-ийн эдийн засгийн бүрэн бүтэн байдалд аюул учруулдаг. Ийм учраас АНУ-д оюуны өмчийн гэмт хэргийн тухай хуулийг эн тэргүүний зорилт болгон хэрэгжүүлдэг юм.

Энэ нэлтгэл нь АНУ-дахь оюуны өмчийн гэмт хэрэгтэй тэмцэх болон сэргийлэх үйл ажиллагааны тухай мөн оюуны өмчийн гэмт хэргийн тухай ерөнхий ойлголт өгөх болно. Нэгдүгээрт ямар оюуны өмч нь АНУ-ийн эрүүгийн хуулиар хамгаалагдсан байх вэ? Хоёрдугаарт ягаад оюуны өмчийн гэмт хэрэгтэй тэмцэх нь чухал вэ? Гуравдугаарт оюуны өмчийг хэрхэн хулгайладаг вэ?

№2 Ямар оюуны өмч нь АНУ-ийн эрүүгийн хуулиар хамгаалагдсан байдаг вэ?

АНУ-ийн хуулинд материалаг өмчтэй байхыг хүлээн зөвшөөрдөг, үүнтэй адил материалаг бус өмч буюу аливаа зүйлийн шинэ санаа болон шинэ бүтээлийн нээлт зэрэг өмчийг эзэмшихийг хүлээн зөвшөөрдөг байна. Өөрөөр хэлбэл АНУ-д зохиогчийн эрхтэй, худалдааны тэмдэгтэй, худалдааны нууцлал зэргийг багтаасан биет бус хөрөнгө буюу оюуны өмчтэй байхыг хүлээн зөвшөөрдөг. АНУ-ийн холбооны хуулийн хамгаалалтаар хангагдсан зохиогчийн эрхийн хууль **copyrightlaw** нь тухайн

зохиогчийн бүтээлийг хуулбарлах, хууль бусаар тараахтай (програм хангамж, утга зохиол, дуу хөгжим) тэмцэх буюу таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлдэг. Зар сурталчиглааг ашиглан танигдсан барааг худалдааны тэмдэгтийн **trademark law** хуулиар хамгаалдаг. Энэ нь зарим нэг үг, нэр, тэмдэгийг хууль бусаар ашиглахыг таслан зогсоох, мөн дуурайлган хийх зэргийг хязгаарладаг. Эцэст нь барааны нууцлалын тухай хууль **trade secret law** энэ нь тухайн барааны мэдээлэл, томъёо, орц жор, зэрэг алдагдахаас сэргийлдэг

№3 Яагаад оюуны өмчийн гэмт хэрэгтэй тэмцэх нь чухал вэ?

Зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй, худалдааны тэмдэгттэй, худалдааны нууцлалтай бараа буюу оюуны өмч нь АНУ-ын эдийн засагт асар их хэмжээний ач холбогдол үзүүлдэг. Учир нь олон улсын оюуны өмчийн төвийн гаргасан мэдээлэлээр АНУ-ын нийт экспортын зах зээлийг 100% гэж үзвэл түүнийг мөнгөн дүнгтэй харьцуулсан тооцоо 5.8 тэрбум доллар, үүнээс оюуны өмчийн зах зээл нь нийт зах зээлийн 74% буюу 1 тэрбум доллартай тэнцэх хэмжээний зах зээл үүссэн гэж үзсэнэ. Оюуны өмчийн эрх чөлөөг хамгаалахын тулд ажилгүйчүүдийг ажлын байраар хангаж дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц хэмжээний өрсөлдөөнийг бий болгох нь чухал юм.

Мөн нэмж хэлэхэд оюуны өмчийн гэмт хэрэгтэй тэмцэх болон сэргийлэх эрх зүйн зохицуулалт нь бүтээгдэхүүнийг аюулгүй, найдвартай, чанартай байлгахад чухал үүрэгтэй ба энэ нь хэрэглэгчдийн аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах нэг түлхүүр юм. Жишээлбэл хуурамчаар хийсэн онгоц болон машины цахилгаан хэрэгслийн худалдаа нь хэрэглэгчийг хууран мэхлээд зогсолгүй, түүний аюулгүй байдал, эрүүл мэндэд хүртэл аюул учруулж болно. Үүний үр дүнд Америкийн засгийн газар тасралтгүй оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтыг сайжруулж өргөтгөсөөр байгаа юм.

Хэрхэн оюуны өмч хулгайлагдаж болох вэ?

Оюуны өмч нь олон тооны аргаар хулгайлагдаж болно. Жишээлбэл зохиогчийн эрхээр хамгаалагдсан аливаа программ хангамж, дуу, кино, ном зэргийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр дахин хийж нийтэд тараах зорилгоор интернет ашиглах, гар аргаар хууль бус CD, DVD хийх зэргээр илэрч болно. Барааны тэмдэг нь барааг зарахдаа хуурамч дууриалган хийсэн барааны тэмдэг ашиглахаар илэрнэ. Нэмж хэлэхэд, үйлдвэрлэгчийн өндөр хамгаалагдсан нууцыг гаднаас эсхүл дотроос нь хулгайлж өрсөлдөгчид худаалдах үйл явц ч үүнд багтана.

Ямар тохиолдолд оюуны өмчийн зөрчил нь гэмт хэрэг болох вэ?

Хувь хүн болон компаниуд нь учирсан хохирлоо мөнгөн хэлбэрээр шаардаж иргэний хэрэг маргаан үүсгэн, хууль бус үйлдлийг зогсоолгох буюу хориглуулахаар нэхэмжилж болно. Гэсэн хэдий ч техник, технологийн талаар мэргэшсэн хулгайчийн өнөөгийн технологи хөгжсөн орчинд хийж буй үйлдэл нь уламжлалт иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шийдвэрлэх нь нь цаг хугацаа, арга барилын хувьд зохимжгүй юм. Үүний улмаас заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь үүнийг зогсоох гол арга болж байна. Америкийн засгийн газар нь хэлэхэд оюуны өмчийн гэмт хэрэгтэй тэмцэх болон сэргийлэх эрх зүйн зохицуулалтыг, мөн түүний эрүүгийн хариуцлагыг сайжруулан өргөтгөсөөр байна. Үүнд:

Оюуны өмчийн эрүүгийн зөрчил:

Оюуны өмч зөрчигч этгээд нь 180 хоногийн дотор 10-с дээш хуулбар хийсэн эсхүл тараасан этгээдэд 3 жил хүртэлхи хугацаагаар хорих, эсхүл 250,000 доллараар торгох заалт байдаг. Ялын дээд хэмжээ 5 жил байдаг ба хэрвээ худалдааны ашигтай байдал олж авахын тулд хувийн эрх ашгийн төлөө гэмт хэрэг үйлдсэн бол эл ялыг онооно.

Оюуны өмчийг хугацаанаас нь өмнө нийтэд цацаж, тараах

Оюуны өмчийг гаргахаас нь өмнө олон нийтэд аливаа мэдээллийн хэрэгслээр цацаж тараасан тохиолдолд 3 хүртэлхи жил хорих эсхүл 250,000 доллараар торгохоор зохицуулсан байдаг. Ялын дээд хэмжээ 5 жил байдаг ба хэрвээ худалдааны ашигтай байдал олж авахын тулд хувийн эрх ашгийн төлөө гэмт хэрэг үйлдсэн бол эл ялыг онооно.

Камераар бичлэг хийх:

Нийтийн үзвэрийн газар буюу кино театрт бичлэг хийхийг оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтаар хориглодог. Хэрэв уг этгээд нийтийн үзвэрийн газарт гарч буй аливаа бичлэгийг нийтэд тараах эсхүл хуулах зорилгоор бичлэг хийсэн тохиолдолд 250,000 доллараар торгоно.

Барааны тэмдэгийг хууль бусаар үйлдэх:

Барааны тэмдэг нь барааг зарахдаа болон аливаа үйлчилгээнд түүнийг хуурамчаар дууриалган хийсэн барааны тэмдэг ашигласан тохиолдолд барааны тэмдэгийн тухай хуулиар 10 хүртлэх жилээр хорих, эсхүл 2 сая долларын торгууль ногдуулна. Хэрэв зөрчигч этгээд эм, цэргийн аливаа бараа бүтээгдэхүүний тэмдэгийг ашигласан бол 20 хүртэлхи жилээр хорих, эсхүл 5 сая доллараар торгуулна.

Шошго тэмдэг хуурамчаар үйлдэх:

Шошго тэмдэгийн тухай хуулийн дагуу бараа бүтээгдэхүүн кино үзвэр, дуу, программ хангамж, зурган болон графикийн бүтээлд зориулан хийсэн шошго тэмдэгийг хууль бусаар ашигласан тохиолдолд 5 хүртэл жилээр хорих, эсхүл 250,000 доллараар торгох ял онооно.

Худалдааны нууцыг хулгайлах:

Эдийн засгийн тагнуулын ажиллагаатай тэмцэх хуулийн дагуу 2 төрлийн үйлдлийг худалдааны нууцыг хулгайлах гэмт хэрэг гэж үздэг. Эхний төрөл нь засгийн газрын нууцад халдан тагнуулын үйл ажиллагаа хийсэн тохиолдолд 15 хүртэлхи жилээр хорих эсхүл 5 сая долларын торгууль төлүүлдэг. Хоёрдахь төрөл нь худалдааны нууцыг эзнээс нь өөр хүнд зарж ашиг олсон тохиолдолд 10 хүртэл жилээр хорих, эсхүл 250,000 доллараар торгох ял оноодог. Хэрэв зөрчигч нь компани байвал түүний ял илүү хүндэрнэ. Худалдааны нууц гэдэг нь дотроо олон зүйлийг багтаах бөгөөд үүнийг тодорхойлбол эзэмшигч нь тухайн зүйлийг нууц гэж үзсэн, эдийн засгийн өгөөжтэй зүйлийг хэлнэ. Холбооны эрүүгийн хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх үед мөн түүнтэй холбоотой аливаа нууцыг хадгалахыг шаарддагтай адил юм.

Оюуны өмчийн гэмт хэргээс хамгаалах аргууд

Оюуны өмчийн гэмт хэргээс хамгаалах аргууд нь ямар төрлийн гэмт хэрэг вэ гэдгээс хамааран өөр өөрөөр зохицуулагдсан байдаг. Оюуны өмчийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын дагуу хамгаалалт нь оюуны өмчийг худалдаалах, оюуны өмчийг шударгаар ашиглах, компьютерт хадгалахтай холбоотой зохицуулаалууд байдаг. Эхний буюу оюуны өмчийг худалдаалахтай холбоотой хамгаалалт нь худалдан авагч нь өөрт байгаа оригинал хувилбараа ямар нэг байдлаар дахин хувилаж бусдад зарахгүй байх ёстой. Оюуны өмчийг шударга ашиглахтай холбоотой хамгаалалт нь дараах байдлаар оюуны өмчийг ашиглахыг зөвшөөрнө. Үүнд: Шүүмжлэл, тайлбар, мэдээгээр гаргах, хичээл заах, эрдэм шинжилгээний зориулалт болон судалгааны зорилгоор ашиглахыг хэлнэ.

Барааны тэмдэгийн эрүүгийн хамгаалалтад нь илүүдэл бүтээгдэхүүн, саарал зах зээл, оригинал бүтээгдэхүүнүүдийг савлах үйл ажиллагаа зэрэг орно.

Илүүдэл бүтээгдэхүүний нөхцөлд юут хамааруулж үзэх вэ гэвэл, жишээ нь, захиалагч 1000 ширхэгийг хийлгэх захиалга өгсөн боловч 5000 ширхэгийг хийсэн байх нөхцөлийг хэлнэ. Саарал зах зээл нь бараа бүтээгдэхүүн ямар нэг эрх зүйн зөрчилгүйгээр буюу хуулийн дагуу Америкийн нутаг дэвсгэрээс гадуур зарагдах, тухайлбал, Олон улсын худалдааны веб хуудас болох E-Вau хуудсаар зарагдсан бүтээгдэхүүнүүд орно. Сүүлд нь оригинал бүтээгдэхүүнүүдийг савлах үйл ажиллагаа орно. Энэ нь хэн нэгнийг хууран мэхлэх зорилгогүйгээр бараа бүтээгдэхүүнийг хуулийн дагуу ямар нэг зөрчилгүй хайрцаг саванд хийх, барааны тэмдэг наах зэрэг үйл ажиллагаанууд орно.

Дүгнэлт

Оюуны өмчийн гэмт хэрэг нь хулгай мөн бөгөөд энэ нь хувь хүний болон Америкийн эдийн засагт хохирол учруулж буй үзэгдэл юм. Энэ нь хүний шинэ санааг хулгайлан өөрийнх болгож, түүнээс эдийн засгийн ашиг олж буй үйл ажиллагаа юм. Учир нь оюуны өмч нь Америкийн эдийн засгийн салшгүй хэсэг, чухал салбар бөгөөд үүнийг хамгаалахын тулд оюуны өмчийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах нь Америкийн чухал зорилт болоод байгаа юм. Энэхүү илтгэл нь дээрхи зохицуулалтыг товчхон буюу тойм байдлаар харуулсан ба энэхүү зохицуулалтууд нь ирээдүйд гарах асуудлыг шийдвэрлэхийн тулд цаашид хөгжсөөр байх болно. Иймээс ирээдүйд тулгарах асуудлуудыг шийдвэрлэхийн тулд Америкийн оюуны өмчийн эрх зүйн зохицуулалт оюуны өмчийн хулгайчдаас ядаж нэг алхам урд байх ёстой юм.

Prof. DAVID COLLIER,

Handong International Law University, Republic of Korea

UNITED STATES INTELLECTUAL PROPERTY CRIME ENFORCEMENT

I. Introduction

Intellectual Property ("IP") crime is not a victimless crime. It is theft. It is the stealing of another's creative ideas and the labor it took to bring those ideas to the marketplace. It not only personally robs the individual or individuals of just compensation for their labor, but it also jeopardizes the very well-being of the U.S. economy. Accordingly, preventing IP crime has become a priority for U.S. law enforcement.

This paper provides an overview of the IP Crime Enforcement Structure the United States has created in its on-going attempt to prevent IP crime. First, it looks at what IP is protected by U.S. criminal law. Second, it discusses why IP crime enforcement is important. Third, it explains how IP can be stolen. Fourth, it examines when IP infringement becomes a U.S. federal crime. Lastly, it looks at some available defenses to IP criminal charges.

II. What Intellectual Property is Protected by U.S. Criminal Law?

Much the same way as the law recognizes property ownership rights in tangible items such as automobiles and houses, the law also recognizes rights in intangible property, such as the expression of an idea or an invention. The United States recognizes enforceable rights in "intangibles" that are known as intellectual property, including copyrights, trademarks, and trade secrets. Copyright law provides U.S. federal law protection against infringement of certain exclusive rights, such as reproduction and distribution, of "original works of authorship," including computer software, literary works, musical works, and

motion pictures. The use of a commercial brand to identify a product is protected by trademark law, which prohibits the unauthorized use of "any word, name, symbol, or device" used by a person "to identify and distinguish his or her goods, including a unique product, from those manufactured or sold by others and to indicate the source of the goods." Lastly, trade secret law prohibits the unauthorized disclosure of any confidential or proprietary business information, such as a formula, device, or compilation of information, but only when that information possesses an independent economic value because it is secret and the owner has taken reasonable measures to keep it secret.

III. Why Is Intellectual Property Crime Enforcement Important?

Intellectual Property (IP), including copyrighted creative works, trademarks used for brand identification, and trade secrets, makes an enormous contribution to the U.S. economy. According to the Global Intellectual Property Center, America's IP is worth \$5.8 trillion and accounts for 74% of all U.S. trade exports- amounting to almost \$1 trillion. In addition, IP-intensive industries account for 38% of total U.S. GDP and employ over 55 million Americans. Protecting IP rights helps to create and preserve jobs and fosters economic growth by ensuring fair competition in the world marketplace. Moreover, the enforcement of IP rights incentivizes artists, companies, entrepreneurs, and investors to dedicate resources for research, development, and marketing of creative works and new technologies that help drive the U.S. economy. As one court stated, "[t]he future of the nation depends in no small part on the efficiency of industry, and the efficiency of industry depends in no small part on the protection of intellectual property." Additionally, criminal enforcement of IP rights protects the health and safety of consumers by helping to ensure that products are safe, reliable and authentic. For example, the sale of dangerous counterfeit electrical equipment, automobile parts and airplane parts not only defrauds consumers but also presents serious risks to their health and safety. As a result, the U.S. government has

been continually expanding and strengthening criminal IP enforcement laws.

IV. How can Intellectual Property be Stolen?

Intellectual property can be stolen in numerous ways. For example, copyrighted works, such as software, music, movies, and books, may be criminally infringed upon by distributing or reproducing copies on the internet or by physically manufacturing and distributing illegally-copied DVDs or CDs. A trademark can be infringed upon by selling goods, labels or other packaging that contains a counterfeit trademark. In addition, a highly protected trade secret can be stolen by a company insider or by someone outside a company and sold to a competitor of the original owner.

V. When is Intellectual Property Right Infringement a U.S. Federal Crime?

Individuals and companies can pursue civil remedies such as injunctions and monetary damages in order to try to protect their intellectual property. However, due to technologically sophisticated thieves, technological complexity, advances in computer technology, and slow-moving civil litigation processes, civil remedies are often inadequate to deter individuals from infringing upon others' intellectual property rights. As a result, criminal sanctions are often necessary to ensure appropriate punishment and deterrence of wrongful intellectual property infringement. The U.S. government has been expanding and strengthening criminal laws related to the infringement of intellectual property rights. Among the most significant provisions are the following:

- **Criminal Copyright Infringement:** Copyright infringement is a felony punishable by up to three years' imprisonment and a \$250,000 fine where a defendant willfully reproduces or distributes at least ten copies of one or more copyrighted works with a total retail value of more than \$2,500 within a 180-day period. The maximum penalty rises to five years' imprisonment if the defendant also acted "for purposes of commercial advantage

or private financial gain." Misdemeanor copyright infringement occurs where the value exceeds \$1,000 or where the defendant willfully violated any of the exclusive rights "for purposes of commercial advantage or private financial gain."

- **Pre-Release Criminal Copyright Infringement:** Pre-release piracy, *i.e.*, willful infringement "by the distribution of a work being prepared for commercial distribution, by making it available on a computer network accessible to members of the public, if such person knew or should have known that the work was intended for commercial distribution," is a felony punishable by up to three years' imprisonment and a \$250,000 fine. The maximum penalty rises to five years' imprisonment if the defendant also acted "for purposes of commercial advantage or private financial gain."
- **Camcording:** The Family Entertainment and Copyright Act criminalizes the use of camcorders and similar devices to record movies playing in public theaters. "Camcording" is a felony punishable by up to three years imprisonment' and a \$250,000 fine where a defendant "knowingly uses or attempts to use an audiovisual recording device to transmit or make a copy of a motion picture. . . . in a motion picture exhibition facility."
- **Counterfeit Trademarks:** The Trademark Counterfeiting Act provides penalties of up to ten years' imprisonment and a \$2 million fine for a defendant who intentionally "traffics in goods or services and knowingly uses a counterfeit mark on or in connection with such goods or services," or intentionally "traffics in labels, . . . documentation, or packaging . . . knowing that a counterfeit mark has been applied thereto." This Act provides penalties of up to twenty years' imprisonment and a \$5 million fine for a defendant who intentionally traffics in counterfeit drugs or certain counterfeit military goods or services.
- **Counterfeit Labeling:** The counterfeit labeling provisions of 18 U.S.C. § 2318 prohibit trafficking in counterfeit labels designed to be affixed to movies, music, software, and literary, pictorial, graphic, or sculptural works and works of visual art as well as

trafficking in counterfeit documentation or packaging for such works. Violations are punishable by up to five years' imprisonment and a \$250,000 fine.

- **Theft of Trade Secrets:** The Economic Espionage Act contains two separate provisions that criminalize the theft of trade secrets. The first provision prohibits the theft of trade secrets for the benefit of a foreign government, instrumentality, or agent, and is punishable by up to 15 years' imprisonment and a \$5,000,000 fine. The second provision prohibits the commercial theft of trade secrets to benefit someone other than the owner, and is punishable by up to ten years' imprisonment and a \$250,000 fine. The penalties are higher for defendants who are companies. The statute broadly defines the term "trade secret" to include all types of information that the owner has taken reasonable measures to keep secret and that itself has independent economic value. Federal law also provides special protections to victims in trade secret cases to ensure that the confidentiality of trade secret information is preserved during the course of criminal proceedings. Specifically, the statute expressly states that courts "shall enter such orders and take such action as may be necessary and appropriate to preserve the confidentiality of trade secrets, consistent with the requirements of the Federal Rules of Criminal and Civil Procedure, the Federal Rules of Evidence, and all other applicable laws."

These major statutory provisions address the three main areas of IP infringement, copyrights, trademarks and trade secrets, by providing a mechanism for the U.S. government to criminally prosecute the most egregious IP right violators.

IV. What are the Available Defenses to IP Crimes?

The available defenses for IP crimes vary depending upon the area of criminal IP infringement. With regards to criminal copyright infringement, the defenses include the first sale defense, the fair use defense and the archival exception for computer software. The first

sale defense allows the first purchaser and any subsequent purchaser of a specific lawfully made copy of a copyrighted work to sell, display (privately), or dispose of their copy, but she may not reproduce and distribute additional copies made from that work. The fair use defense allows an otherwise infringing use of a work for purposes such as criticism, comment, news reporting, teaching (including multiple copies for classroom use), scholarship, or research. Lastly, the archival exception for computer software allows an owner of a copy of a computer program to copy the program as necessary to use the program, to do machine maintenance or repair, or to make an archival backup, subject to certain limitations.

The available defenses for criminal trademark infringement include the overrun goods defense, the gray market goods defense and the repackaging of genuine goods defense. The overrun goods defense involves the situation where the defendant had authorization to make copies of goods but exceeded it (i.e., the defendant was authorized to make 1,000 copies but made 5,000). The gray market goods defense consists of the situation where goods are legitimately manufactured and sold overseas (typically at a reduced priced pursuant to a licensing agreement with the U.S. IP owner) and then imported into the U.S. outside traditional distribution channels, such as through an E-bay retail seller. Lastly, there is the repackaging of genuine goods defense. This is the situation where genuine goods are repackaged with genuine marks or reproduced marks, and there is no intent to deceive or confuse on the part of the defendant.

With regards to trade secret theft, the defenses include parallel development, reverse engineering and claim of right. Parallel development is when the defendant discovers information underlying a trade secret through his own independent efforts. Reverse engineering is "the process by which a completed process or device is systematically broken down into its component parts to discover the properties of the product with the goal of gaining the expertise to reproduce the product." In other words the defendant takes the thing apart to determine how it works or how it was manufactured. A claim of right

means that a defendant's *mens rea* might be negated if he believed in good faith that he had a right to use the information, either because it was in the public domain (e.g., posted on the internet) or because it belonged to him.

I. Conclusion

IP crime is theft, directly harming the individual as well as the U.S. economy in general. It is the stealing of another's ideas and the commercial manifestation of those ideas. Because IP has become such a significant part of the U.S. economy and its standing in the global markets, preventing IP crime has quickly become a priority for U.S. law enforcement. While this paper provides an overview of certain aspects of the current IP Crime Enforcement Structure in the United States, that structure will continue to evolve in order to meet future challenges. In order to meet these challenges, U.S. law enforcement will need to stay at least one step ahead of the IP thieves and will need the cooperation of the international community.

Ц.ЭНХГЭРЭЛ

Цагдаагийн Ерөнхий газрын хэллэл, мэдээллийн төвийн сүлдлөгч

“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САЛБАР ДАХЬ ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ”

Нийгмийн хөгжлийг урагшлауулах чухал гол хүчин зүйлийн нэг нь хүний оюун ухааны хүчин чадавхи оюуны хөдөлмөрийн үр дүн байдаг. Аливаа хүн төрөлхтөн уураг тархиныхаа ухамсарт үйл ажиллагааны үндсэн дээр байгаль нийгэм зүй тогтол, үзэгдэл юмсын мөн чанарыг танин мэдэж түүндээ тулгуурлан эдийн ба оюуны баялгийг бүтээн туурвиж нийгмээ хөгжүүлдэг. «Сэдэх суу ухаан бол баялгийн эцэг мөн» гэж эртний гүн ухаантан Сократ суут мэргэнээр хэлсэн байдаг.

Хүний ухамсартай үйлдэл бүхэн хууль зүйн хэллэгээр гарал үүслийн хувьд оюуны бүтээгдэхүүн байдаг бөгөөд оюуны хөдөлмөрийн бүтээл нь зуунаас зуунд дамжин хөгжиж ирсэн түүхтэй.

Манай эриний өмнөх гурван мянгаад жилийн өмнөөс цаг хутацааг нараар хэмжиж болохыг анх сэдсэнээр МЭӨ 2000 онд анхны элсэн цаг, 1657 онд дүүжинг цаг, 18 дугаар зуунд механик цагны анхны эх загвар, 1840 онд цахилгаан цаг, 1888 онд секунд заадаг цаг үүсэж гарсан бол одоо электрон цаг болж дэвшижээ. Энэ жишээнээс харсан ч хүний танин мэдэх үйл ажиллагаа хязгааргүй, түүнийг цаашид хөгжүүлэхэд хүн төрөлхтөний урьд өмнө бүтээж бий болгосон бүтээлүүд ямар их ач холбогдол өгдгийг харуулж байна.

Монгол улс эрт дээр үеэс оюуны үнэт зүйлийг эрхэмлэн дээдэлж хамгаалж ирсэн бөгөөд энэ талаар эртний ном зохиолд тухайлбал Монголын нууц товчоонд дурдсан байдаг.

Харин 1990 оноос эхлээд ардчилсан нийгэмд шилжсэн тэр үеэс шинэ Үндсэн хуулиа баталж үүндээ оюуны өмчийн талаар тодорхой заалт оруулж хуульчлан баталгаажуулсан нь онцгой ач холбогдолтой болжээ. Уг хуулинд зааснаар соёл урлаг, шинжлэх ухааны нээлт хийх, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрх нь Монгол Улсын иргэнд байхаар, зохиогч шинэ бүтээл нээлтийн эрхийг хуулиар хамгаалахаар, иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн гэжээ.

Түүнчлэн түүхийн үе шат болгондоо оюуны үнэт зүйлийг зохицуулж ирсэн бөгөөд дээрх үндсэн хуулиар тунхагласан эрхээ эдлэн оюуны үнэт зүйлийг туурвих, бүтээлээ өмчлөх эрхийг баталгаажуулсан хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалтын үндэс тавигдаад 10 гаруй жил өнгөрч байна. Хүний оюун ухаанаар бүтээгдсэн шинэ бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, бараа үйлчилгээний тэмдэг, шинжлэх ухааны нээлт, урлаг утга зохиолын бүтээл, хөгжим, дүрслэх урлаг, архитектор, бүжиг, кино, гэрэл зураг, дуу авиан, дүрс бичлэгийн бүтээл гэх мэт зүйлсийг хууль зүйн талаас нь хэрхэн үнэлэх, ямар журмаар анхдагчаар тогтоох, зохиогчийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг нь ямар арга хэрэгслээр хамгаалах, эрх нь зөрчигдсөнийг хэрхэн сэргээн тогтоох гэх мэт асуудлаар төрөөс хууль зүйн зохицуулалтыг цаг тухай бүрд нь хийхийг шаардаж байна.

Зуун зууны тэртээгээс нүүдэлчин Монгол түмний туурвин бүтээсэн үнэт зүйлс өнөөдөр ч дэлхий нийтийн гайхал хүндэтгэлийг төрүүлсээр байгаа билээ. Энэхүү бүтээгдсэн оюуны үнэт зүйлсийг хадгалах, хамгаалах, уламжлан үлдээх, бүтээлийг туурвисан этгээдэд эрх дарх, цол хэргэм олгох зэрэг өвөрмөц арга хэлбэртэй байсныг эх сурвалж болгон үзвэл: «Чингис хаан болбоос эрдэмтнийг ихэд хүндэтгэн сайшааж үздэг байсан бөгөөд 1222 оны хавар Нанхианаас алдарт Бумба Чангунг ордондоо урьж ихэд өргөн хүндэтгэсэн ба гурван удаа түүний номлосон сургаалийг сонсож, түүний хэлсэн бүгдийг монгол хэлээр бич хэмээн сайшааж, хатад, олон баатар, сайд нартаа үүний эрдмийг

ихэд магтвай. Тэндээс Чангун удалгүй салж, нутагтаа буцах зөвшөөрлийг олж авбай» хэмээжээ. Мөн «Чингис хаан болбоос эрдэмтнийг дайн байлдаан хийж, бусдыг дайж дагуулан авсан ч эрдэмтэн хийгээд уран дархчууд ба эмс хүүхдийг бол ер алж цаазалдаг заншилгүй ажгуу» гэсэн байдаг, мөн «Төрийн хуурч» гэсэн алдар цол олгож байсан зэргээс үзэхэд түүхийн үе шат бүрт «оюуны өмч»-ийн онцлог талаас нь судалж үзсэн байгаа юм.

Хүний нийгэм урт хугацааныхаа хөгжлийн явцад өмчлөлийн зүйлийн хоёр үндсэн хэлбэрийг бий болгожээ. Тухайлбал: биет өмчлөлийн зүйлс (tangible things), биет бус өмчлөлийн зүйлс (intangible things) -ийг өмчийн харилцаанд оруулжээ. Биет өмчлөлийн зүйлд эд юмс орох бөгөөд үүнийг иргэний эрх зүйн үүднээс авч үзвэл хөдлөх эд юмс, үл хөдлөх эд юмс гэж ангилна. Харин биет бус өмчлөлийн зүйлд оюуны үнэт зүйл, эд хөрөнгийн зарим эрх хамаарагддаг.

Оюуны өмч гэдэг нь хэл зүйн болон хууль зүйн хоёр утгатай. Хэл зүйн утгаараа компьютер, загвар өгүүлэл, шинэ бүтээл гэх мэт хүний оюун санааны үр дүнг илэрхийлсэн нийтлэг хэл зүйн ойлголтыг өөртөө агуулна. Харин хууль зүйн утгаараа тухайн оюуны бүтээл дэх өмчлөлийн эрх юм. Үүнийг задлан тодорхойлбол хүний сэтгэн бодох ухаанаас ямар нэгэн бүтээлч санаа гарна. Тэр санаа амьдралд хэрэгжихдээ тодорхой биет болон биет бус хэлбэрээр нөлөөлж байдаг. Иймд энэ нь хөрөнгө болох бөгөөд энэ хөрөнгийг хэн нэг нь эзэмших ёстой. Эндээс объект субъект гэсэн ойлголт гарч ирэх ба энэ хоёр нийлж байвал оюуны өмч гарч ирнэ. Хүн тодорхой нэгэн зүйл бүтээхийн тулд сэрлийн уураг тархи, түүнд хуримтлагдсан мэдлэгийн тусламжтайгаар танин мэдэхүйн янз бүрийн арга хэрэгсэл, техник технологийг ашиглан, өөрийн оюун ухаанд бодож боловсруулаад түүнийгээ тодорхой нэгэн хэлбэрээр илэрхийлэн гаргахыг оюуны хөдөлмөрийн бүтээлч үйл ажиллагаа гэж тодорхойлж болох юм.

1921 оны Ардын хувьсгалын түүхээс хойш товчоор авч үзвэл манай улсад 1940-өөд оны үеэс эхлэн оюуны хөдөлмөрийн

үр дүнг эрх зүйн талаас нь зохицуулалт хийж эхэлсэн байна. Хамгийн анхны эрх зүйн акт нь 1944 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн Ардын сайд нарын зөвлөл (АСНЗ)-ийн 63 дугаар хурлын тогтоолоор батлагдсан «Шинэ юмыг зохион олох ба үйлдвэрт оновчтой сайн санал гаргагсадыг шагнаж урамшуулах тухай заавар юм». Үүгээр аливаа шинэ зүйл бүтээсэн этгээдэд тодорхой хэмжээний урамшуулал олгох, түүнчлэн шинэ зүйл бүтээснийг нь нотлох баримт өгч, түүнийг нь улс бүртгэж байх тухай зохицуулалт хийжээ. Улмаар 1952 оны Иргэний хуулийн 18 дугаар бүлэгт «Зохиогчийн эрх», 19 дүгээр бүлэгт «Зохион бүтээсэн зүйлийн эрх» нэртэйгээр анх зохицуулагдсан байна. Мөн 1960 онд «нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дүрэм» батлагдан гарсан ба үүнд шинэ бүтээл зохиогчийн гэрчилгээ эсвэл патентын аль нэгийг зохиогчийн хүсэлтээр шийтгэн олгож байхаар тусгасан бөгөөд уг дүрэм нь 1970 онд шинэчлэгдэж байжээ. 1963 оны Иргэний хуулиар оюуны хөдөлмөрийн үр дүнгийн асуудал арай боловсронгуй, дэлгэрэнгүй байдлаар зохицуулагдах болсон байна. Тухайлбал: «зохиогчийн эрх», «шинэ бүтээлийн эрх», «нээлт гаргах эрх» гэсэн системтэйгээр зохицуулалт хийгдэж оюуны хөдөлмөрийн үр дүнд нээлтийг оруулан эрх зүйн хамгаалалт тогтоох, нээлт гаргасан этгээдэд «диплом» олгож байхаар зохицуулжээ. Дээр дурдсан эрх зүйн актаар оюуны хөдөлмөрийн үр дүнд бий болсон харилцааг хууль зүйн талаас нь тодорхой зохицуулж ирсэн боловч оюуны өмч, тухайн зохиогчийнх нь өмч гэсэн сонгодог утгаар нь зохицуулагдаггүй байжээ. Учир нь тухайн нийгэм нь социализмын байгуулахад чиглэж байсан ба үүнийгээ дагаад үүнийг эмчийг эсэргүүцэж бүх өмч улсын өмч байх зарчим ноёрхож байсантай холбоотой.

Оюуны хөдөлмөрийн тодорхой үр дүнг төрийн зүгээс хууль зүйн талаас нь үнэлэх, эрх зүйн хамгаалалтанд авах асуудлаар олон улсын хэмжээнд арга зүйн хоёр үндсэн чиглэл байжээ. Үүнд:

- Оюуны хөдөлмөрийн бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээл бол нийгмийн баялаг бөгөөд нийгмийн зүгээс бүтээл бүтээсэн этгээдийг зохиогч гэж хүлээн зөвшөөрч, уг бүтээлийг бий болгосных нь төлөө зохиогчид шагнал өгөх үндсэн дээр эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох;
- Оюуны бүтээл бүтээсэн этгээдийн зохиогч байх эрхийг нь хүлээн зөвшөөрөхийн хамт уг бүтээлийг зөвхөн тухайн этгээдийн оюуны хөдөлмөрийн үр дүн болох утгаар зохиогч нь өмчлөгч, зохиол бүтээл нь өмчлөлд байх гэсэн утгаар эрх зүйн зохицуулалтыг тодорхойлсон.

Манай улс дээрх зохицуулалтын нэгдүгээр хэлбэрээс хоёрдугаар хэлбэр лүүшилжин зохицуулалат хийж эхлээд байна. Нийгмийн харилцааны шилжилтийн үед зайлшгүй хэрэглэгдэх төрийн зохицуулалтын гол арга нь эрх зүй бөгөөд энэ агуулгын үүднээс нийгмийн амьдралын тулгуур хууль болох «Үндсэн хууль»-ийг 1992 онд шинээр батлан гаргасан. Шинэ үндсэн хуулиар нийгмийн харилцааны олон талт асуудлыг шинээр зохицуулсан бөгөөд түүний нэг нь оюуны хөдөлмөрийн үр дүнг төрөөс хэрхэн зохицуулах зарчмыг Үндсэн хуулийн хүрээнд батлан тунхаглаж өгсөн явдал юм.

Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 2-т «Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол улсын үндэсний баялаг мөн» гэж оюуны хөдөлмөрийн бүтээлч үйл ажиллагааны үр дүн болсон хүний уураг тархинаас боловсруулсан бүтээгдэхүүн нь тухайн зохиогчийнх нь өмч, зохиогч нь өмчийн эрхээ бие даан хэрэгжүүлэх боломжийг төр хууль зүйн талаас нь хангаж өгөх тогтолцооны эх үндэс нь тавигдсан байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 18 дугаар зүйлийн 8-д зааснаар «Монгол Улсын иргэн соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч шинэ бүтээл нээлтийн эрхийг хуулиар хамгаална», мөн 7 дугаар зүйлийн 1-д «Монголын ард түмний түүх соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтанд байна» гэсэн заалтууд нь

«Хүн бүр өөрийн туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, уран сайхны бүтээлийн материаллаг болон ёс суртахууны үр шимийг хүртэж, ашиг сонирхолоо хамгаалуулах эрхтэй» гэсэн «Хүний эрхийн түгээмэл тунхаглал»-ын заалттай нийцэж байгаа юм.

Оюуны өмчийн эрхийн хамгаалалтыг зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд улс бүхэнд оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн байгууллага байдаг ба манай улсын тухайд Засгийн газрын 1996 оны 197 дугаар тогтоолоор Зохиогчийн эрхийн газар, Патентын газрыг нэгтгэн «Оюуны өмчийн газар»-ыг шинээр зохион байгуулсан байна. Одоо энэ байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Манай улсын шинжлэх ухаан, технологийн салбар дахь оюуны өмчийн хамгаалалт, хэрэгжилтийн өнөөгийн байдалд судалгаа хийсний үндсэн дээр энэ салбарын оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтыг боловсронгуй болгох, зохион бүтээгч, туурвигчийн эрхийг хамгаалах, бүтээлийнхээ үр шимийг хүртэх, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн зохимжтой орчин, хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх зайлшгүй хэрэгцээ байгаа нь тодорхойлогдоно.

Монгол Улсад дагаж мөрдөгддөг нийт хууль тогтоомжоос 76 хууль, УИХ-ын 14 тогтоол, Монгол Улсын олон улсын 4 гэрээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 3 зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 73 тогтоол болон асуудал эрхэлсэн сайдын зарим хамаарах тушаал, Шинжлэх ухааны Академийн их чуулган, Тэргүүлэгчдийн хурлын зарим тогтоолын хүрээнд эрх зүйн орчны судалгааг хийж үзэхэд:

Шинжлэх ухаан, технологийн салбарт дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд судалгааны сэдвийн томъёоллоор хязгаарлан зөвхөн оюуны өмчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг авч үзэхэд нэр бүхий хэдэн хуулиас өөр зохицуулалт, хамгаалалтын механизм, оюуны өмгөтэй уялдуулсан агуулга холбоос бусад хуульд бараг байхгүй гэж хэлж болохоор үр дүн эхний байдлаар гарсан. Эндээс Монгол Улсын төр энэ

асуудалд байнга анхаарал тавьж, хууль тогтоох замаар бодлого, зохицуулалтыг хийсээр байна гэсэн анхдагч дүгнэлт гарч болох юм. Энэ судалгааны үр дүнтэй танилцсан судлаач бүхэн өөр өөрийн байр сууринаас дүгнэлтийг гаргах нь ойлгомжтой хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилт нь "хуулийн зохицуулалттай" -гаа хэрхэн харилцан хамааралтай байгааг анхаарахын зэрэгцээ "шинжлэх ухаан, технологи, оюуны өмч, инноваци" гэсэн харилцан хамаарал бүхий үзэгдлийг салангидаар бус нэгдмэлээр авч үзэх, "эдийн засгийг мэдлэгжүүлэх"-ийн чухалд бүх нийтийн анхаарлыг хандуулах, оролцоон дээр тулгуурласан, үр ашгийг хүртэгчдийн хүрээг өргөтгөн тодорхой болгох зэрэг олон асуудал хүлээгдэж байгаатай санал нэгдэх болов уу.

Шинжлэх ухаан, технологид хамаарах асуудлыг дээр дурдсан хуулиудын хүрээнд:

1. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих талаархи зохицуулалт
2. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах талаархи зохицуулалт
3. Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн бодлогод нийцүүлж, уялдуулан зохицуулах үүргийн талаархи зохицуулалт
4. Шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, шинжлэх ухаанд тулгуурласан, шинжлэх ухааны үндэслэл бүхий байх талаархи зохицуулалт
5. Судалгаа шинжилгээний ажлыг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх талаархи зохицуулалт
6. Түүх, соёл, шинжлэх ухааны бүтээлийг хамгаалах, хадгалах, улсын нууцад авах талаархи зохицуулалт
7. Судалгаа шинжилгээний зориулалтаар зөвшөөрөл олгох талаархи зохицуулалт
8. Шинжлэх ухаан, технологийн салбар дахь татвар хураамжийн талаархи зохицуулалт

9. Оюуны өмчийн эрхийг хамгаалах талаархи зохицуулалт гэсэн агуулгаар харьцуулан судлав.

Судалгаанаас үзэхэд:

Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих талаархи зохицуулалтын талаар:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2-т "Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх бүрэн эрхийг Үндсэн хуулиар тогтоожээ.
2. Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын хэмжээнд баримтлах шинжлэх ухаан-техник, технологийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах нь Засгийн газрын үүрэг юм.
3. Авто замын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д Авто замыг хөгжүүлэх болон шинжлэх ухаан, техник, технологийн талаар төрөөс баримтлах бодлого боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих нь авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамаарахаар заасан байна.

Оюуны өмчийн эрхийг хамгаалах талаархи зохицуулалтын талаар:

Энэ хэсэгт оюуны өмчийн үндсэн салбарын хамгаалалтын гол хууль болох Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиудыг авч үзсэнгүй бусад хууль тогтоомжид оюуны хөдөлмөрийн үр дүнг өмч болгон хамгаалан "хэрэгжүүлэх" зохицуулалт тусгагдсан байдлыг агуулгаар нь түүвэрлэн үзлээ.

1. Иргэний хуулийн 421 дүгээр зүйлийн 421.8-д Уралдаант шалгаруулалт зарласны дагуу зохиогчийн эрхэд хамаарах

бүтээл туурвисан бөгөөд уг бүтээл нь уралдаант шалгаруулалтын шагнал авсан бол уралдаант шалгаруулалт зарласан этгээд түүнийг уралдаант шалгаруулалтын болзолд дурдсан аргаар ашиглах эрхтэй бөгөөд болзолд өөрөөр заагаагүй бол энэхүү бүтээлийн зохиогч бүтээлээ ашиглуулсны хөлс, шагналыг авах эрхтэй.

2. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулахыг хориглосон бөгөөд патент эзэмшигч, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, худалдааны мэдээлэл, нууцыг худалдах, нийтлэх, бусдад тараахыг өрсөлдөөнд харш үйлдэл гэж зохицуулсан байна. Энэ нь патентын болон зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжоор хязгаарлагдаагүй, зах зээлд чөлөөтэй худалдагдаж байгаа барааг дуурайлган дахин угсран бүтээхэд хамаарахгүй гэжээ.
3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 115.1.4-т ялтан холбогдох зардлаа өөрөө хариуцаж шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих эрх эдлэхээр заажээ.
4. Эрүүгийн хуулийн 140 дүгээр зүйлд зохиогчийн бүтээлийг түүний зөвшөөрөлгүйгээр өөрийн нэрээр гаргасан, хууль бусаар хуулбарласан, нийтлүүлсэн, тараасан, борлуулсан, хамтран зохиогч болохоор албадсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 141 дүгээр зүйлд нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын зохиогч, патент эзэмшигчийн бүтээлийг хууль бусаар өөрийн нэрээр гаргасан, тараасан, борлуулсан, хамтран өмчлөгч болохоор албадсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ гэж эрүүгийн хуулиар хамгаалаалт хийгдсэн байна.

5. Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д зааснаар Технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь технологи дамжуулахтай холбогдон технологи эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлыг зохицуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэжээ. 8 дугаар зүйлээр дамжуулах технологид хамаарах зүйлд патент, лиценз, бүтээгдэхүүний загвар, ноу-хау байхаар тусгасан бол технологи дамжуулах гэрээнд тусгах асуудлын нэг нь патент, барааны тэмдгийг ашиглах нөхцөл байхаар зохицуулжээ.

Монгол Улсад шинжлэх ухаан, технологи, инновацийг эрчимтэй хөгжүүлэх боломж бүрдэж байна. Учир нь манай улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжээд нийгмийн үйлчилгээний давхарга өөрчлөгдсөн ч нийгэм-эдийн засгийн хөгжлийн эрх зүйн орчны бүрдүүлэлт амжилттай явагдаж байна. Үйлдвэрлэл хөгжиж шинэ техник, технологи үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтэрсээр байна. Тухайлбал, шинжлэх ухааны төрөлжсөн байгуулагатай, төрийн өмчийн дээд боловсролын байгууллагуудад шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх эрх зүйн үндэс нэгэн бий болсон байна. Инноваци нь улс орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжлийн хөдөлгөгч хүч, эдийн засгийн өсөлтийн тулгуур хүчин зүйл болсон өнөөгийн нөхцөлд энэхүү арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа нь ихээхэн ач холбогдолтой.

Өндөр хөгжилтэй орнуудад шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэхэд эрдэм шинжилгээний төрөлжсөн байгууллагуудаас гадна төрийн өмчийн их сургуулиудад их ач холбогдол өгч байна. Их сургуулиудын дэргэд байгуулагдсан эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төвүүдийг зориудаар дэмжин хөрөнгө оруулж материаллаг баазыг нь бэхжүүлэхийн хамт судлаачдыг бэлтгэхэд зориулсан хөрөнгө оруулалтыг их сургуульд өгч байна. Мөн төрийн өмчийн сургуулиудын институт,

салбар, тэнхим, профессорын багийн сургалт судалгааны материаллаг баазыг бэхжүүлэхэд ихээхэн дэмжлэг өгч байна.

Судалгааны хүрээнд дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Тодорхой сэдвээр бэлтгэгдсэн залуу судлаачдад шинжлэх ухааны суурь судалгааны сэдэвт ажил олгох, лаборатори байгуулж өгөх, судалгааны захиалга өгөх,
2. Өндөр технологийн чиглэлийн судалгаанд оролцох докторантууд, залуу эрдэмтдийг сонгон гадаадын өндөр хөгжилтэй орнуудад явуулж дадлагажуулах,
3. Шинжлэх ухаан технологийн болон аж үйлдвэрийн бодлогын цогц уялдааг хангах инновацийн төрийн бодлогыг тухайлан боловсруулж, инновацийг улс орон даяар өрнүүлэн хөгжүүлэх таатай орчин, хууль зүйн механизм бүрдүүлэн, үндэсний инновацийн үр ашигтай тогтолцоо бий болгох,
4. Шинжлэх ухаан, технологийн ололтыг практикт нэвтрүүлэх, тэргүүний технологийг нутагшуулах, үндэсний уламжлалт технологийг боловсронгуй болгох, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалтыг сайжруулах хүрээнд үйлдвэр аж ахуйн газар, бизнесийн байгууллагуудад хийгдэж буй нааштай өөрчлөлт шинэчлэлт, аливаа үүсгэл санаачлагыг бүх талаар хөхиүлэн дэмжиж, хувийн хэвшилд инновацийн идэвхжиллийг өрнүүлэх чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулах, татварын хөнгөлөлт чөлөөлөлт үзүүлэх, ололт амжилтыг нийтэд сурталчилах, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх олон талт урамшууллын механизм бүрдүүлэх зэргээр төрөөс бодитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
5. Оюуны өмчийн эрхийн баталгааг хангах, оюуны өмчийг хамгаалах механизмийг боловсронгуй болгох, ялангуяа оюуны бүтээлийг гадаадад патентлах, өөрийн орны үйлдвэрлэлийн практикт оюуны бүтээл, патентуудыг нэвтрүүлэх, боломжоор хангах, энэ чиглэлд төрөөс

шаардлагатай дэмжлэг тусламцаа үзүүлэх, холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах,

6. Инновацийн болон эрсдлийн тусгайлсан сан бий болгох, дотоод, гадаадын эх үүсвэр, гадаадын зээл тусламжийн хөрөнгийг энэ чиглэлд төвлөрүүлж үр өгөөжтэй ашиглах, даатгал, татварын баталгааг хангах, энэ чиглэлд төрөөс шаардлагатай дэмжлэг тусламцааг үзүүлэх,
7. Технологи дамжуулалтыг боловсронгуй болгох, үндэсний технологийн уламжлалт салбарт шинжлэх ухаан технологийн дэвшлийг нэвтрүүлэх, үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх асуудлыг зохистой шийдвэрлэх хүрээнд инновацийн үр дүнтэй арга хэрэгсэл болох технологи, бизнесийн инкубацийг үүсгэн хөгжүүлэх, шаардлагатай хууль эрх зүйн баримт бичигт нэн даруй боловсруулж батлуулан, эрх зүйн зохистой орчин бүрдүүлэх, холбогдох байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх,
8. Мэдлэгийн менежментийн тогтолцоо механизм бүрдүүлэх, мэдлэг, оюун ухаан шаардсан, оюуны багтаамж өндөртэй салбарын мэргэжилтэнг түлхүү бэлтгэх, хөгжингүй орнуудад залуучуудыг олноор явуулж сургах, гадаадад суралцаж, ажиллаж буй өндөр мэдлэг, ур чадвар бүхий боловсон хүчнийг эх орондоо ирж ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх замаар инновацийн хүний нөөцийг зохистой бүрдүүлэх,
9. Иргэдийн дунд инновацийн талаар мэдлэг олгох, мэдээлэл түгээх сургалт, сурталчилгааны ажлыг өргөнөөр зохион байгуулах, үндэсний соёл, зан заншил, сэтгэлгээний уламжлалд тулгуурлан монгол хүний хөгжил, оюун санаа, хөгжлийн хүрээнд инновацийг өрнүүлэх, энэ чиглэлд боловсрол, соёл урлаг, шашны байгууллагуудад хүчээ нэгтгэн хамтран ажиллах.

Мөн түүнчлэн оюуны өмчтэй холбогдолтой иргэний хэргийн мэдээллийн бодит үнэнийг анхааралтай авч үзэж энэ төрлийн

маргааны шийдвэрлэлтийн практикийг эрх мэдэл бүхий зохих шатны шүүхэд төвлөрүүлж судлах нь зүйтэй байна.

Олон улсын практик, онолын талаас оюуны өмч болох мэдлэг буюу мэдээлэл нь хамгийн үнэт ба үл мэдрэгдэх нөөц баялаг билээ. Мэдээллийн ертөнцөд өмчийн эрхийг үүсгэн бэхжүүлэх нь мэдээллийг ихээр, зохистой ашиглаж, хөрөнгө оруулалтыг эрчимтэй дэмжих нөхцөл болж байна. Нөгөө талаар энэ нь зохиогчийн эрхийн хамгаалалтанд хүндрэл учруулж, олон арван маргааны эх үүсвэр болж байна. Техник технологийн дэвшилтэт хөгжил нь хэдий чинээ үсрэнгүй явагдах тусам энэ нь зохиогчийн бүтээлийг хувилж олруулан, зөвшөөрөлгүйгээр нийтэд худалдан борлуулж ашиг олох явдлыг хяналтаас гаргаж хууль зөрчигдөхөд хүргэж байгаа юм. Иймд нийгмийн хөгжлийн алхам бүрт эрх зүйн шинэтгэлийг цаг алдалгүй хийж, сургалт сурталчилгаа явуулах замаар иргэдэд эрх зүйн мэдлэгийг эзэмшүүлэх ажлыг цогц байдлаар хэрэгжүүлэх хэрэгтэй.

Аливаа улс орны хөгжлийг тодорхойлохдоо газар нутгийн хэмжээ, газрын хөрсөн доорх баялгаар нь бус харин тухайн улсын иргэдийн оюуны чадавхи түүнийгээ ашиглаж өөрийн гэсэн техник технологийг хөгжүүлсэн байдал, соёл, шинжлэх ухааны салбарт олсон амжилтаар нь хэмжих болсон билээ. Ийм эрин үед амьдарч байгаа бид оюунаа уралдуулж түүнийхээ үр дүнгээр өөрийн гэсэн өмчтэй болох боломж эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэдийнээ бий болсон байна.

Ном зүй

Хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Иргэний хуулиуд (1952, 1963, 1994, 2002)
3. Монгол Улсын Патентын тухай хууль 1995 он
4. Монгол Улсын Патентын хууль 2006 он
5. Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль 1993 он
6. Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль

7. Монгол Улсын Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль 1998 он
8. Монгол Улсын Оюуны өмчийн газар, Оюуны өмчийн хууль тогтоомжийн системчилсэн эмхтгэл 1999 он

Ном, сурах бичиг:

1. Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй (Ерөнхий ангш) УБ, 2000 он
2. Т.Мөнхжаргал. Иргэний эрх зүй (Тусгай ангш) УБ, 1998 он
3. Д.Цолмон. "Оюуны өмчийн эрх зүй" УБ, 2000 он
4. Т.Сэнгэдорж. Монгол улсын төр эрх зүйн үндэс УБ, 2000 он
5. Гражданское право. Том юр.лит 1999, М
6. Intellectual property Reading material WIPO Geneva, 1997
7. Менежер. Удирдлагын академи. УБ, 1999 он

П.ТҮВШИНТӨГС

Шихихутуг ХЗДС-ийн багш, докторант

ЦАХИМ ЭРХ ЗҮЙ ДЭХ ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Өнөөдрийн мэдээллийн эрин зуунд цахим эрх зүй гэдэг цоо шинэ салбар үүсэх боллоо. Цахим эрх зүй нь даяаршлын далайцтай жишээ болж байна. Асар хурдацтай хөгжиж байгаа өнөө үед цахим эрх зүйд техник, эдийн засаг, нийгэм ба соёлын олон асуудлууд хөндөгдөж буй юм. Тухайлбал, цахим харилцаан дахь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, оюуны өмчийн асуудлууд болон маргааныг хянан шийдвэрлэх, интэрнэтийн үйлчилгээ үзүүлэгчийн хүлээх үүрэг, харилцаага зэрэг ойлголтуудыг дурдаж болох юм. Ганц илтгэлийн хүрээнд нэгэн зэрэг авч үзэх боломжгүй тул цахим харилцаан дахь зохиогчийн эрхийн тулгамдсан асуудлуудыг авч үзсэн болно.

Цахим эрх зүй нь манай улсад нилээд түгэн дэлгэрсэн бөгөөд интэрнэт хэрэглэгчдийн тоо ч улам нэмэгдсээр байгаа өнөө үед цахим харилцаа тэр дундаа цахим орчин дахь зохиогчийн эрхийн талаар дурдсан бүтээл тун цөөн билээ. Т.Галбаатар “Цахим эрх зүй” номондоо цахим харилцааг тодорхойлсон ч хууль эрх зүйн үүднээс дагнан судлаагүй бөгөөд Ч.Жадамба “Шихихутуг” сэтгүүлийн 2012 оны дугаарт энэ талаар хөндөн тавьсан ч судлаачийн бүтээлээс цахим эрх зүй дэх зохиогчийн эрхийн хамгаалалт, харилцаага оногдуулах үндэслэл журмыг хөндөж тавьснаараа онцлог болно.

Цахим орчинд барааны тэмдэг, зохиогчийн эрх, патентыг хамгаалах зэрэг харилцаа нь цахим эрх зүйн зөрчлийн хамгийн нэгэн том асуудал болж байгаа бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс Дэлхийн оюуны өмчийн байгууллага /ДООБ/ -аас 1996 оны 12 дугаар сард Зохиогчийн эрхийн тухай, Үзүүлбэр, фонограммын тухай хэлэлцээрүүдийг тус тус баталсан байна. Дэлхийн оюуны өмчийн байгууллагын эдгээр конвенциуд нь

интернэтээр үзүүлбэр үзүүлэгч, фонограмм зохиогчдын эрх, зохиогчийн эрхийг олон улсын түвшинд хамгаалах, хууль, эрх зүйн зарчмуудыг агуулсан томоохон баримт юм. Дэлхийн оюуны өмчийн байгууллагад аудио-видео үзүүлбэрийн тухай протокол, мэдээллийн сангийн оюуны өмчийн хэлэлцээрийг байгуулах талаар хэлэлцүүлэг явагдаж байгаа бөгөөд оюуны өмчийн бас нэгэн чухал асуудал бол домэйн нэрийг хуваарилах асуудал юм. ДООБ интернэтийн домэйн нэрийн оюуны өмч, холбогдох маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлаар зөвлөмж боловсруулах олон улсын хэлэлцүүлгийг 1988 оноос эхлүүлсэн байна.

Интернэтийн хүртээмж дэлхий даяар болж дэлхийн хаанаас ч зохиогчийн бүтээлийг татаж авах бололцоотой болсныг харгалзан үзэж, тэдгээрийг хууль бусаар татах, хэрэглэхийг хориглохыг дотоодын хууль тогтоомжоороо тусгахыг ДООБ хүсчээ.

Цахим гэдэг утга санаа нь ерөнхийдөө текст, дуу, дүрс зэрэг цахим өгөгдлийг боловсруулж дамжуулах ажиллагаан дээр үндэслэсэн байгууллага, хувь хүмүүсийн хоорондын харилцааны нэг хэлбэрийг хэлнэ.

Зохиогч гэдэг бол монгол улсын зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд зааснаар "Өөрийн оюуны бүтээлч үйл ажиллагаагаар бүтээл туурвисан хувь хүнийг хэлнэ". Зохиогч нь өөрийнхөө бүтээлийн хувьд онцгой эрхүүдийг эдэлж болох бөгөөд зохиогч нь зохиол бүтээлээ нийтэд түгээх эрхтэй бөгөөд энэ эрхийг нь тус хуульд томъёолохдоо "нийтэд түгээх" гэж бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объектыг хэрэглэгч өөрийн сонгосон цаг, газраас хүртэх боломжтой байдлаар утсан болон утасгүй холбоогоор нийтэд тараахыг хэлнэ" гэж зааж өгсөн нь цахим хэлбэрээр байж болох нэг утга юм.

Манай улсын хувьд цахим хэлбэрээр зохиогч өөрийн дуу, дүрс, видео болон бүтээлээ бусдад түгээх энэхүү харилцаанд дараах субъектүүд хамаарч байгаа юм.



Манай улсад интернетээр зохиогч бүтээлээ түгээх харилцааг дээрх байдлаар авч үзвэл

3-1 харилцаанд тухайн харилцааны онцлог шинжээс хамаарч ямар ч төрлийн гэрээгээр энэхүү харилцааг зохицуулж болох бөгөөд интернетийн үйлчилгээ эрхлэгч субъектүүдийг оролцуулан судалгаа хийхэд хөдөлмөрийн гэрээ, эрх шилжүүлэх гэрээ, захиалгаар зохиол бүтээл туурвих гэрээ гэх мэт олон төрлийн гэрээ байгуулан оролцож байна.⁵⁴

3-2 харилцаанд тухайн интернет сервер ямар зорилготойгоор байгуулагдсан болон ямар үйлчилгээ үзүүлдэг зэргээсээ хамаарч олон төрлийн гэрээ байгуулагддаг. Жишээ нь, хөдөлмөрийн гэрээ /www.shuud.mn⁵⁵, www.news.mn,⁵⁶ www.gogo.mn/, худалдах, худалдан авах гэрээ, захиалгын гэрээ гэх мэт/

X-1⁵⁷ харилцаанд зарим тохиолдолд худалдах худалдан авах гэрээний болон бусад захиалгын гэрээний шинж чанар харагдах боловч зохиогчийн эрхийг зөрчил энэ харилцаанд илүү их гардаг байна.

Зохиогчийн эрх, түүнд хамаарах эрхийн тухай хуульд зааж өгснөөр Интернетийн үйлчилгээ түгээгч нь өөрийн серверт байршуулсан вэб хуудсанд зохиогчийн эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогч болон эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй хэмээн зааж өгсөн нь үүрэг болгосон шинжтэй заалт бөгөөд Интернетийн үйлчилгээ түгээгч нь зохиогч

⁵⁴ J. Rosenoer, "Problems on the Internet: A Lawyer's Perspective," *Ethics & Behavior*, March 1995, 98 дахь талд

⁵⁵ www.shuud.mn /маркетингийн алба/

⁵⁶ www.news.mn /маркетингийн алба/

⁵⁷ J. Rosenoer, "Getting to Digital Signatures and Electronic Commerce," *Policy Options*, June 1998, 188 дахь талд

болон зохиогчийн эрхэд хамаарах эрх эзэмшигчийн эрх зөрчигдөж байгаа тухай мэдээллийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх, зөрчлийн тухай мэдэгдсэн даруй тухайн вэб хуудсыг хаах үүрэг хүлээнэ хэмээн заажээ. Мөн түүнчлэн мэдээлэл, технологийн газрын даргын тушаалаар батлагдсан Цахим хуудасны агуулгын загварт "Цахим хуудасны сайтын агуулгыг ашиг орлого олохоос бусад зорилгоор үнэ төлбөргүй хэрэглэж болно. Вэб сайт дээр тавигдсан материалыг бусад мэдээллийн хэрэгслэлээр бүтнээр нь болон хэсэгчлэн хэвлэх тохиолдолд сайтын нэр ба зохиогчийн эрх эзэмшигч байгууллагын нэрийг дурдаж агуулгын утга санаа, судалгааны дүн зэргийг өөрчлөхгүй байна....."³⁸ хэмээн зааж өгчээ. Хэдийгээр манай улс нь хууль тогтоомжоороо ийнхүү тусгаж өгсөн нь өнөөдрийн цахим харилцаанд гарч буй оюуны өмчийн эрхийн зөрчлийг бүрэн зохицуулж чадаагүй гэж хэлж болох юм. Одоогийн түвшинд цахим харилцаанд оюуны өмчийн дараах нийтлэг асуудлууд гарч байна.

- Цахим хэлбэрээр оюуны өмчид халдсан үйлдлийг олох, эзэн холбогдогчийг нь тогтоох
- Оюуны өмчид халдсан тохиолдолд учирсан хохирлыг хэрхэн арилгуулах зэрэг асуудал гарч байгаа юм.

Цахим харилцаанд эрх зөрчсөн үйлдлийг олж тогтоох болон эрх зөрчсөн субъектийг олоход бэрхшээлтэй. Учир нь интернэтийн үйлчилгээ үзүүлэгч нь интернэт сервертээ бусдын линк, хаягийг татан байршуулсан, иш татсан, хэрэглэгчид түүнийг нь хуулбарласан зэрэг нь хэн нь зөрчлийн субъект вэ гэдгийг тодорхойлоход маргаантай байна. Мөн эрх зөрчигчид хариуцлага хүлээлгэх ойлголтонд Зохиогчийн эрх түүнд хамаарах эрхийн тухай хуульд Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ гэж заасан ч тухайн зохиогч этгээд эд хөрөнгийн хохирлод юуг хамааруулан ойлгох, зохиогч эд хөрөнгийн бус хохирлоо хэрхэн барагдуулах

³⁸ Мэдээтэл, технологийн газрын даргын тушаалын хавсралт 1, цахим хуудасны агуулгын загвар

нь тодорхой бус байна. Мөн хуульд Зохиогчийн эрх зөрчиж, зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг хуулбарлахад ашигласан техник хэрэгслийг шүүх, эрх бүхий байгууллагын шийдвэрээр хураан авч улсын орлого болгоно гэж заасан нь цахим харилцаанд зохиогчийн эрхийн зөрчил компьютер, техник хэрэгсэл ашиглан үйлддэгддэг нь түүнийг хураах үндэслэл болно гэж ойлгогдож байгаа ч үүнийг хэрэглэсэн нь одоогоор байхгүй байна.


Энэ бүхнээс дүгнэн үзэхэд хэдийгээр цахим харилцаа нь шинэлэг хэдий ч хэдийнээ дэлхийн улс оронд олон мянган хүнийг хамарсан зүйл болсон бөгөөд дэлхий нийтийн хандлага ч цахим харилцаанд аливаа зөрчлийг арилгах, зөрчилтэй тэмцэх зорилго бүхий байгаа бөгөөд манай улс ч үүнтэй мөн адил зорилго болгон ажиллах шаардлага зүй ёсоор урган гарчээ. Хэдийгээр хууль тогтоомжиндоо цахим харилцааны талаар тусгаж өгсөн ч өнөөгийн практикт нэг мөр ойлгон хэрэглэх боломжгүй байгаа тул хэрэгжих боломжоор хангах, эрх зүйн зохицуулалтаа эргэн харах шаардлага тулгарсаар байна.

Copyright priorities in cyber law

In current era of rapid development of cyber law, it becomes a bright example of the globalization and it raises many issues related to technique, economy, society and culture. For instance, following categories as protection of consumers' rights in cyber communication, settlement of intellectual property issues and disputes, liabilities and responsibilities of internet service providers and etc could be listed.

The relations of trademark, copyright and patent protection in cyber environment become top priority issues of cyber law conflicts and in order to resolve these problems, the World Intellectual Property Organization (WIPO) adopted the International Convention of Treaties for the Protection of Performers, Producers of Phonograms and Broadcasting Organizations in December 1996. According to the worldwide internet availability and download accessibility of copyright, the WIPO has requested its' member states to prohibit illegal or unauthorized duplication of copyrights with their national laws and regulations.

Cyber means generally a type of a communication between organizations and individuals that is based on developing and transferring text, sounds of a performance or of other sounds, video and other electronic data. In our country, following subjects are referred to this communication where an author distributes his or her sounds of a performance or of other sounds, video, images and other creations to others through electronic way.



If we consider that how an author in our country distributes his or her creations through internet:

1. For the relation Z-1, depending on the specific features of the relation, this kind of relation could be regulated with any type

of contracts and the survey conducted among internet service providers show that they uses many type of contracts as employment agreement, assignation agreement, ordering agreement of creations and etc.⁵⁹

2. For the relation Z-2, many type of contracts are concluded depending on what does the internet server aim for or what kind of service does it deliver. For example, employment agreement (www.shuud.mn⁶⁰, www.news.mn⁶¹, www.gogo.mn), sell and purchase agreement, ordering agreement and etc.
3. For the relation X-1⁶², in some cases, sell and purchase agreement, and other ordering agreement can be found but copyright conflicts occur mostly in this relation.

Determining copyright violations or conflict actions and finding violated subjects during the cyber communication is difficult. Because the internet service providers uploaded or copied other's links and web addresses to their internet servers and besides this, consumers copied them also, therefore it is disputable for determining who the conflict subject is. The liability for breakers of copyright includes the provision "Property damage caused by the conflict of exclusive rights of copyright shall be compensated in accordance with the provisions stated in Civil Law of Mongolia"⁶³ in Law on Copyright but it is unclear that what shall be included in property damages by an author or how shall the author be compensated for his or her non-material damage. As well as, the Law states that the equipment or tools used for duplicating copyright creations or other creations belong to copyright by violating the copyright shall be confiscated by the resolution of courts or by the authorized organizations and shall be transferred to the national income and it means that the copyright conflicts in cyber communication are made in assistance of

⁵⁹ J.Rosenoer, "Problem on the Internet: A Lawyer's Perspective" *Ethics and Behavior*, March 1995

⁶⁰ www.shuud.mn/marketing/service/

⁶¹ www.news.mn/marketing/service/

⁶² J.Rosenoer, "Getting to Digital Signatures and Electronic Commerce" *Policy Options*, June 1998

⁶³ *Law on Copyright and Rights referred to it Provision #31 31.3*

computers and other equipment and therefore it shall be the grounds to confiscate them but currently there is no history of application of the provision.

By concluding from these, however the electronic communication is comparatively new but this has already been introduced millions in the world and the global trend is eliminating any conflicts, fighting against such conflicts and therefore our country is also required to work aiming same goal as above. However laws and regulations in Mongolia reflect the cyber communication issues but it is impossible to use them as an integration of laws in current situation, therefore it still requires us to provide the legal environment with favorable conditions of implementation and even to re-consider legal regulations.

О.ОЮУНГЭРЭЛ

Оюуны өмчийн газрын аж гүйдлэрийн өмч, зохиогчийн эрхийн
хэлтсийн шинжээч

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ЗОХИЦУУЛААЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Оюуны өмчийн хууль тогтоомжид, бүтээгдэхүүний загвар нь аливаа бүтээгдэхүүний гоо сайхны болоод гадаад төрх харагдах байдалд хамааралтай болохыг заажээ. Энэ нь хэрэглэгчдийг болоод тэдний анхаарлыг нь татахуйц бүтээгдэхүүнийг хэрхэн хийх, мөн харахад анхаарал татахуйц байх нь хэрэглэгч тухайн бүтээгдэхүүнийг нөгөөгөөс илүүд үзэж шийдвэр гаргахад нөлөөлөх үндсэн асуудлуудын нэг болдог.

Монгол улсад, **бүтээгдэхүүний загварыг Патентын тухай хуулийн дагуу** хамгаалж бүртгэдэг.

Бүтээгдэхүүний загварыг бүртгүүлж хамгаалуулснаар, бүтээгдэхүүний загварын эзэмшигч гуравдагч этгээд тэрхүү бүтээлийг зөвшөөрөлгүйгээр олшруулж хувилах эсвэл хуулбарлахаас сэргийлэх **эрхийг** олж авдаг байна. Үүнд нийлмэл дизайны эсвэл хавсрага бүтээгдэхүүний загварын аль ч эдлэл хэрэгслийг хийх, санал болгох, гадаадаас оруулж ирэх, гадаадад гаргах буюу худалдаалахаас бусад хасагдсан эрхүүд багтана. Оюуны өмчийн хууль тогтоомж болон практик хэрэглээ нь бүртгэгдсэн бүтээгдэхүүний загварын хамгаалаалтын бодит цар хүрээг тодорхойлдог.

Монгол улсын Оюуны Өмчийн Газар нь тухайн бүтээгдэхүүний загварыг бүртгэхийн тулд шинэлэг эсвэл жинхэнэ загвар болох эсэхийг шалгадаг.

Бүтээгдэхүүний загвар бүртгэгдсэн тохиолдолд, тэрээр бүтээгдэхүүний загварын бүртгэлд орж, бүтээгдэхүүний загварын албан ёсны хэвлэлд хэвлэгдэн, танд **бүтээгдэхүүний загварын патент олгогдоно**.

Дүгнэвэл, бүртгэгдсэн бүтээгдэхүүний загвараар олгогдсон эрхийн хамгаалалт нь хүтэй хамгаалалт байдаг. Энэ нь санаатай бус зөрчилд өртөх болон бүтээгдэхүүний загварын патент нь зөрчил үүсэх тохиолдолд ач холбогдол бүхий баталгаа болж өгдөг байна, энэ нь ихээхэн үр дүнтэй хамгаалалт (санхүүгийн болон зохион байгуулалтын) болдог, яагаад гэвэл бүртгэлийг шаарддаг, мөн түүнчлэн тодорхой хугацааны хязгаарлалттай байна.

Ямар ч тохиолдолд, ялангуяа бүтээгдэхүүний загвар бүртгэгдээгүй бол, тухайн загварыг сайжруулан хөгжүүлэх бүхий л үе шатандаа барааныхаа тухай тайланг нууцлах нь зүйтэй хэмээн зөвлөмөөр байна. Ноорог эскиз бүрээ огноожуулж, баталгаажуулан архивлаж хадгалах явдал нь зөрчил илэрсэн тохиолдолд тус болж чадна.

Т.МӨНХЖАРГАЛ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/, Профессор

ОЮУНЫ ӨМЧИЙН ХАМГААЛАЛТ

Оюуны өмчийг хамгаалах асуудал бол нийгмийн амьдралын шавхагдашгүй үнэт баялаг болох хоорондоо харилцан гүн холбогдох боловч тус бүрдээ өвөрмөц онцлог шинжийг илэрхийлсэн, зохиогчийн оюун сэтгэлгээний бүтээлийг явцуу ба өргөн утгаар томъёолон хэлж болно.

Шинжлэх ухаан, урлаг, утга зохиолыг туурвисан зохиогч, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохион бүтээгчийн хуулиар тогтоосон эрхийг зохицуулж, хамгаалах ажиллагаа гэж товчхон тодорхойлж болох юм. Харин зохиогч, туурвисан зохиол бүтээл, зохион бүтээсэн зүйлээ өмчлөх, ашиглах, захиран зарцуулах эрхээ ямар арга замаар хамгаалах, бусдын зохиол бүтээлийг эзэмших, ашиглах, онцгой эрх, тэдгээр үйлдэл, үйл явцыг зөрчсөн хэлбэрүүд, түүнд оногдуулах хариуцлага зэрэг материалаг ба процессын эрх зүйн харилцааг хамаарах хүрээгээр өргөн утгыг илэрхийлсэн ойлголт болно.

Оюуны өмчийн хамгаалалт гэдэг ухагдахууныг зөв баримжаатай ойлгохын тулд юуны өмнө оюуны өмч, түүний хууль зүйн зохицуулалтыг зөрчсөн зөрчил хэмээх ухагдахууныг авч үзэх нь логик дараалал хийгээд утгын хувьд зөв биз. Хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн зөрчил нь төрийн хууль тогтоомжид зөвшөөрсөн ба хориглосон хэм хэмжээ болон гэрээнд тохиролцож тогтоосон эрх, үүргийг санаатай буюу болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэл байна гэсэн онол, үзэл баримтлал, арга зүй нь оюуны өмчийн эрх зүйн хамгаалалтад нэгэн адил хамаарах учиртай.

Оюуны өмчийн эрхийн зөрчил, түүнд хүлээлгэх хариуцлага нь Иргэний эрх зүй дэх хариуцлагын ерөнхий зарчим, нийтлэг шинжийг агуулахын зэрэгцээ бас зөрчлийн үүсэл, илрэх хэлбэр, хариуцлагын ялгарлын хувьд өөрийн гэсэн агуулга бүхий дүр

төрхтэй байна. Оюуны өмчийн эрхийн зөрчил мөн, бишийг тодорхойлоход:

1. Хэн нэг этгээд зохиогч ба зохион бүтээгчийн онцгой эрх зөрчсөн үйлдэл, эс үйлдэл;
2. Зохиогч ба зохион бүтээгчийн эрх зөрчсөний эцэст зохиогч ба зохион бүтээгч, эзэмшигчид эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус хохирол учирсан байдал;
3. Оюуны өмчийн эрх зөрчсөн үйлдэл, эс үйлдэл, учирсан хохирол хоёрын хоорондох шалтгаант холбоо;
4. Оюуны өмчийн эрхийг зөрчсөн этгээдийн гэм буруу / санаатай ба болгоомжгүй/ гэсэн дөрвөн бүрэлдэхүүнийг тогтоох хэрэгтэй юм.

Зарим ном бүтээлд зохиогчийн эрхийн зөрчил мөн үү гэдгийг тогтооход хэд хэдэн нөхцөл байдлыг харгалзан үзэх, тухайлбал тухайн зөрчил нь зохиогчийн эрхийн объектод халдсан эсэх, зохиогчийн эрхийг ямар нэгэн хувь хүн, эсвэл хуулийн этгээд эзэмшиж байгаа эсэх, эрх зөрчсөнөөс хохирол учирсан эсэх зэргийг тогтоох шаардлагатайгэж бичсэн байна.

Зохиол бүтээл болон патентын эрхийг хэн ямар арга хэлбэрээр хамгаалах вэ гэвэл дараах субъектийг нэрлэж болох юм.

- Юуны өмнө зохиолч туурвисан зохиол, зохион бүтээгч шинэ бүтээл, ашигтай загварыг санаачлан хийсэн бүтээлийн эрхээ өөрөө хамгаалах нь нэг талаар эрх, нөгөө талаар үүрэгтэй. Зохиолч, зохион бүтээгч бүтээлдээ нэр өгөх, нэрээ дуудуулах, хуулбарлах, олшруулах, бусдад төлбөртэй ашиглуулах, зохиол бүтээлээ үнэлэх, оюуны өмчийн газар бүртгүүлж баталгаажуулах, зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар эрх бүхий байгууллагад гомдол, нэхэмжлэл гаргах зэрэг нь оюуны өмчийн халдашгүй эрхээ өөрөө хамгаалж буй хууль ёсны үйлдэл болно. Үүргийн хувьд хэлбэл зохиогч ба зохион бүтээгч нь хүний мэдлэг боловсрол, оюун сэтгэхүйг тэлж хөгжүүлэх болон нийгмийн эдийн засгийн макро ба микро түвшиний үйлдвэрлэл, хэрэглээнд шинэ буюу шинэлэг агуулга, хэлбэртэй техник

сэтгэлгээг нэвтрүүлэхэд ач тустай зохиол бүтээл гүйцэтгэх үүрэгтэй. Ийнхүү хууль буюу гэрээнд заасан эрхээ хэрэгжүүлж, үүргээ биелүүлж байгаа нь зохиогч, зохион бүтээгч өөрөө өөрийнхөө эрхийг хамгаалж буй арга юм.

- Оюуны өмчийн эрхийг хамгаалах мэргэжлийн бөгөөд гол субъект нь оюуны өмчийн талаар төрийн бодлого, төлөвлөлт, чиг үүргийг шууд гардан хэрэгжүүлэх үүрэг бүхий Оюуны өмчийн газар байна.

Оюуны өмчийн газар нь оюуны өмчид хамаарах туурвисан зохиол болон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохион бүтээсэн мэдүүлгийг хүлээн авч хянан шийдвэрлэж гэрчилгээ олгох, оюуны өмчийн хуулийг нийгмийн амьдралд зүй зохистой хэрэгжүүлэх зорилгоор түүнийг биелэлт, хэрэглээг хянах, шалгах, сургалт сурталчлааг зохион байгуулах, зохиолч болон зохион бүтээгчээс зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар гаргасан гомдол, маргаан, хүсэлтийг хуульд заасан харъяалаал, эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх зэрэг арга хэлбэрээр оюуны өмчийн эрхийг хамгаална.

- Зохиогчийн эрхийн хуулийн 6-р зүйлд: Зохиогч уран бүтээлчид эрхээ хамгаалуулах зорилгоор төрийн бус байгууллага болох хамтын удирдлагын байгууллага байгуулж болохоор заасан. Хамтын удирдлагын байгууллага нь зохиогчийн эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах талаар гишүүдтэйгээ гэрээ байгуулахын зэрэгцээ тэдгээрийн зохиол бүтээлийг ашиглах иргэн, хуулийн этгээд, байгууллагатай зохиогчийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах, гишүүдийн зохиолыг хууль бусаар ашигласан тухай мэдэгдэлийн дагуу Оюуны өмчийн газартай хамтарч шалгалт хийх, холбогдох арга хэмжээ авах зэрэг аргаар оюуны өмчийн эрхийг хамгаална.
- Шүүх оюуны өмчийн эрхийг хамгаална. Оюуны өмчийн хууль, түүнтэй холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйлдэл, эс үйлдлийн шинж байдлаар нь шалгуур болгон эрүүгийн, захиргааны, иргэний эрх зүйн харилцаа

оногдуулдаг. Оюуны өмчийн эрхийн эсрэг үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй бол эрүүгийн хуульд зааснаар ял шийтгэл оногдуулах нь мэдээж. Хэрэв зөрчил нь эрүүгийн шинжийг агуулаагүй байвал шүүх буюу улсын байцаагч захиргааны хариуцлагын арга хэмжээ авахаар одоогийн мөрдөж байгаа хуульд заасан байна.

- Олон улсын жишиг чиг хандлагыг даган Монголын Үндэсний Арбитрын хуульд/2003/... эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаанд арбитрын ажиллагаа явуулахтай холбогдон үүссэн харилцааг зохицуулна гэж заасан. Ийнхүү хуулийн тодорхойлолт болон дараагийн бүлэг зүйлд Оюуны өмчийн маргаан гэж тухайлан заагаагүй ч эрх зүйн этгээдийн хооронд үүссэн эдийн ба эдийн бус маргаан гэдэгт оюуны өмчтэй холбогдсон маргаан зайлшгүй холбогдож байгаа юм. Дэлхийн улс оронд худалдааны, далайн, хөдөлмөрийн гэх мэт төрөлжсөн арбитрын шүүхийн зэрэгцээ нилээд улсад оюуны өмчийн арбитр байгуулагдан ажиллаж байна.

Оюуны өмчийн эрхийн эсрэг хууль бус халдлагын зүйл / объект / -ийг авч үзье. Оюуны өмчийн харилцаа нь бүхэл бүтэн цогц харилцаа байх бөгөөд түүний дотоод бүрэлдэхүүн нь нэг нь нөгөөгөө оршин байхыг нөхцөлдүүлсэн, хоорондоо харилцан холбоо сүлбээ бүхий олон төрөл чиглэлийн харилцааны бүрдэл хэсгүүдтэй байна.

Энэхүү бүтэц тогтолцоог иш үндэс болговол үүссэн зөрчил, маргаан нь оюуны өмчийн харилцааг бүхэлд нь, эсхүл түүний доторх тодорхой нэг харилцаанд хамаарах, хэрэв нэг харилцааг зөрчсөн үйлдэл бусаддаа хэрхэн нөлөөлөх зэрэг асуудлыг нарийвчлан нягталж үзэх нь онол, арга зүйн төдийгүй практик хэрэглээ болон маргааныг шийдвэрлэх хуулийн зүйлчлэлд чухал байдаг.

Дээр дурьдсан харилцаа, түүнд халдсан зөрчлийг хураангуйлан хэлбэл зохиогчийн бүтээлийн эд хөрөнгийн бус амин хувийн харилцаанд чиглэсэн зөрчил, тухайлбал зохиогчийн чөлөөтэй

туурвиж, хэвлэн нийтлэх эрхийг хавчих, хязгаарлах, зохиогчийн зөвшөөрөлгүй хувилах, олшруулах, тараах гэх мэт зохиогчийн туйлын халдашгүй эрхийн зөрчил байхын зэрэгцээ зохиогч буюу эзэмшигчийн эд хөрөнгөтэй холбогдох зөрчил, тухайлбал зохиогчийн зөвшөөрөлгүйгээр бүтээлийг хуулбарлах, олшруулах, өөрчлөх, засварлах, орчуулах, худалдах, танилцуулах зэрэг зөрчил хамаарна.

Дурьдан буй хууль бус үйлдэл, эс үйлдлийн эцэст, нэгд: зохиогчийн халдашгүй амин хувийн эрх зөрчил нь түүний нэр, нэр төр, алдар хүндийг үл хүндэтгэсэн уриагүй үйлдлийн сөрөг үр дагавар нь сэтгэл санаанд учирсан хохирол байж болно.

Хоёрт: зохиол бүтээлийг хууль бус ашигласан этгээдэд тодорхой ашиг, орлого бий болж, зохиогчид тэр хэмжээгээр орох ёстой байсан орлого үгүйсгэгдэж, эд хөрөнгийн хохирол учирсан байна.

Хууль бус үйлдэл, эс үйлдэл, түүний эцэст бий болсон хохирол баймааж, тэдний хоорондын шалтгаант холбоог тодорхойлох ёстой. Хэрэв холбоогүй бол хариуцлагын тухай ярьгдахгүй нь мэдээж. Жишээ нь зохиогчийн зөвшөөрөлгүйгээр түүний зохиол, бүтээлийг дур мэдэн засварласан нь бүтээлийн зорилго, зориулалт, утга санаа агуулгатай зарчмын зөрүүтэй болж, үүссэн маргааныг хянан шийдвэрлэхдээ юуны өмнө хуульд заасан зөвшөөрөл авах үүрэгтэй байсан атал аваагүй хууль бус үйлдэл болохыг анхаарах, хийсэн засвар нь тухайн зохиолын анхны бөгөөд суурь агууллагад тохирохгүй болсон, үүний улмаас өмнө дурьдсан хохирол учирсан эсэхийг орон зай, цаг хугацаа, нөхцөл байдалд нь холбогдуулан авч үзнэ гэсэн ойлголт юм.

Оюуны өмчийн эрх зүйд хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл бол гэм буруу байна. Гэм буруу нь оюуны өмчийн эрх зөрчигчийн санаа сэтгэхүйтэй холбоотой ойлголт байдаг. Нөгөө талаар санаа зориг нь хууль бус идэвхитэй ба идэвхигүй үйлдлээр илэрдэг. Эцэст нь хууль бус үйлдлийн эцсийн үр дагавартай шууд холбоотой байна. Энэ байдлаас авч үзвэл гэм буруу бол оюуны өмчийн эрх зөрчигчийн үйлдэлдээ харьцах санаа зоригийн хэлбэр юм.

Оюуны өмчийн эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл нь санаатай ба болгоомжгүй хэлбэртэй байх бөгөөд амьдралд санаатай үйлдэл зонхилж байдаг. Бусдын зохиол, бүтээлийг хууль буюу гэрээний нөхцөлд шууд хориглосон заалтыг эрх зөрчигч этгээд өөрийн үйлдэл, эс үйлдлийн эцсийн үр дагаварыг хууль бус болохыг мэдсэн, мэдэх боломжтой байсан боловч түүнийг зориуд хүсэж үйлдсэнийг санаатай хэлбэр гэнэ.

Зохиогчийн зохиолыг орчуулах, жүжиг буюу киноны зохиол болгон өөрчлөхдөө утга агуулгын алдаа гаргасан, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг үйлдвэрлэлд нэвтрүүлэхдээ хайхрамжгүй, эсхүл мэдлэг чадвар дутсанаас буруу зөрүү хэрэглэснээс хохирол учирч болох ийм тохиолдолд бий болсон зөрчлийг болгоомжгүй хэлбэр гэнэ.

Оюуны өмчийн харилцаа, түүний эрх зүйн зохицуулалт болох хууль, бусад холбогдох хуульчилсан актыг зөрчсөн этгээдэд хэн, ямар хэлбэрийн хариуцлага хүлээлгэх тухай асуудал бол энд зайлшгүй хөндөгдөж ярилцах гол сэдвийн нэг мөн.

Хариуцлага гэдэг үг нийгмийн амьдралд өргөн ба явцуу утгаар хэрэглэгддэг. Бие хүний нийгэмд эзлэх байр суурийг тодорхойлж, төр хамт олон, иргэний өмнө хүлээх үүргээ ухамсарлан биелүүлэх хариуцлага байна. Энэ утгаараа нийгэм, улс төр, ёс суртахууны хүрээг хамарсан өргөн ойлголт юм. Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээ болон гэрээгээр харилцан тохиролцсон эрх, үүргийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага байна. Үүний арай явцуу хүрээнд хэрэглэнэ хэмээн ойлгож болно.

Оюуны өмчийн эрх зүйд хариуцлага нь хууль зүйн шинжлэх ухаан дахь хариуцлагын ерөнхий зарчим, чиг үүргийг гүйцэтгэх нийтлэг шинжийг агуулахын сацуу өвөрмөц өөрийн онцлогтой. Оюуны өмчийн эсрэг чиглэсэн хууль бус үйл явдлын гэм буруу, нийгмийн хор аюул, эд хөрөнгө болон сэтгэл санаанд учруулсан хохирол, үйлдлийн шинж байдлыг шалгуур болгон эрүүгийн, захиргааны, иргэний хариуцлага гэсэн төрөлтэй болохыг өмнө дурьдсан.

Оюуны өмчийн эсрэг үйлдэл нь эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй болох нь нэгэнт нотлогдсон бол эрүүгийн ял шийтгэл хүлээлгэх нь мэдээж. Тухайлбал, эрүүгийн хуулийн 140-р зүйлд: зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлан нийтлүүлсэн, түгээсэн, борлуулсан, тэдгээрийн улмаас их хэмжээний орлого олсон бол, 141-р зүйлд: шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загварын гэрчилгээ эзэмшигчийн эрхийг зөрчсөн бол тус тус эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Хэрэв оюуны өмчийн эсрэг үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал оюуны өмчийн харилцааг зөрчсөн тохиолдолд Оюуны өмчийн газрын дэргэдэх маргаан таслах комисс, шүүх, улсын байцаагч гэсэн гурван субъект захиргааны ба иргэний хариуцлага оногдуулах бөгөөд тэгэхдээ Зохиогчийн ба Патентын хуульд хэн нь хариуцлагын ямар хэлбэр хэрэглэхийг ялгавартай байхаар заажээ. Тухайлбал маргаан шийдвэрлэх комисс маргагч талуудын аль нь зөв, эсхүл буруут тогтоож шийдэх, улсын байцаагч торгох, харин шүүх торгох, баривчлах, хууль бусаар олсон орлогыг хураан авч улсын орлого болгох асуудлыг хуульд заасан эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэнэ. Чухам ямар хэлбэр, хэмжээний хариуцлага оногдуулахыг хууль нэгэнт тодорхой тогтоосон тул энд нуришн тоочих шаардлагагүй гэж үзлээ.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль УБ, 1992он, 16.8-р зүйл
2. Д.Цолмон. Оюуны өмчийн эрх зүй УБ, 2003, 48 дахь тал
3. Зохиогчийн эрхийн хууль 1993, 6-р зүйл
4. Монгол Улсын Арбитрын хууль, 2003, 1-р зүйл
5. Т.Мөнхжаргал Иргэний эрх зүй УБ, 2009, 188 дахь тал
6. Монгол Улсын Патентын хууль, 2006, 29-р зүйл

С.БАТБУЯН

СЭЗДС-ийн ХУТ-ийн багш, докторант

Б.ДЭЛГЭРМАА

СЭЗДС-ийн ХУТ-ийн багш, Дэл проф. докторант

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН БАТАЛГААЖИЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

1. Оюуны өмчийн эрхийн баталгаажилтын тухай өгүүлэхэд
2. Гадаадын зарим улс орны газар зүйн заалтын эрхийн баталгаажилтыг авч үзэх нь
3. Эцэслэн хэлэх санал

Өмнөтгөл

Дэлхий ертөнц дээрх материаллаг баялагийн эрэлт, хэрэгцээ нийгмийн анхаарлын төвд байсаар ирсэн. Гэвч материаллаг бус оюун санаа сэтгэхүйн бодит илрэл болох оюуны өмч эдийн засаг, гоо зүйн харилцаанд чухал байр суурь эзэлдэгийг хүн төрөлхтөн аль хэдий нь хүлээн зөвшөөрөх болоод олон арван жилийн нүүр үзжээ. Хүний оюун санааны хязгааргүй сэтгэлгээний үр дүнд бий болсон оюуны өмч хөрөнгийг хамгаалах, баталгаажуулах механизм бүрдсэн нийгэмд зохиогч, эрх эзэмшигчийн хууль ёсны эдийн болон эдийн бус эрх хангагдаж оюуны хөдөлмөрийн үнэ цэнийг нийгэм даяар ойлгодог. Оюуны төрөл бүрийн өмчийн эрхийн баталгаажилтыг хангах маш чухал арга хэрэгсэлд хууль зүйн механизм буюу эрх зүйн зохицуулалтыг дурьдахгүй байхын аргагүй. Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй дараах хуулиуд уг асуудлыг голлон зохицуулдаг. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай гэх хуулиудаар эрхийг баталгаажуулахаас гадна зохицуулалт шаардлагатай эрхийн баталгаажилтын харилцаанд салбарын бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрүүдээр нөхөн зохицуулах шинжтэй байна. Оюуны өмчийн зүйл олон төрөл хэлбэрээр илэрдэг. Үүнд: Зохиогчийн эрхэд хамаарах зүйл, шинжлэх ухаан, утга зохиол,

урлагийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар, барааны тэмдэг, газар зүйн заалт гэх зэрэгтэй холбоотой эрхийг баталгаажуулах асуудлыг тус бүрд нь судалж дүгнэлт санал өгөх зорилго илтгээд тавьсангүй харин нийгэмд ойлгомжгүй тусдаг, явцуу хүрээнд хэрэглэгддэг эрхийн баталгаажилт хийх хэрэгцээ, шаардлагыг ард олон төдийлэн ухаардаггүй оюуны өмчийн салбарт нилээд онцлог объектод тооцогддог газар зүйн заалтын эрхийн баталгаажилтыг судлан боловсронгуй болгох арга замыг санал болгохыг зорисон болно.

1. Оюуны өмчийн эрхийн баталгаажилтын тухай өгүүлэхэд: Оюуны өмчийн эрхийг баталгаажуулснаар зохиогч, эрх эзэмшигчид, аюулгүй хэнээс ч хараат бус оюуны өмчийн зүйлийн хувьд эдийн засгийн болон эдийн бус эрхээ эдлэх баталгаат боломж нь үүсдэг. Хэрэв баталгаажуулаагүй нөхцөлд хэн нэгнээс хараат, өмчийг дагсан хууль ёсны эрхийн хэрэгжилт зөгсөнг байдалтай байдаг. Хүний өмчийн эрх, эрх чөлөөг дээдэлсэн, хүлээн зөвшөөрсөн нийгэмд оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг хууль тогтоомжоор зохицуулсан байдаг. Монгол улс оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг хууль зүйн механизмаар хэрэгжүүлдэгийг Патентын тухай хуулийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхийг баталгаажуулах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино"¹ гэсэн заалтаас харж болохоор байгаа юм. Энд патент, гэрчилгээ эзэмшигчийн өмчлөх эрхээ эрх бүхий байгууллагад хандан баталгаажуулах эрх зүйн хүрээнд олгогдсон боломж. Түүнчлэн Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 1.1-т "Энэ хуулийн зорилт нь бараа, үйлчилгээний тэмдэг /цаашид "барааны тэмдэг" гэх/, газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах, түүнийг эзэмшигч, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, барааны тэмдэг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, газар зүйн заалтыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино"² газар зүйн заалтыг эрх зүйн хувьд баталгаажуулах гэж оруулснаар хуулийн хэм хэмжээний

1 Патентын тухай хууль 2006 он УБ., 1.1 дэх заалт

2 Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль 2010 он УБ., 1.1 дэх заалт

нийтлэг үндэслэл нь болж өгч байна. Хуульд зааснаар оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг хэрхэн хийдгийг үзье. Патентын тухай хуулийн 7.1-т “Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд Оюуны өмчийн газарт гаргана”³ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуульд зохиогчийн эрх баталгаажих нөхцлийг тусгасан⁴. Энэ объектын хувьд хуулийн 9.1, 9.2, 9.3, 9.5-т тус тус зааснаар хоёр үндэслэлээр эрх үүсч, баталгаажна. 1. Бодитой туурвиж бүтээсэн үеэс үүсч, түүнд баталгаажилт шаардахгүй байх 2. Бүтээл ашиглах онцгой эрхээ бусдад шилжүүлэх гэрээ, хэлцлийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх. Эндээс үзэхэд зохиогчийн эрхийн баталгаажилт нилээд онцлог болох нь харагдаж байна. Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулийн 6.1-д “Барааны тэмдгийг бүртгүүлэх хүсэлтэй иргэн, хуулийн этгээд барааны тэмдгийн мэдүүлгийг төрийн захиргааны байгууллагад монгол хэлээр гаргана” мөн тус хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Газар зүйн заалтад хамаарч байгаа бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг нэгтгэсэн, газар зүйн заалт бүртгүүлэх хүсэлтэй нэгдэл, холбоо, байгууллага нь тухайн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийг төлөөлөх хуулиар олгосон эрхийн дагуу газар зүйн заалтыг бүртгүүлэхээр мэдүүлгийг төрийн захиргааны байгууллагын тогтоосон журмын дагуу бичгээр гаргана”⁵ дээрх баталгаажилтын зохицуулаалуудыг задлан шинжилж хүснэгт хэлбэрээр харвал:

3 Патентын тухай хууль 2006 он УБ., 7.1 дэх заалт

4 Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль УБ., 2006 он /9.1. Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг бодитойгоор туурвиж бүтээсэн үеэс үүснэ 9.2.Зохиогчийн эрх үүсэх болон түүнийг хэрэгжүүлэхэд баталгаажуулалт шаардахгүй. 9.3.Бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь эрхээ нийтэд таниулах зорилгоор зохиогчийн эрх хамгаалагдсаныг илэрхийлэх тавих тэмдэг хэрэглэх эрхтэй./

5 Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль 2010 он УБ., 6.1 дэх заалт /6.2.Барааны тэмдгийн мэдүүлгийг мэдүүлэг гаргагч өөрөө, эсхүл энэ хуулийн 31 дүгээр зүйлд зөвсөн оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүрлэн гаргана./

6 Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хууль 2010 он УБ., 21.1 дэх заалт

д/д	Оюуны өмчийн зүйл	Хэн хандах	Хаана хандах	Ямар баримт гаргах	Эрх үүсэх
1.	Шинэ бүтээл, бүтээг-дэхүүний загвар, ашигтай загвар	Зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд	Оюуны өмчийн газарт	Мэдүүлэг	Патент, гэрчилгээ олгосон
2.	Шинэчлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл	Бүтээл ашиглах өндгөй эрх эзэмшигч /зохиогч, өндгөй эрх олж авсан этгээд/	Оюуны өмчийн газарт / сайн дурын үндсэн дээр/	Бүтээл ашиглах хэлцэл, гэрээг бүрт-гүүлэх	Зохиогчийн эрх үүсэхэд баталгаажилт шаардахгүй, бодитой туувсан үеэс үүснэ.
3.	Барааны тэмдэг	Иргэн, хуулийн этгээд,	Оюуны өмчийн газарт	Мэдүүлэг	Бүртгэж гэрчилгээ олгосноор
4.	Газар зүйн заалт ⁷	Нэгдэл, холбоо, байгууллага ОӨИТ	Оюуны өмчийн газарт	Мэдүүлэг	Бүртгэж гэрчилгээ олгосноор

Хууль, тогтоомжид зааснаар дээрх байдлаар оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг хийж байна. Газар зүйн заалтын эрхийн баталгаажилтыг тухайлан авч үзэхийг чухалчиллаа. Иймд газар зүйн заалтын ойлголтод анхаарлаа хандуулая. Дотоодын хууль, олон улсын гэрээ, конвенцид 3.1.4-т "газар зүйн заалт гэж тухайн газар нутгийн байгаль, цаг уурын нөхцөл, эсхүл тухайн газар нутгийн хүмүүсийн дадал заншил зэрэг хүчин зүйлээр

7 Монгол улсад ӨОБ-ын судалгаагаар 2006–2013 онд 17 газар зүйн заалт бүртгэгдсэн байдаг.

тодорхойлогдсон чанар, нэр хүнд, бусад онцлог шинж чанар бүхий бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн улс, бус, газар нутгийн газар зүйн тодорхойлолтыг” мөн Дэлхийн оюуны өмчийн /ДӨОБ/ болон Дэлхийн худалдааны байгууллагын /ДХБ/ тодорхойлсноор “Газар зүйн заалт нь газар зүйн онцгой гарал үүсэлтэй, онцлог чанарыг агуулсан, газар нутгийн байршлаараа нэр хүндтэй, бараан дээр хэрэглэгддэг ялгагдах чадвартай тэмдэг юм” Газар зүйн заалт зөвхөн үйлдвэрлэгчид бус хэрэглэгч, орон нутгийн иргэд аль алинд нь олон талын ашиг авчрах боломжтой. Дээрх тодорхойлолтыг нэгтгэн үзвэл 1/ байгаль, цаг уурын нөхцөл, хүмүүсийн дадал, заншил зэрэг хүчин зүйлээр тодорхойлогддог. 2/ онцгой гарал үүсэлтэй, байршлаараа нэр хүндтэй бараан дээр хэрэглэгддэг.

2. Гадаадын зарим улс орны газар зүйн заалтын эрхийн баталгаажилтыг авч үзэх нь

1883 оны Парисын конвенц¹⁰ нь хамгийн анх бараа, бүтээгдэхүүний эх үүсвэр, гарал үүслийг оюуны өмчийн нэгэн хэлбэр хэмээн бусад оюуны өмчийн хэлбэрүүдтэй ижил гэдгийг зааж өгснөөрөө ач холбогдолтой юм. Улмаар Барааны гарлын газрыг буруу тэмдэглэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тухай 1891 оны Мадридын хэлэлцээрээр барааны гарлын талаар буруу, төөрөгдүүлсэн тэмдэглэгээ хэрэглэсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр зааж өгсөн байна. “Барааны гарлын газрыг заасныг хамгаалах тухай” 1958 оны Лиссабоны хэлэлцээр¹¹ Швейцар дахь Лиссабоны холбоонд гарлын газрыг бүртгэх механизм бий болгосон. Энэхүү хэлэлцээрийг цөөн тооны хэдэн орон соёрхон баталсан тул тухайн үедээ олны анхаарлыг татаж чадаагүй. Үүний гол шалтгаан нь олон улсын хамгаалалтыг бий болгохдоо тухайн улсын үндэсний бүртгэл дээр үндэслэх

8 Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль УБ., 2010 он. 3.1.4 дэх заалт

9 Газар зүйн заалт 2012 он. УБ., /гарын аллага/ 2 дэх тал Патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын хэлтэс. МХАҮТ

10 The Paris Convention for the Protection of Industrial Property was agreed in 1883 and complemented by the Madrid protocol of 1891. <http://www.wipo.org>

11 The Agreement for the Protection of Appellations of Origin and their International Registration was concluded in Lisbon on 31 October 1958. <http://www.wipo.org>.

Уг хэлэлцээрт олоогийн байдлаар 27 орон нэгдээд байна.

ёстой байсан юм. Тэдгээр орнууд нь оюуны өмчийн эрхийг шударга бус өрсөлдөөний болон хэрэглэгчийн эрхийн хуулийн хүрээнд зохицуулж байсан нь Лиссабоны хэлэлцээрт хамрагдах боломжийг олгоогүй юм¹². Учир нь **sui generis**¹³-н тогтолцоог эхлэн бий болгох ёстой байв.

ТРИПС-ийн хэлэлцээр¹⁴ бол газар зүйн заалтыг оюуны өмчийн тусгай бие даасан хэлбэр гэж үзсэн дэлхий дахинд зөвшөөрөгдсөн хэлэлцээр байв. Уг хэлэлцээрийн II хэсэг, 3-р бүлэг нь газар зүйн заалт түүнтэй холбоотой харилцааг зохицуулахад зориулагдсан байдаг. ТРИПС-ийн хэлэлцээрээр гурван төрлийн хамгаалалтын аргыг бий болгосон.

1. Бүх төрлийн бараа, бүтээгдэхүүнд "ерөнхий" болон "стандарт" хамгаалалт

2. Дарс, спиртийн төрлийн ундааны газарзүйн заалтын нэмэгдэл эрхийн хамгаалалт¹⁵

3. Зөвхөн виныны хувьд "туйлын нэмэлт хамгаалалт"¹⁶-ыг тус тус тогтоожээ.

ТРИПС-ийн хэлэлцээр нь газар зүйн заалтын олон улсын эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөнөөрөө ач холбогдолтой төдийгүй гишүүн орнуудад газар зүйн заалтыг хэрхэн хамгаалах, хэрэглэх талаарх удирдамж болж байна. Өнөөгийн байдлаар гишүүн орнууд үндсэн хоёр сонголттойгоор газар зүйн заалтын хамгаалалтыг хэрэгжүүлж байна.

1. **Sui generis**-н хамгаалалт

2. Холбогдох хууль тогтоомжийн дагуу. Тухайлбал: барааны тэмдгийн тухай, шударга бус өрсөлдөөний тухай, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, захиргааны холбогдох хуулийн дагуу гэх мэт

Sui generis-н бүртгэл дээр тулгуурладаг газар зүйн заалтын

12 Study for possible negotiations on GLs Agreement between China and the EU. <http://www.ipr2.org>

13 *Sui generis*- латин гаралтай үг. Ямарваа нэг юмны хэлбэр, төрх, өөрийх нь шинж гэсэн агуулгатай.

14 The Agreement on Trade-Related Intellectual Property Rights. <http://www.wipo.org>. ДХБ-ын хэлэлцээрт ТРИПС хэлэлцээр багтсан. 1995.01.01-нд хүчин төгөлдөр болсон.

15 ТРИПС-ийн хэлэлцээрийн 23-р эцсийн үг.

16 ТРИПС-ийн хэлэлцээрийн 23-р эцсийн 3 ба 4-ийг ялан цэнэ үг.

хамгаалалт юм. Гэвч зарим орнууд тухайлбал Сингапур, Иордан, Шри Ланкад заавал хуулиараа бүртгүүлэхийг шаарддаггүй. Харин Энэтхэг, Мавритан, Оман, Катар зэрэг улсуудад бүртгэл байдаг хэдий ч заавал бүртгүүлснээр хамгаалалтанд орно гэж үздэггүй. Энэтхэгийн хувьд "Бараа бүтээгдэхүүний газар зүйн заалтын хууль"-ийн/1999.2002/¹⁷ дагуу газар зүйн заалтыг бүртгүүлэх мэдүүлэг гаргаснаар бүртгүүлнэ. Гэхдээ бүртгүүлэх нь заавал биш бөгөөд бүртгүүлээгүй ч хамгаалагдана гэж үздэг. Гэхдээ бүртгүүлж сертификат авахыг зөвлөдөг. Учир нь дараа дараагийн процесст тустай гэж үздэг байна. Хамгаалалтын хугацаа 10 жил, дахин 10 жилээр сунгаж болно. Газар зүйн заалтын тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага нь Барааны тэмдэгийн хууль зөрчигчид хүлээлгэх арга хэмжээтэй төстэй байдаг. Энэ тохиолдолд эрүүгийн болон иргэний хариуцлага хүлээлгэдэг. Тухайлбал: 6 сараас 3 жил хүртэл хорих, тэнсэн харгалзах, 50 мянгаас 2.0 сая хүртэл рунгээр торгох гэх мэт¹⁸.

Ихэнх *sui generis*-г хэрэгжүүлдэг улс орнуудад газар зүйн заалтыг хамгаалалтын объект болгохын тулд бүртгүүлсэн байхыг шаарддаг байна. Маш олон төрлийн бүртгэлийн систем үйлчилж байна. Хэр өргөн хүрээнд энэхүү системийг хэрэглэж буй нь л гол ялгаа нь болж байна. Ер нь ямар бүтээгдэхүүнд зорнулж, ямар нэрийг бүртгэх бүртгэл хийх процесс нь янз бүр байдаг. Тухайлбал: Хятадад Барааны тэмдэгийн тухай болон Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний газар зүйн заалтын хэмжүүрийн тухай хуулиар¹⁹ газар зүйн заалтын харилцааг зохицуулж байна. Хуулиндаа газар зүйн заалт нь ямар нэг шошго, сертификатаар баталгааждаг төдийгүй газар зүйн заалтын хамгаалалт авахыг хүсэгч үндэсний үйлдвэрлэгчид урьдчилсан нөхцөл тавигддаггүй. Харин гадаадын газар зүйн заалтын хувьд тусгайлсан зохицуулалт байхгүй байна²⁰. Дэлхийн ихэнх улсад заавал бүртгүүлснээр

17 *The Geographical Indications of Goods Act, 1999. The Geographical Indications Rules, 2002.*

18 *Laws of Geographical Indications and Plant Varieties in India. By Vijay Pal Dalmia*

19 *The Trademark Law, the Provisions on the Protection of geographical Indication Products and the Measures for Administration of Geographical Indications of Agricultural Products.*

20 *Protecting Foreign Geographic Indications in China. By King and Wood on January 23, 2012 Posted in Intellectual Property*

хамгаалагдаж, баталгаажна гэсэн зохицуулалт төдийлэн алга байна. Монгол улсын хувьд дан ганц бүртгүүлснээр баталгааждаг тогтолцоо нь олон улсын жишгээс хөндий зохицуулалттай гэж үзэж байна. ТРИПС-ын дагуу бүртгүүлснээр баталгааждаг тогтолцооны үндэс нь нотлох чадварын илэрхийлэлтэй холбогдон бий болсон гэж үзэж байна.

Эцэслэн хэлэх санаа

Ихэнх улс орон оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг хууль зүйн механизмаар хэрэгжүүлдэг нь харагдлаа. Монгол улсын хувьд Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай, Барааны тэмдэг газар зүйн заалтын тухай хуулиар тус тус баталгаажуулж байна. Дэлхий нийтийн жишгийн дагуу **sui generis**-ын хамгаалалтын хэлбэртэй²¹ буюу бүртгүүлснээр хамгаалалт тогтох механизм үйлчилдэг.

1. Оюуны өмчийн эрхийг баталгаажуулснаар зохиогч, эрх эзэмшигчийн эдийн засгийн ашиг сонирхлыг хангахаас гадна эдийн бус эрх ашгийг ч ханган хамгаалах ач тустай.

2. Оюуны өмчийн онцлог объект болох Газар зүйн заалтын эрхийг баталгаажуулснаар орон нутаг, бүс нутгийн хөгжил, иргэдийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлдэг.

3. Газар зүйн заалтын ойлголт, баталгаажилтыг олон нийтэд сурталчилж үр өгөөжийг нь нийгмийн сэтгэл зүйд хүргэх ажлыг зохион байгуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.

4. Оюуны өмчийн эрхийн баталгаажилтын асуудал эрхэлсэн байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зохистой хуваарилж эрх эзэмшигчид үзүүлэх үйлчилгээний чанар өгөөжийг нэмэгдүүлж, хүртээмжтэй, ил тод болгох.

5. Гадаадын улс оронд оюуны өмчийн зарим объектын талаарх хоёр талт гэрээ, хэлэлцээр хийсэн байдаг. Тухайлбал: Газар зүйн заалтын талаар гэх мэт. Харин манай улс экспортлогч улс болохын хувьд тухайн улстай Газар зүйн заалтын эрхийн баталгаажилтын хэлэлцээр хийх шаардлагатай. Жишээ нь: Монгол улс хаврын улиралд монгол ямааны ноолуураа Хятад улсруу экспортолдог. Дэлхийн бараа бүтээгдэхүүны зах зээл

дээр манай ноолуурыг Хятад улсад үйлдвэрлэсэн Хятад улсын ноолуур хэмээн олон улсад хүрч байгаа нь хоёр талт хэлэлцээр хийх нийгмийн шаардлага байгааг харуулж байна.

6. Оюуны өмчийн эрх тэр дотор ялангуяа Газар зүйн заалтын эрх заавал бүртгүүлснээр бус олон нийтэд түгээмэл болсноор хүчтэй хамгаалаат тогтох механизмыг хууль тогтоомжоор зохицуулж өгч Энэтхэг, Сингапур улсын туршлагыг тус тус нэвтрүүлэх саналтай байна.

Оюуны өмчийн эрхийн баталгаажилат өндөр хөгжсөн улсад хүн мөнхийн бүтээгч байдаг.

IMPROVING GUARANTEE OF INTELLECTUAL PROPERTY

It's long been known that intellectual property plays major role in I terms of economic, aesthetic relationship. The man kind already accepted the importance of the intellectual expression and in the society which constituted the protection, guarantee of intellectual property widely understands its valued aspects. It is impossible not to mention about the legal mechanism which provides the protection. Most countries provide legal shield for the intellectual property right. As practiced in the rest of the world, Mongolia implements sui generis system as soon as the property has registered. We have illustrated the following issues

1. The Intellectual Property right protection
2. Intellectual property right protection in terms of Geographical indication of foreign countries.

Б.ОЮУНЦЭЦЭН

Оюуны Өмчийн Газрын аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн
хэлтсийн олон улсын барааны тэмдгийн шинжээч

БАРААНЫ ТЭМДГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОГТОЛЦОО

Барааны тэмдэг гэж юу вэ?

“Барааны тэмдэг” гэж иргэн, хуулийн этгээд өөрийн бараа, үйлчилгээг бусад этгээдийн бараа, үйлчилгээнээс ялгах зорилгоор хэрэглэх ялгагдах чадвартай илэрхийллийг хэлнэ.

Барааны тэмдэг нь үг, дүрс, үсэг, тоо, гурван хэмжээст дүрс, өнгө, дуу авиа, үнэр, эсхүл тэдгээрийг хосолсон байдлаар илэрхийлэгдэж болно.

Бараа, үйлчилгээний эх үүсвэрийг нь илэрхийлдэг барааны тэмдгээс гадна хэд хэдэн төрлийн тэмдгүүд байдаг.

Хамтын тэмдэг	Холбооны гишүүдийн үйлдвэрлэж байгаа бараа болон үзүүлж буй үйлчилгээг ялгах тэмдэг.
Гэрчлэх тэмдэг	Эрх бүхий байгуулагаас гэрчилсэн, тогтоосон шаардлагыг хангасан бараа үйлчилгээг ялгах тэмдэг
Нийтэд түгээмэл болсон тэмдэг	Зах зээлд нийтэд түгээмэл болсон бөгөөд үүний үр дүнд хүчтэй хамгаалалттай болсон тэмдэг.

Барааны тэмдгийн ач холбогдол

- Хэрэглэгч бараа бүтээгдэхүүнийг ялгах баталгаа болно.
- Арилжааны хэрэгсэл болж брэндийн дүр төрх, нэр хүндийг бий болгох үндэс нь болно.
- Лицензээр ашиглуулж болох бөгөөд шимтгэлт төлбөр авснаар орлогын шууд эх үүсвэрийг бий болгоно.
- Таны бизнесийн үнэлшгүй хөрөнгө болно.

- Бараа бүтээгдэхүүнийхээ чанарыг сайжруулах, хадгалахад зориулсан хөрөнгө оруулахад компаниудыг дэмжинэ.
- Санхүүжилт олж авахад ашигтай

Барааны тэмдгийн бүртгэлийн систем

- **Барааны тэмдгийн мэдүүлэг гаргах**

Барааны тэмдгийг бүртгүүлэх хүсэлтэй

- **иргэн,**
- **хуулийн этгээд**
- **Барааны тэмдгийн мэдүүлэгт шүүлт хийх**
9 сар + 6 сар
- **Барааны тэмдгийг бүртгэх, хэвлэх**
Эрхийн хамгаалалтын хугацаа
- **Барааны тэмдгийн гэрчилгээ 10 жил**
- 10, 10 жилээр сунгана.

Барааны тэмдгийн хамгаалалтын эрх зүйн орчин

- **Барааны тэмдэг, аж ахуйн нэрийн тухай хууль**
Батлагдсан 1996.12.09
Хүчин төгөлдөр болсон 1997.02.01
- **Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль**
Батлагдсан 2003.05.02
Хүчин төгөлдөр болсон 2003.08.21
- **Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль**
Батлагдсан
Хүчин төгөлдөр болсон 2010.06.10
- **Барааны тэмдгийг бүртгэх, улсын бүртгэл хөтлөх, тэдгээрт өөрчлөлт оруулах журам (2011)**

Олон улсын гэрээ хэлэлцээрүүд

- Барааны тэмдгийн олон улсын бүртгэлийн тухай Мадридын Хэлэлцээр, Протокол
- Барааны тэмдгийг бүртгэх зорилгоор Бараа, үйлчилгээний олон улсын ангилал тогтоох Ниццийн хэлэлцээр
- Барааны тэмдгийн хуулийн тухай Сингапурын гэрээ
- Олимпын билэг тэмдгийг хамгаалах тухай Найробийн гэрээ

Д.ДЭЛГЭРЦОО

Оюуны Өмчийн Газрын хяналтын хэлтсийн дарга

ОЮУНЫ ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ АСУУДЛУУД

Монгол Улс “Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллага Байгуулах тухай конвенц”-ийг 1978 оны 10 дугаар сарын 10-ны өдөр соёрхон баталж, Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагад нэгдэн орсноор өдгөө 35 жил өнгөрч, Монгол Улсын оюуны өмчийн тогтолцоо нь хөгжлийн тодорхой үе шатыг туулан бусад улс орны нэгэн адил дэлхийн жишигт нийцэн боловсронгуй болжээ.

Энэ хутагаанд Дэлхийн Оюуны Өмчийн байгууллагаас хэрэгжүүлж буй оюуны өмчийн талаархи 16 олон улсын гэрээ, хэлэлцээрт Монгол Улс нэгдэн орж, тухайн гэрээ, хэлэлцээрийн утга агуулга, зүйл, заалт болон гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүрэг Монгол Улсын үндэсний хууль тогтоомжид тусгалаа олж, Монгол Улс нь оюуны өмчийн эрх зүйн салбарын хувьд Ази-Номхон далайн бүсийн орнуудад тэргүүлэх, жишиг улсуудын нэг боллоо.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 7, 16 дугаар зүйлд оюуны өмчийн эрхийн талаар заасны дагуу дэлхий нийтийн чиг хандлагад нийцсэн оюуны өмчийн тогтолцоо бүрэлдэн бий болох үндэс болсон.

Түүгчлэн оюуны өмчийн бие даасан хуумуд батлагдаж (“Монгол Улсын Патентын тухай хууль” 1993, 2006он, “Зохиогчийн эрхийн тухай хууль” 1993 он, “Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хууль” 1996 он, “Зар сурталчилгааны тухай хууль” 2002 он, “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль” 2006 он, “Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль” 2010 он) оюуны өмчийн улсын хяналтын тогтолцоо бүрэлдэн бий болж, оюуны өмчийн зохиогч, эрх эзэмшигчдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин шивнэчлэн бүрэлдсэн.

Эрх зүйг төрийг төлөвшүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд болон оюуны өмчийн харилцаан дахь чухал үүрэг гүйцэтгэх хөшүүрэг нь оюуны өмчийн хяналтын тогтоолцоо юм.

Жилээс жилд оюуны өмчийн бүтээлүүд өсөн нэмэгдэж, түүнийг захиран зарцуулахад /бүтээх, худалдан борлуулах, нийгэд түгээх, сурталчлах/ сөрөг хүчин зүйлүүд үүсч, олон улсын худалдаанд үндэстэн дамнасан оюуны өмчийн зөрчил, хулгайгарах болсон явдал нь олон улсад шинээр эрх зүйн зохицуулалт бий болгох, нэгдмэл хүчээр түүнтэй тэмцэх явдлыг зүй ёсоор шаардаж байна.

Ийм ч учраас Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагаас гаргасан "Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр"-т /TRIPS Agreement/ 1997 оны 1 дүгээр сарын 29-нд нэгдэн орсон юм.

Дэлхийн Гаалийн Байгууллага, Олон улсын худалдааны танхим, Интерполын судалгаагаар жил бүрдэл хийн нийт худалдааны эргэлтийн 5-7 хувийг оюуны өмчийн эрхийн зөрчилтэй /хуурамч/ бараа бүтээгдэхүүн эзэлж, 600 тэрбум долларын ашиг алдагдсан тооцоо гарсан байна.

Олон улсад хууль бус хуурамч бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнийг зарж борлуулах цар хүрээ, төрөл хэлбэр өргөжин тэлсээр байна. Түүгээр барахгүй олон улсын байгууллагуудаас олон улсын "террорист" үйл ажиллагааны санхүүгийн зарим эх үүсвэр нь хууль бус хуурамч бараа, бүтээгдэхүүний орлогоос бүрдэж байгааг анхааруулсаар байгаа нь тив, улс үндэстний аюулгүй байдалд халдах аюул нүүрлэж байгааг илтгэж байна. Оюуны өмчийн зөрчилтэй /хуурамч/ бараа бүтээгдэхүүн нь оюуны өмчийн зохиогч, эрх эзэмшигчдийг хохироохоос гадна тухайн бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэж буй олон зуун хэрэглэгчийн эрх, эрүүл мэндийг давхар хохироогоод зогсохгүй эдийн засгийн асар их хохирол дагуулж байдаг.

Мөн агаарын тээвэр болох нисэх онгоцны тоног төхөөрөмж, авто машины сэлбэг, хэрэгсэл, хүнс, эм, эмийн бүтээгдэхүүнийг

хулгайгаар дуурналган хийх нь ард түмний эрүүл мэнд, аюулгүй байдалд ихээхэн сөрөг нөлөөтэй байдаг.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын тооцоолсноор дэлхийн зах зээл дээр худалдаалагдаж байгаа эм, эмийн бүтээгдэхүүний 10 хувийг хуурамч, хууль бусаар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн эзэлдэг гэсэн судалгаа бий. Үүнээс хөгжиж байгаа орнуудын эмийн худалдааны 70 хүртэлх хувийг нь хуурамч эм бэлдмэлүүд эзэлж, хуурамч эм, эмийн бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалт жил бүр нэмэгдсээр байна.

Иймд Монгол Улс шиг нийт эм, эмийн бүтээгдэхүүний 80 гаруй хувийг импортоор авч байгаа улсын хувьд хил, гаалиар оруулж ирж буй эм, эмийн бүтээгдэхүүнд тавих мэргэжлийн болон гаалийн хяналтыг эрчимжүүлэх, оюуны өмчийн эрх, зөрчлийн талаар нийгмийн бүхий л салбар, нийт ард иргэдийн дунд зохих түвшний мэдлэгийг төлөвшүүлэх шаардлагатай юм.

Дээрхи зөрчил, гэмт хэргийн учир шалтгааныг тодорхойлож, түүнээс урьдчилан сэргийлэх, гэмт үйлдлийг таслан зогсоох, хууль бус, хуурамч бараа бүтээгдэхүүнээс хэрэглэгчид, ард түмнийг хамгаалах үүднээс оюуны өмчийн эрхийг хамгаалах зайлшгүй шаардлагатай байдаг.

Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй холбоотой хууль бус үйлдэл, үйл ажиллагаанууд нь зарим тохиолдолд гэмт хэргийн шинжтэй байдгийг улс орнууд эрүүгийн хуулиндаа зааж өгсөн байдаг. Монгол Улсын Эрүүгийн хууль, Иргэний хууль, Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Гаалийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хуулиудад оюуны өмчийн зөрчил, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг таслан зогсоох, хариуцлага ногдуулах эрх зүйн зохицуулалт бий. Мөн оюуны өмчийн бие даасан шүүхийн тогтолцоотой хөгжингүй улс орнууд ч бий.

Түүнчлэн олон оронд зохиогчийн эрх болон аж үйлдвэрийн өмчийн эрхийн зөрчлөөр дагласан шүүх ажилладаг байна. Жишээ нь: Европийн холбооны улсуудад 2013 оноос эхлэн 25 улсын

гишүүнчлэлээс бүрдсэн Нэгдсэн патентын шүүх /Unified Patent Court/ гэсэн тогтолцоо, Япон улсад 2005 оны 04 дүгээр сарын 01-нд Оюуны Өмчийн Дээд Шүүх /Japanese IP High Court/, ОХУ-д 2011 онд Оюуны Өмчийн Шүүх /Intellectual Property Court/ бий болж 2013 оны 07 дугаар 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлээд байна.

Оюуны өмчийн бие даасан шүүх нь оюуны өмчийн эрхийн зөрчил гарсан эсэхийг тогтоох, ямар төрлийн зөрчил болохыг тодорхойлох, уг зөрчлөөс учирсан хохирлын цар хэмжээ, ногдуулах шийтгэлийг тогтоодог байна.

Оюуны өмчийн эрхийг хамгаалах тогтолцооны хувьд олон улсад АНУ-ын Гаалийн байгууллага, Японы Гаалийн байгууллагууд ихээхэн үүрэгтэй ажилладаг. АНУ, Япон улсын гаалийн байгууллагуудад оюуны өмчийн чиглэлээр мэргэшсэн гаалийн ажилтан байх ба тэд хил, гаалиар орж ирж буй бүх бараа бүтээгдэхүүнд хяналтыг хэрэгжүүлдэг. Нэг үгээр хэлбэл тухайн бараа бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, хэлбэр хийц, дизайны зэрэгт зөрчил байгаа эсэхийг /хуурамч/ нарийн чанд тодорхойлж хяналтыг хэрэгжүүлдэг. Японы гаалийн мэдүүлэх хуудасны хориотой бараа бүтээгдэхүүний жагсаалтад "Оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараа бүтээгдэхүүн" гэсэн заалт орсон байдаг бол АНУ-ын гаалийн байгууллага "Оюуны өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан"-тай. Энэ мэдээллийн санд зохиогчийн эрхийн бүтээл, бараа бүтээгдэхүүн, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл... гэх мэт аж үйлдвэрийн өмчөөр хамгаалуулсан патент, гэрчилгээг үндэслэн зохиогч, эрх эзэмшигчийн хүсэлтээр дэлгэрэнгүй мэдээллийн санг бий болгосон байдаг. Нэг үгээр хэлбэл энэхүү бүртгэлийн системийг ашиглаж хил, гаалиар оруулж буй бараа, бүтээгдэхүүний эрх эзэмшигч нь хэн болох, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загварын /сав баглаа боодлын хэлбэр, хийц, загвар/ зөрчил байгаа эсэхэд хяналт шалгалт хийж зөрчлийг илрүүлнэ гэсэн үг юм. Жишээ болгож Япон Улсын JETRO байгууллагаас гаргасан оюуны өмчийн зөрчилтэй /хуурамч/ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч улс орнуудын талаарх

судалгааг үзүүлбэ.

Дэлхийн улс орнуудад оюуны өмчийн эрхийн зөрчил, гэмт хэрэгтэй Эрүүгийн, Иргэний, Захиргааны журмаар тэмцэж, шийдвэрлэдэгтэй нэгэн адил Монгол Улсад оюуны өмчийн хяналтын тогтолцоо бий болсон. Үүнд:

Монгол Улсын оюуны өмчийн хяналтын тогтолцоо:

Төрийн байгууллагын тогтолцоо:

- Шүүх эрх мэдлийн байгууллага /шүүх, прокурор, мөрдөн байцаах, хэрэг бүртгэх/
- Гаалийн байгууллага
- Оюуны өмчийн газар
- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө байгууллага
- Мэргэжлийн хяналтын байгууллага
- Хуулиар харъяалуулсан бусад байгууллага
- Иргэний нийгмийн байгууллага:
- Хамтын удирдлагын байгууллага /Зохиогчийн эрхийн салбарт/
- Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөллийн байгууллага
- Төрийн бус байгууллагууд гэх мэт

Оюуны өмчийн газраас хэрэгжүүлж буй захиргааны хяналтын статистик үзүүлэлтээс үзэхэд сүүлийн жилүүдэд нийгмийн харилцаа асар хурдацтай хөгжиж, аж үйлдвэр, зохиогчийн эрхийн бүхий л салбарт хүний бүтээлч сэтгэлгээ, оюун ухаан, мэдлэг боловсрол улам өргөжин тэлж байгаатай уялдан оюуны өмчийн эрхийн зөрчил, хэрэг маргаан өсөх хандлагатай байна. Тухайлбал: Зохиогчийн эрхийн салбарт дуу, хөгжим, кино урлагийн бүтээл, шинжлэх ухаан, утга зохиолын бүтээлийг зохиогч, эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй хуулбарлан хувилан олшруулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох телевиз, интернетийн орчинд байршуулах, түгээх зөрчил дийлэнх хувийг эзэлж байна. Зохиогчийн эрхийн зөрчилд орчин үеийн техник, технологийн үсрэнгүй хөгжил сөргөөр нөлөөлөх боллоо. Дижитал технологи хөгжсөн нь зохиогчийн эрхийн бүтээл туурвигчдын бүтээлийг /кино, дуу хөгжим, шинжлэх ухаан, утга зохиол, гэрэл

зураг, дүрслэх урлагийн бүтээл, программ хангамж/ хуулбарлах, олшруулахад хялбар болсон ба хил хязгааргүй интернетийн орчинд бүтээлийг түгээх цар хүрээ нэмэгдэж, зохиогчийн эрхийн салбарын бизнесийн уламжлалт хэв маягийг үндсээр нь өөрчилж байгаа явдал юм.

Харин Аж үйлдвэрийн өмчийн салбарт эрхийн хамгаалалт хийгдсэн гадаадын болон үндэсний бараа, үйлчилгээний /brand, logo, TM-trademark/ тэмдэг эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эрхийг зөрчиж бараа, үйлчилгээний тэмдгийг шууд болон ижил, төсөөтэйгээр авч ашиглах, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчийн эрхийг /бараа, бүтээгдэхүүний хэлбэр, хийц, өнгө, дизайн/ зөрчсөн зөрчил давамгайлж байна.

Ингээд Оюуны өмчийн газраас захиргааны журмаар шийдвэрлэсэн зөрчлийн талаарх статистик судалгааг үзүүлье.

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Нийт /2000-2012 он/
1.	Хийсэн хяналт шалгалт	Нийт хийсэн хяналт шалгалт	Тоо	4601
		Хамрагдсан байгууллага /давхардсан тоогоор/	Тоо	3781
		Хамрагдсан иргэн /давхардсан тоогоор/	Тоо	866
		Илэрсэн зөрчил	Тоо	3664
2.	Алсан арга хэмжээ	Торгуулийн хэмжээ	Төг (₮)	231 565 000,0
		Хураан алсан зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн	Төг (₮)	381 416 647,0
		Материалыг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн	Тоо	25
		Материалыг шүүхэд шилжүүлсэн	Тоо	22

Дээрхи үзүүлэлтээс үзэхэд Оюуны өмчийн газраас хийсэн нийт хяналт шалгалтын 80% нь зөрчилтэй байсан ба оюуны өмчийн үндсэн хоёр салбар болох Аж үйлдвэрийн өмчийн эрхийн зөрчил 64%, Зохиогчийн эрхийн зөрчил 36%-ийг эзэлж байгаа боловч нарийвчлан авч үзвэл барааны тэмдгийн зөрчил дангаараа нийт зөрчлийн 34%-ийг эзэлж байгаа нь анхааруштай асуудал юм.

Өөрөөр хэлбэл олон улсад гарч буй оюуны өмчийн эрхийн зөрчлийн 50% гаруйг барааны тэмдгийн зөрчил эзэлдэг судалгаатай манай улсад гарч буй барааны тэмдгийн зөрчлийн хувь адилхан байна гэсэн үг юм. Иймд бизнес эрхлэгч иргэд, байгууллага зах зээлд өөрсдийн бараа бүтээгдэхүүний нлэрхийлэл, толь болж буй бараа, үйлчилгээний тэмдэг, тэдгээрийн бүтээгдэхүүний загварт анхаарлаа түлхүү хандуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахад анхаарлаа хандуулах цаг болжээ.

Мөн Оюуны Өмчийн Газарт оюуны өмчийн эрхийн талаар гарч буй зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдлын тоон үзүүлэлтийг авч үзвэл 2000 онд 11 байсан бол, 2001 онд 51, 2002 онд 137, 2003 онд 127, 2004 онд 155, 2005 онд 235 болж өссөн байна. Энэ нь өөрийн оюуны бүтээлийг жинхэнэ утгаар нь өмч хэмээн ойлгож, ач холбогдол өгч түүнийг зах зээлийн эргэлтэнд оруулж, үр шимийг нь хүртэх болсонтой холбоотой юм.



ТУЛГАМДСАН АСУУДАЛУУД:

1. Юуны өмнө бидэнд тулгарч байгаа асуудлын нэгдүгээрт аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрхийн салбарт оюуны бүтээл туурвиж буй шинийг санаачлагч, зохион бүтээгч, зохиогч, уран бүтээлч, бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн бүтээсэн аливаа бүтээлд оюуны өмчийн эрхийн хамгаалаат хийлгэх/шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, газар зүйн заалт, зохиогчийн

эрх/ асуудал хангалтгүй байгаа явдал юм.Тодруулж хэлбэл Та өөрийн хүүхдийг төрсөний дараа эцэг, эх болсоноо улсдаа бүртгүүлж, төрсний гэрчилгээ авч баталгаажуулдагтай нэгэн адил таны санаж, сэдэж, хийж бүтээсэн оюуны бүтээл таны оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэхгүйгээр таны өмч болж чадахгүй гэсэн үг юм. Олон улсад та бүхий л салбарт шинийг санаачилж бүтээсэн бүтээлээ тухайн орныхоо болон олон улсын оюуны өмчийн байгууллагуудад бүртгүүлж, эрхийн хамгаалалт хийлгэж патент, гэрчилгээ авсаны дараа зах зээлийн эргэлтэнд оруулдаг. Энэ нь цаашид үүдэн гарах зохиогч, эрх эзэмшигчдийн хооронд үүсч болох маргаан, хуурамч бараа бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлэгдэхээс урьдчилан сэргийлэх, оюуны бүтээлээ лиценз, франчайзингийн гэрээгээр ашиглуулахад ач холбогдолтой юм.

2. Оюуны өмчийн салбарт тулгарч буй өөр нэг асуудал бол орон нутагт холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа дутагдалтай байгаа асуудал юм. Орон нутаг, аймгуудад оюуны өмчийн асуудал хариуцсан албан тушаалтан, төрийн бус байгууллага байхгүй байгаа нь оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийх, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд учир дутагдалтай байна.
3. Нийгмийн харилцаанд гарч буй шинэ шинэ харилцаатай уялдан оюуны өмчийн салбарын хууль, тогтоомжийг шинэчилэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарч байна. Жишээ нь: Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагын "Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр" -т /TRIPS Agreement/ 1997 онд нэгдэн орсон боловч "Гаалийн тухай хууль" 2008 оны 5 дугаар сарын 20-ны өдөр шинэчилэн найруулагдаас өмнө манай улсын хил, гаалиар орж, гарч буй оюуны өмчийн эрхийн зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг саатуулж, хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах хууль зүйн тогтолцоо байсангүй. УИХ-аас 2008 онд баталсан "Гаалийн тухай хууль" -"Оюуны өмчид хамаарах дэд бүлэг" -тэй болж эрх зохицуулалт бий болсон ч дахин ТРИПС-ийн хэлэлцээрийн

- хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа юм.
4. Дараагийн асуудал бол дээр дурьдсан оюуны өмчийн хяналтыг хэрэгжүүлэхэд эрх бүхий төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллагын хоорондын уялдаа холбоог сайжруулж, хэрэгжүүлэх субъект болох шүүх эрх мэдлийн байгууллагын амьтлан /шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч/, гаалийн улсын байцаагч, өмгөөлөгч, хуулиар эрх олгосон улсын байцаагч нарыг оюуны өмчийн чиглэлээр мэргэшүүлэх зайлшгүй шаардлагатай байна.



Ж.БЯМБАА

*Шилхихутуг ХЗДС-ийн төр, эрх зүйн
онол, түүхийн тэнхмийн эрхлэгч.*

Хууль зүйн ухааны доктор /Ph.D./, Профессор

ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙГ ЗӨРЧСӨНӨӨС УЧИРСАН ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ ЗАРИМ АСУУДАЛ

1.1. Оюуны өмчийн эрхийн хамгаалалтын тухай

Орчин цагийн хөгжлийн чиг хандлагаас ажиглахад хүнд үйлдвэр, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг гол зорилтоо болгосон эдийн засаг нь Оюуны өмч дээр тулгуурласан бүтээлч эдийн засагт байр суурин алхам бүр алдаж байна. Чухамдаа хүний бий болгож байгаа баялаг, эдийн засгийн бүхий л хүрээнд, тухайлбал үйлдвэрлэлийн салаа мөчир бүрт үзүүлэх үр нөлөөгөөрөө Оюуны өмч дээр тулгуурласан эдийн засаг нь өрсөлдөөн бүрт ялан дийлсээр байна.

Өөрөөр хэлбэл, мэдлэг болон тэргүүний техник, технологи дээр тулгуурласан хөгжингүй эдийн засаг нь биеийн хүч, гар урлал, боловсруулах үйлдвэр дээр түшиглэсэн хөгжиж буй эдийн засгаас туйлын төдийгүй харьцангуй утгаараа ил давуу гэдэг нь харагдсаар байна.

Ер нь аль ч улс орны хувьд өөрийн үйлдвэрлэл, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, бүтээлч болгоход оюуны өмч, түүний хамгаалалт чухал ач холбогдолтой. Ийм ч учраас хөгжингүй болон хөгжиж буй эсэхээс үл хамааран дэлхийн улс орнууд оюуны өмчийг дээдлэхийн зэрэгцээ түүний хамгаалалтад ихээхэн анхаардаг болсон нь зүй ёсны хэрэг юм.

Оюуны өмчийн эрхийг жинхэнэ утгаар нь хамгаалахгүй бол оюуны өмчийг шинээр бүтээх нь бүү хэл тэргүүний техник, технологийг импортлон оруулж ирэхэд ч хүндрэл бэрхшээл учирч таарна.

Монгол улсад хувийн өмчийг хүлээн зөвшөөрч хамгаалдаг болсоор 20 гаруй жилийн нүүр үзлээ. Энэ хутагаанд хувийн өмчийн бүхий л төрөл хэлбэр, түүний дотор оюуны өмчийг хамгаалахтай уялдсан эрх зүйн зохицуулалтын ямар ч бай, өөрийн гэсэн тогтолцоотой боллоо.

Тухайлбал, Оюуны өмчийн эрхийг баталгаажуулах зорилгоор олон улсын хэд хэдэн гэрээ конвенцуудад нэгдэн орчон бөгөөд Зохиогчийн эрх, Патент, Бүтээгдэхүүний загвар, Технологи зэрэг бүхий л төрөл чиглэлээр бие даасан хуулиудтай болсон нь яах аргагүй дэвшилтэт алхам юм.

Үүний зэрэгцээ, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Захиргааны хариуцлагын тухай хуулиудад оюуны өмчийн эрхийг хамгаалах тодорхой зүйл заалтуудыг тусган хэрэгжүүлж байгааг дурьдах нь зүйтэй биз.

1.2. Оюуны өмчийн зөрчигдсөн эрхийг хамгаалах иргэний эрх зүйн арга, хэлбэрүүд:

Энэ илтгэлд Оюуны өмчийн эрхийн зөрчлийн улмаас учирсан гэм хорыг арилгах асуудлыг тусгайлан авч үзэх оролдлого хийсэн юм. Уг зөрчлийн улмаас учирсан гэм хорыг арилгах асуудлыг жичлэн хөндөхдөө оюуны өмчийн эрхийг хамгаалах иргэний эрх зүйн бусад үндсэн аргуудыг, оюуны өмчийн эрхийн зөрчилтэй холбоотой зөрчил маргааныг шийдвэрлэх ажиллагаатай тус тус уялдуулан авч үзэхийг хичээв.

Сэдвийн хүрээнд оюуны өмчийн эрхийн хамгаалалтанд Иргэний эрх зүйн нийтлэг аргуудыг хэрхэн ашиглаж байгааг харуулахад:

- а) эрх хүлээн зөвшөөрүүлэх,
- б) эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, урьдах байдлыг нь буцаан сэргээх,
- в) учруулсан хохирлыг арилгуулах,
- г) бусад арга.

Дурьдсан аргууд өөр хоорондоо харилцан уялдаатай, ихэнх тохиолдолд хам үйлчилдэг онцлогтой. Тухайлбал оюуны өмчийн

эрхийг хүлээн зөвшөөрүүлэх, эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоох шаардлага нь ихэвчлэн хамтдаа тавигддаг бол учруулсан хохирлыг арилгах шаардлага нь эрх зөрчсөн үйлдлээ таслан зогсоохтой салшгүй холбоотой байдаг.

а) эрх хүлээн зөвшөөрүүлэх

Эд хөрөнгөөс оюуны өмчийн ялгагдах шинж нь бодит эзэмшил гэсэн ойлголт байдаггүйд оршино. Ийм учраас эрхээ хамгаалуулах үндсэн зорилго нь өмчлөгчийн эрхээ хүлээн зөвшөөрүүлэхэд оршино.

Эрх хүлээн зөвшөөрүүлэх арга нь өмчлөгчийн эд хөрөнгийн бус болон эд хөрөнгийн онцгой эрхийн аль алинд хамаарч таарна.

Эд хөрөнгийн онцгой эрх эзэмшигчийн эрх нь тухайн бүтээлийг бий болгосноор, эсхүл хөдөлмөрийн гэрээ бүхий этгээд ажил үүргийнхээ дагуу бүтээсэн, өв залгамжилсан, гэрээний дагуу эрх шилжүүлэн авсан зэрэг янз бүрийн байдлаар үүсэж болно. Эрх хүлээн зөвшөөрүүлэхээр нэхэмжлэл гаргаж байгаа хэн боловч дурьдсан аль нэг нөхцөл байдал байна гэдгийг заавалчгүй нотлон харуулах шаардлагатай болно.

б) эрх зөрчсөн үйлдлийг таслан зогсоож, урьдах байдлыг нь буцаан сэргээх,

Оюуны өмчийн эрх зөрчигчийн үйлдэл нь өмчлөгчийн хараа хяналтаас гадуур байдаг онцлогтой. Ямар нэгэн эд хөрөнгө шилжүүлсэнээр, гэрчилгээ эзэмшсэнээр өмчлөгчийн эрх хэрэг дээрээ бүрэн хамгаалагддаггүй. Тиймээс ч бусдын хууль бус үйлдлийг таслан зогсоох, засан залруулж эрх зөрчигчийн өмнөх байдлыг сэргээх шаардлага зүй ёсоор тавигдана. Тухайлбал зохиогчийн эрх зөрчиж ном хэвлэхийг зогсоох, хэвлэснийг нь хурааж авах буюу устгахыг даалгаж болох юм.

в) учруулсан гэм хор, хохирлыг ариугуулах

Оюуны өмчийн эрх зөрчигдсөн үед өмчлөгчид ихэвчлэн төрөл бүрийн гэм хор, хохирол учирч байдаг. Тухайлбал, эд хөрөнгийн бус гэм хор, сэтгэл санааны хохирол учирч болно. Мөн бизнесийн боломж алдагдах, оюуны өмчийн зүйл болох ном, цомог нь зарагдахгүй болох зэрэг янз бүрийн хохирол учирч болзошгүй.


Энэ гэм хор, учирсан хохирлыг заавалчгүй арилгах нь зөрчигдсөн эрхийг сэргээх хамгийн үр нөлөөтэй арга бөгөөд мэдээж цаашдын алдаа, дутагдлаас сэргийлэх чухал ач холбогдолыг агуулдаг.

в) бусад арга

Оюуны өмчийн эрх зөрчсөн хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулах, гэрээ байгуулсан бол түүнд заасан анз төлүүлэх, оюуны өмчийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжид заасан тодорхой шаардлага гаргах /Патентын тухай хуулийн 16.1.5-д зааснаар патент эзэмшигч нь түүний бүтээлийг ашиглаж олсон орлогоос зохих хэмжээний төлбөр авах эрхтэй/, эрх бүхий байгууллагын тусламцааг авах боломжгүй бол өөртөө туслах зэрэг аргуудыг хэрэглэдэг.

1.3. Шүүхэд шийдвэрлэгдсэн хэрэг маргааны талаар

Монгол улсын Дээд шүүхээс гаргадаг шүүн таслах ажиллагааны сүүлийн 5 жилийн мэдэвнээс үзэхэд жилд оюуны өмчийн эрх зөрчсөн тухай 3-6 маргааныг хянан шийдвэрлэдэг юм байна¹.



Энэ мэдээллийг график болгон харуулахад зарим давхцал, эргэлзээ төрүүлэх үзүүлэлт байгаа боловч жилд шийдэгдэж байгаа хэргийн тоо тун цөөн, тэр хэмжээгээр шүүхийн практикийн жишиг үзүүлэлтгүй шахам, тэрч атугай сүүлийн жилүүдэд шүүхэд шийдэгдсэн хэрэг маргааны тоо багасах хандлагатай байна. Шүүхээр шийдвэрлэж байгаа оюуны өмчийн эрх зөрчсөн тухай хэрэг маргааны тоо цөөн атлаа буурч буйг оюуны өмчийн эрхийн зөрчил манайд бага байна гэж өнгөцөөр дүгнэж тайвширч боломгүй санагдана. Тиймээс ч учир шалтгааныг нь нарийвчлан судлаж бодитой дүгнэлт хийх шаардлагатай байна.

1 http://www.supremecourt.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=58&Itemid=127

2011-2013 онд шүүхээр шийдэгдсэн, шүүхийн шийдвэрийн цахим санд бүртгэл бүхий хэрэг маргаантай танилцаж үзэхэд:

- Оюуны өмчийн эрхийг зөрчсөн тухай нийт 8 иргэний хэрэг шийдсэн аж².
- Эдгээрээс 3 нь зохиогчийн эрхтэй холбоотой, 3 нь Патент, ашигтай загвартай холбоотой, 2 нь барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэртэй холбоотой байна.
- Бүх нэхэмжлэлд оюуны өмчийн өмчлөгч болохыг тогтоолох шаардлага тавьснаас 7 шаардлага бүрэн хангагдаж, 1 шаардлагыг хангаагүй.
- Нэг нэхэмжлэлийг хариуцагч хүлээн зөвшөөрсөн тул талууд эвлэрч, нэхэмжлэгч нь хохирол төлүүлэх шаардлагаас татгалзсан.
- 4 хэрэгт Оюуны өмчийн эрх зөрчсөн этгээдээс төлбөр нэхэмжилсэн.
- Оюуны өмчийн эрх зөрчсөн этгээдээс төлбөр нэхэмжилсэн хэргүүдээс зөвхөн 1 нэхэмжлэлийг хэсэгчлэн /14%/ -ийг хангасан, бусдыг нь хэрэгсэхгүй болгосон.
- Дээрх хэргүүдээс 2 хэргийг давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэж 2-ууланг нь хүчингүй болгож анхан шатны шүүхэд буцаасан.

Шүүхийн шийдвэрээс үзэхэд зохиогч, патент, гэрчилгээ эзэмшигч зэрэг Оюуны өмчийн эзэн нь ихэнх тохиолдолд эрх өмчлөгч болохоо хүлээн зөвшөөрүүлж байгаа. Тэгсэн атлаа 50% нь учирсан гэм хорыг арилгуулах шаардлага тавилгүй орхижээ. Үлдсэн тал хувь нь гэм хор, хохирлоо арилгуулах шаардлага тавьсан ч нэхэмжлэлийг нь хангаагүй байна.

Хохирол нэхсэн бүх хэрэгт хохирлын хэмжээг нотлоогүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй байх бөгөөд зөвхөн шинжээчийн дүгнэлт байгаа нэг л тохиолдолд дүгнэлтэд заасан боломжит бага хэмжээг баримталж хохирлыг нь нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

Эндээс анхаарвал зохих асуудлууд нь:

- Нэхэмжлэгч нь тэр бүр хохирол төлүүлэх тухай шаардлага гаргахгүй байна.

2 <http://www.shinakh.mn/>

- Шүүхээс оюуны өмчийн эрхийг хүлээн зөвшөөрдөг боловч нэхэмжлэлийн шаардлагаас хохирол төлүүлэх тухай хэсгийг нь хангахгүй орхигдуулдаг.
- Шүүхийн шийдвэрийг давж заалдахад хүчингүй болгох, анхан шатны шүүхэд буцаах магадлал өндөртэй аж.

1.4. Оюуны өмчийн эрх зөрчсөнөөс учирсан гэм хорыг арилгах арга замууд

Оюуны өмчийн эрхийн зөрчлийн улмаас учирсан хохирлыг хэрхэн арилгах асуудлыг тухайн салбарын хуулиар тусгайлан зохицуулаагүй тул Иргэний хуульд заасан ерөнхий зохицуулалтыг ашиглахаас өөр аргагүйд хүрч байна. Зохиогчийн эрх, Патентын тухай болон Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиудад “эрх эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэсэн заалттай.

Гэтэл Иргэний хуульд оюуны өмчийн эрхийг зөрчсөнөөс учирсан гэм хорыг арилгах асуудлыг тусгайлан зохицуулаагүй аж. Ийм учраас Гэм хор учруулснаас үүсэх үүргийн нийтлэг журмыг баримтлахаас өөр аргагүй.

Монгол улсын Иргэний хуулийн 230.2-т зааснаар гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх бөгөөд 511-р зүйлд зааснаар зөвхөн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх учиртай. Иймд оюуны өмчийн эрхийг зөрчсөн тохиолдолд эдийн бус гэм хорыг арилгах тухай асуудал бараг хөндөгдөх боломжгүй аж.

Иргэний хуулийн 497.1-д зааснаар “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэхүй/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” бөгөөд Оюуны өмчийн эрхийг зөрчсөн этгээд нь энэ журмаар гэм хорыг буюу учирсан хохирлыг нөхөн төлнө.

Иргэний хуулийн дээрх нийтлэг журам, бусад тусгай зохицуулалтыг хэрэглэхэд гэм хор учруулагч нь хууль бус үйлдэл хийсэн, эд хөрөнгийн хохирол учруулсан, түүний хэмжээ

нь нотлогдсон, гэм буруутай үйлдэл болон хохирлын хооронд шалтгаант холбоо тогтоогдсон байх шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, хохирлын хэмжээ нотлогдсон байх нь гэм хорыг арилгах зайлшгүй шалгуур болох хатуу зохицуулалттай.

Хууль бус үйлдэл гэдгийг оюуны өмчийн тухай салбарын хууль тогтоомжоор тусгайлан тодорхойлоогүй бөгөөд үүнийг өмчлөгчийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг зөрчсөн аливаа үйлдэл гэж ойлгож таарна.

1.6. Харьцуулсан судалгаа /Оюуны өмчийн эрхийн зөрчлийн улмаас учирсан гэм хорыг арилгах асуудлаар/

Харьцуулах зүйл	Монгол улсын хууль тогтоомж	Оросын Холбооны улсын хууль тогтоомж	Монгол улсын хуулиас онцлох ялгаа
Хохирол, Гэм хорын тодорхойлолт	Эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Иргэний хуулиар шийдвэрлэнэ. Харин Иргэний хуулийн 229.1 болон 227.5-д заасан тодорхойлолтыг үзвэл хохирол гэдэгт зардал, алдагдал, эд хөрөнгийн гэмтэл, олох байсан орлого зэрэг орно. Хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг хориглосон бөгөөд Оюуны өмчийн эрхийг зөрчсөн тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх зохицуулалт байхгүй	ОХУ-ын Иргэний хуулийн 15.1-д зааснаар эрхийг сэргээхэд гарсан болон гарах зардал, эд хөрөнгө алдагдсан, устсан (бодит хохирол), эрх нь зөрчигдөөгүй байсан нөхцөлд олох байсан орлого зэргийг хохирол гэдэгт оруулсан. Мөн ОХУ-ын Иргэний хуулийн 151.1-д хохирлоос бусад Эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх тухай тусгасан бөгөөд бие махбодь болон ёс суртахууны зовлон шаналалыг эдийн бус гэм хор гэж үзэхээр өргөн агуулгаар тодорхойлсон.	Хохирлын үндсэн тодорхойлолт ижил Олох байсан орлого гэдгийг зайлшгүй олох байсан орлого гэж хатуу заагаагүй. Эдийн бус гэм хорыг арилгах ерөнхий зохицуулалттай тул Оюуны өмчийн эрх зөрчсөн тохиолдолд эдийн бус гэм хорыг нөхөн тууулаах боломжтой

Эрх зөрчсөн этгээдийн гэм буруу нөлөөтэй эсэх	Эрх зөрчсөн этгээдийн гэм бурууг ангилдаггүй. Бүх тохиолдолд нинна харнуудлага хүлээнэ.	Ашиг олох зорилгоор эрх зөрчсөн бол ялуу харнуудлага хүлээлгэнэ.	Оюуны өмчийг ашиг олох зорилгоор ашиглаагүй бол Торгууль төмөх харнуудлага хүлээхгүй бөгөөд харин олсон орлого, эсхүл хохирлыг нотлогдсоны дагуу нөхөн төмөх үүрэгтэй.
Хууль бусаар олсон орлогын хэмжээтэй харьцуулах байдал	Патентын тухай хуулийн 16.15-д зааснаар Патент гэрчлэгээ эзэмшигч нь бүтээлийг нь ашиглаж олсон бусад этгээдийн орлогоос зохих хэмжээний төлбөр авах эрхтэй.	ОХУ-ын Иргэний хуулийн 15.2-т зааснаар Эрх зөрчсөн этгээд орлого олсон бол эрх нь зөрчигдсөн этгээд түүний олсон орлогоос багагүй хэмжээгээр хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй	Хууль бусаар олсон орлогын хэмжээ нь тодорхой бол заавал хохирлын хэмжээг нотлох шаардлагагүй. Хамгийн багадаа хууль бусаар олсон орлоготой тэнцүү хэмжээний нөхөн төлбөр авах боломжтой байна.
Анз торгууль	Хуульд анз, торгууль тусгаагүй	ОХУ-ын Иргэний хуулийн 1301-р зүйлд зааснаар Зохиогчийн эрхийн зөрчсөн бол зохиогч нь хохирол төлүүлэх эсхүл 1000-5000,000 рублийн анз, эсхүл бүтээлийг хуулбарласан үнийг 2 нутагсан хэмжээгээр, эсхүл бүтээлийг нь ашиглахад төмөх ёстой байсан төлбөрийг 2 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгууль төлнө. Шүүгч хэргийн нөхцөл байдлаас хамаарч торгуулийн хэмжээг тодорхойлно.	Хохирол, Хууль бусаар олсон орлогын хэмжээ тодорхойгүй, түүнийг нотлоход хүндэртэй гэж үзвэл шууд торгууль төлүүлэхээр нэхэмжлэл гаргах боломжтой. Шүүгчид хэргийн нөхцөл байдлаас хамаарч торгуулийн хэмжээг тодорхойлох өргөн эрх өгсөн.

1.7. Анхаарч судлах шаардлагатай чиглэл, саналууд

Зохиогчийн эд хөрөнгийн бус эрхийг зөрчиж, зохиол бүтээлийг өөр хүний нэрээр гаргах, хэвлүүлэхэд эд хөрөнгийн хохирол гэхээсээ илүүтэйгээр эд хөрөнгийн бус хохирол учирдаг. Зарчмын хувьд нэр төр, алдар хүндийг нь гутаасан, гүтгэн доромжилсноос төдийлөн ялагамгүй эдийн бус гэм хор учирдаг боловч зохиогч хохирлоо мөнгөөр нөхөн төлүүлэх хууль зүйн зохицуулалт үгүйлэгдэж байна.

Иймд гэм хор учруулснаас үүсэх үүргийн хүрээнд эд хөрөнгийн бус гэм хорыг арилгах асуудлыг судлах хүрээнд зохиогчийн эрхийг зөрчсөнөөс учирч болох эд хөрөнгийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх асуудлыг тусгайлан судлаж оновчтой шийдэлд хүрэх шаардлагатай.

Оюуны өмчийн эрхийн зөрчлийн нэг онцлог нь хохирлын хэмжээг нотлон тогтооход тун хүндрэлтэй. Эрх нь зөрчигдсөн этгээд нь зөрчил гаргагчийн үйлдлийн хэмжээ хязгаарыг нотлох, хууль бус үйлдлээ явуулсан цар хүрээ, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг нь мэдэх боломж тэр бүр байдаггүй. Үүнтэй холбоотойгоор эрх зөрчигдсөн этгээд өөрийн алдагдсан бизнесийн боломжийг ч нотлож чададаггүй.

Иргэний хууль тогтоомж, гэм хор учруулснаас үүсэх үүргийн нийтлэг журам нь хохирлын хэмжээг заавал нотлох шаардлага тавьдаг тул оюуны өмчийн эрхийн зөрчилд шууд хэрэглэхэд түвэгтэй юм. Нэгэнт хохирлын хэмжээг нотлох боломж бараг үгүй тул оюуны өмчийн эрх нь зөрчигдсөн этгээд шүүхэд хандаад хохирлоо төлүүлэх магадлал бага юм.

Иймд гэм хор учруулснаас үүсэх үүргийн хүрээнд оюуны өмчийн эрхийн зөрчилтэй холбоотой асуудлыг тусгайлан зохицуулсан хэм хэмжээ бий болгох, ийм ч учраас цаг алдалгүй нарийвчилсан судалгаа, шинжилгээний ажил хийх шаардлага тулгарч байна.

Манайд шүүхийн жишиг цөөн байгаа нь оюуны өмчийн эрх зөрчигдөхгүй байгаа хэрэг биш бөгөөд хуулийн зохицуулалт нь цаг үеийн шаардлага хангахгүй байгаатай холбоотой байж

болзошгүй. Иймд хууль тогтоомжийн шинэчлэл хийх чиглэлээр судалгаа хийхийн хамт цаашдаа тусгайласан шүүгчийг оюуны өмчийн эрхийн чиглэлээр мэргэшүүлэн бэлтгэх, мэдлэг, чадварыг нь дээшлүүлэхэд байнга анхаарч ажиллах цаг болжээ.

SOME ISSUES RELATED TO REMEDIES FOR TORT CAUSED BY A BREACH OF INTELLECTUAL PROPERTY RIGHTS

Protection of intellectual property rights

In modern world, for any countries, there is a trend toward economic development of which top priority is based on knowledge and leading technique and technology. For this reason, countries worldwide respect intellectual property and emphasize its protection and for Mongolia it is a direction which shall be taken into consideration as well.

For Mongolia, it has been for over 20 years since recognition and protection of private properties. During the period, new law for a sector of intellectual property rights was enacted and several international treaties and conventions were joined.

In addition, it is appropriate to mention that certain provisions on protection of intellectual rights were stipulated in Civil Code, Criminal Law, and Law on Administrative Sanctions.

Court practices

According to the report of legal proceedings for the last 5 years which is prepared by Supreme Court of Mongolia, 3-6 claims related to breach of intellectual property rights are settled in a year⁶⁴.

According to the graphic above, number of litigations settled by a court is very few and there's almost no case law of court practices, moreover, number of litigations being settled by courts tend to decrease. But it seems that we cannot conclude that breaches of intellectual property rights are few due to the fact that small number of claims related to breaches of intellectual property rights are settled by courts.

Also, we have reviewed cases settled by courts in 2011-2013 which are recorded in electronic database of court decisions.

⁶⁴ http://www.supremecourt.mn/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=58&Itemid=127

According to rulings, in most cases (90% of claims), owners of intellectual property including authors, owners of patents and certificates are recognized as the owner of rights. However, 50% of them didn't require remedies for tort. Other 50% percent of them required remedies for tort but only demands of one claim were awarded.

Regulations for remedies for tort caused by breach of intellectual property rights

Basically, remedies for tort caused by breach of intellectual property rights are regulated in accordance with Civil Code of Mongolia.

However, there is no specific provision which regulates remedies for tort caused by a breach of intellectual property rights in Civil Code. Therefore, there is no other way but to adhere to general provisions for obligations arising from tort.

There is a strict rule that in order to use general provisions in Civil Code, remedies for tort must be provided only to the amount of proven losses.

Required directions and proposals for further studies

Special characteristic of breaches of intellectual property rights is that it is difficult to prove amount of loss. Therefore, it prevents from full protection of copyrights and restitution of breached rights in practice when it is brought before a court.

Thus, it is required to set norms which specifically regulate issues related to breaches of intellectual property rights in the frame of obligations arising from tort and conduct detailed studies and works in this direction promptly.

Breaches of non-material rights of authors and publication of copyrighted works by other names cause more non-material harm than material harm. Therefore, it is necessary to study remedies for non-material tort, particularly, compensation for non-material harm to authors.

Few numbers of court precedents don't necessarily mean that there is no breach of intellectual property rights and it is somehow related to inconsistent legal regulations. Thus, it is time to conduct researches on reformation of laws and train judges on intellectual property rights and improve their knowledge and skills.

